- Юнатов А.А. Основные черты растительного покрова МНР //Тр. Монг. Комисс. АН СССР. 1950. М. Л. Вып. 39. 223 с.
- Улзийхутаг Н. Монгол орны ургамлын аймгийн тгойм. Улаанбаатар, 1989. 208 х.
- Beket U. The Vegetation of the Mongolian Altai (Problems of sustainable land use and nature conservation) Bonn-Bad Godesberg. Germany, 2009. 317 p.
- German D.A., Shmakov A.I., Zhang X.-Ch., Chen W.-L., Smirnov S.V., Xie L., Kamelin R.V., Wang J. 2006. Some new floristic finding in Xinjiang, China //Acta Phytotaxonomica Sinica . V. 44. N 5. P. 598-603.
- Global Strategy for Plant Conservation (GSPC), on line. Режим доступа: www.biodiv.org.
- Glowka L., Burhenne-Guilmin F., and Syngé H. (in collaboration with Jeffrey A. McNeely and Lothar Gunding.) A guide to the Convention on Biological Diversity Gland, Switzerland : IUCN--the World Conservation Union, 1994. xii, 161 p.
- Flora of China. Beijing: Science Press, St.-Louis: Missouri Botanical Garden Press, 1994-2005. V. 4, 5, 8, 9, 13, 14, 17, 18, 22, 24.
- Flora Xingjiangensis. Urumqi: Xinjiang Science and Technology and Hygiene Publishing House, 1996. V.6. 670 p.
- Orme C.D.L., Davies R.G., Burgess M et al, 2005. Global hotspots of species richness are not congruent with with endemism or treat. Nature. V. 436. P. 1016-1019.
- Piak A.I., Shaw S.C., Ebel A.L. et al. 2008. Endemic plants of the Altai Mountain country. London: Wild Guides. 320 p.
- Raven P.H., Wilson E.O. A 50-year plan for biodiversity surveys //Science. 1992. V. 258. P. 1099 – 1110
- Shengji P. (1996). Biodiversity resources of Himalayan region. //Floristic characteristics and diversity of East Asian Plants. Proc. of I Internat. Symp. of East Asian plants July 25-27, 1996, Kunming, Yunnan, R.P. China. Ed. Zhang A., Wu S. Beijing, China Higher Educ. Press. P. 440-453.
- Tang Zh., Wang Zh., Zheng Ch. & Fang J. 2006. Biodiversity in China's mountains //Front. Ecol. Environ. Vol. 4. No 7. P. 347-352.
- Yakovlev G.P., Sytin A.K., Roskov Yu.R. Legumes of Northern Euroasia. A checklist. Kew: Royal Botanic Gardens, 1996. 724 p.

**RARE AND ENDANGERED PLANTS OF MONGOLIAN ALTAI
– THE APPROACH TO THE PROBLEM
OF THEIR CONSERVATION**

Olonova¹M. V, U. Beket²

¹Tomsk State University, Russia, 634050, Tomsk, Lenin av., 36.
olonova@green.tsu.ru/ beketu@yahoo.com

Key words: conservation, Important Plant Areas, endemics, Altai

Abstract

Altai Mountain Country is an unique natural object, which is located on the border between different floristic provinces of Boreal and Ancient Mediterranean floristic subkingdoms and the limits of distribution of numerous plants occur here. It is known to be one of the most sufficient centers of biodiversity and endemism of the Northern Asia, so, many plants of Altai need effective measures of protection. The identification of Important Plant Areas, accepted by IUCN, based on clear and consistent criteria, could solve this problem the most effectively. The revealing the endemic plants is the important step of this action. The list of endemic plants of Mongolian Altai consists of 28 species; 99 species – endemic of Altai mountain country as a whole, occurs in Mongolia.

ХӨРСӨН ДЭХ ҮРИЙН НӨӨЦИЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮНГЭЭС (ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАНХ СУМЫН ЖИШЭЭН ДЭЭР)

С. Сүмжидмаа¹, Б. Оюунцэцэг²

¹МУИС, ББС, Экологийн тэнхим, sunjee_0515@yahoo.com

²МУИС, ББС, Ургамал судлалын тэнхим, Улаанбаатар 46, ш/х 377. oyuntsetseg@biology.num.edu.mn

Хураангуй

Энэхүү өгүүлэлд Хөвсгөл аймгийн Ханх сумын нутагт орших Далбай болон Турагийн хөндийн ургамлын бүлгэмдлээрээ ялгаатай гурван орчны хөрсөн дэх үрийн нөөцийн судалгааны зарим үр дүнг тусгав. Далбайн хөндийн хөрснөөс 202 үр, Турагийн хөндийн хөрснөөс 39 үр нийт 241 үр илэрсэн бөгөөд энэхүү ялгаа нь мал бэлчээрлэлт болон ургамлын зүйлийн баялагтай холбоотой.

Нийт 241 ш үрийн 199 ш үр нь нугаас олдсон ба нуга ургамлын зүйлийн бүрдлээр баялаг, салхиар болон урсацаар үр хуримтлагдах боломж ихтэй орчин юм. Хөрсөн дэх нийт 242 ш үрийн 223 нь 0-5 см-ийн гүнд агуулагдаж байсан учир аливаа газрын хөрсөн дэх үрийн нөөцийг судлахдаа энэхүү гүнээс дээж авч ашиглах боломжтой гэж үзэж байна.

Хоёр гүний дээжнээс ургасан цухуйцын тоогоор ялгаатай ($P=0,0123$) энэ нь 0-5 см-ын гүнд амьдрах чадвар сайтай үрнүүд хадгалагдаж байдагтай холбоотой.

Зангилаа үг: үрийн нөөц, үрийн тоо, хөрсний гүн, үрийн морфологи

Оршил

Үрийн нөөц гэдэг нь хөрсөнд байгаа амьдрах чадвар бүхий үрийн нөөцийг хэлнэ (Simpson et al, 1989). Үрийн нөөцийн экологийн тухай ойлголт нь ургамлын бүлгэмдлийн хөгжил түүний хөдлөл зүйг тайлбарлахад гол түлхүүр болдог (Roberts, 1981). Учир нь тодорхой цаг хугацааны дараа үрийн нөөцөөс шинэ бодгаль ургамлууд ургах үйл явц нь тухайн газрын ургамалжилтын бүрэлдэхүүн, хөдлөл зүйд чухал үүрэг гүйцэтгэдэг (Baker, 1989).

Хөрсөнд агуулагдах үрийн нөөцөд гадаад болон дотоод олон хүчин зүйл нөлөөлдөг ба юуны өмнө газрын дээрх ургамалжилтыг (Shaukat, 2003) судалдаг. Мөн чийг, гэрэл (Erenler et al, 2010) гэх мэт орчны хүчин зүйлийг ихээхэн судалдаг. Сүүлийн үеийн судалгаанд үрийн нөөцөд үзүүлэх мал бэлчээрлэлтийн нөлөөг (Bakoglu et al, 2009; Chaideftou et al, 2008), судлах хандлага нэмэгдсэн.


Хөрсөн дэх үрийн соёололтын талаар (Alyemeni, 2002), хотжилтын улмаас хөрсний үржил шим өөрчлөгдсөнөөр ургамалжилт болон хөрсний үрийн нөөцөд ямар нөлөө үзүүлэх талаар (Pellisier et al, 2008), хөрсний босоо чиглэл дэх үрийн тархалтад үрийн хэлбэр, хэмжээ нөлөөлдөг талаар (Manuel, 2002) судалсан байна.

Хөвсгөл аймгийн Ханх сумын нутагт орших Хөвсгөл нуурын зүүн эрэг орчмын Далбай, Турагийн хөндийн хөрсөн дэх үрийн нөөцийг судлах зорилго тавьсан. Дараах зорилтуудыг тавьж ажилласан. Үүнд тухайн газрын ургамалжилтын бичиглэлийг хийх, үрийн нөөцийн судалгаанд ашиглах үрийн эталон бэлтгэн зургийг авч морфологийн хэмжилт хийх, хөрсний чийгийг хэмжих, үрийн тоог гаргах, цухуйцын судалгаа хийж хөрсөнд агуулагдаж буй

үрийн амьдрах чадварыг шалгах зэрэг болно. Мөн үрийн тоо хоёр хөндий, амьдрах орчин ба хөрсний гүнд ялгаатай ба хөрсөн дэх үрийн нөөц нь хөрсний чийг болон ургамлын зүйлийн баялагтай хамааралтай гэсэн таамаглал дэвшүүлсэн.

Судалгааны материал ба арга зүй

Хээрийн судалгааг Хөвсгөл аймгийн Ханх сумын нутагт орших Хөвсгөл нуурын зүүн эрэг орчмын Далбай болон Тураг голын хөндийд 2008 оны 7-р сарын 28-наас 2008 оны 8-р сарын 15-ны хооронд Америк-Монголын хамтарсан “Уур амьсгалын өөрчлөлт ба хүний үйл ажиллагааны экологи, эволюцийн үр дагавар” төслийн хүрээнд хийсэн.



1-р зураг. Судалгааны хөндийнүүдийн байршил

2-р зураг. Амьдрах орчнууд

Эдгээр хөндийнүүдийн дундаж өндөршил далайн түвшнээс дээш 1700 м, геоморфологийн хувьд хоорондоо төстэй. Мал бэлчээрлэлтийн эрчмээрээ ялгаатай буюу Далбайн хөндий харьцангуй бага харин Турагийн хөндий талхлагдсан болно.

Судалгааны талбайн хөрс

1-р хүснэгт. Амьдрах орчнуудын доминант ургамлын зүйлүүд

Хөндий	Далбай	Тураг
Амьдрах орчин		
Уулын энгэр	<i>Festuca lenenis</i> , <i>Thymus gobicus</i> , <i>Pulsatilla multifida</i>	<i>Thymus gobicus</i> , <i>Poa attenuate</i> , <i>Potentilla sericea</i> , <i>Agropyron cristatum</i>
Уулын бэл	<i>Carex pediformis</i> , <i>Elymus chinensis</i> , <i>Carex dichroa</i> , <i>Festuca ovina</i>	<i>Koeleria macrantha</i> <i>Potentilla acaulis</i> <i>Carex duriuscula</i>
Нуга	<i>Bromus inermis</i> , <i>Carex melananthiformis</i> , <i>Carex stenocarpa</i> , <i>Polygonum viviparum</i>	<i>Carex duriuscula</i> , <i>Carex melananthiformis</i> , <i>Iris lactea</i> , <i>Leontopodium leontopodioides</i>

Хөвсгөл нуурын зүүн хэсгийн бэлчээрийн үндсэн хэв шинжийн хөрс нь хүрэн хөрс болно. Уулын хээр зонхилсон, өвөр хажуугаар карбонатгүй хар хүрэн хөрс тогтворжино. Энэ хөрс нь 25 см зузаан ялзмагт давхрагатай, үржил шим дунд зэрэг, механик бүрэлдэхүүн элсэнцэр, элсэн фракцийн хэмжээ 70-80%-д хүрнэ (Annual report, 2006).

Газрын дээрх ургамлын зүйлийн бүрдэл

Ургамал-газарзүйн мужлалын хувьд Евроазийн муж, Дорнод Сибирийн уулын тайгын хошуу, Хөвсгөлийн уулын тайгын тойрогт хамаардаг. 886 зүйл гуурст ургамал бүртгэгдсэний дотор 768 зүйл өвслөг 118 зүйл модлог сөөглөг ургамал бүртгэгдсэн байна. Эндээс харахад ургамлын амьдралын хэлбэрийн хувьд олон наст өвслөг ургамлын хэлбэр давамгайлдаг (Өлзийхутаг, 1989).

Судалгааны хугацаанд Раменскийн тор ашиглан нийт 48 удаагийн геоботаникийн бичиглэл хийсэн болно. Үүний үр дүнд Далбайн хөндийд 22 овгийн 69 зүйл, Турагийн хөндийд 19 овгийн 53 зүйл ургамал бүртгэгдсэн. Үүнээс уулын энгэрт 13 овгийн 31 зүйл, уулын бэлд 16 овгийн 31 зүйл, нугад 18 овгийн 40 зүйл ургамал буюу зүйлийн тоогоороо Турагийн хөндийн уулын энгэр 32, нуга 47 бол Далбайн хөндийн уулын бэл 31 зүйл буюу хамгийн олон байна.

Хөрснөөс үрийн нөөцийн дээж авах

Далбай болон Турагийн хөндийн уулын энгэр, уулын бэл, нуга гэсэн гурван амьдрах орчноос тус бүр 4 давталттайгаар хөрсний 0-5 см ба 5-10 см-ийн гүнээс хөрсний дээж авсан. Хөрснөөс дээж авах багаж 5 см голчтой, 5см өндөртэй ба дээжийг даавуу уутанд хадгалсан.

Нэг амьдрах орчноос 8, нэг хөндийгөөс 48 нийт 96 удаагийн хөрсний дээж материал дээр ажилласан болно.



3-р зураг хөрснөөс дээж авах багаж



4-р зураг хөрсний чийг хэмжих багаж

Хөрсний чийг хэмжих

Хөрсний чийг хэмжих TDR багаж ашиглан дээж авсан цэг бүрийн 12 см дэх гүний хөрсний чийгийг хэмжсэн.

Судалгааны хугацаанд 17 овгийн 50 зүйл ургамлын үрийн эталон бэлтгэсэн.

Лабораторын судалгааг 2008 оны 9 сарын 1-ээс 2008 оны 12-р сарын 1-ны хооронд Монгол Улсын Их Сургуулийн, Биологи, Биотехнологийн

сургууль, Экологийн тэнхмийн лабораторид хийсэн.

Энэ хугацаанд бэлтгэсэн үрийн эталонуудын зургийг авч морфологийн бичиглэлийг хийсэн. Том хэмжээтэй үрнүүд *Allium leucocephalum* урт 907.04 мкм, өргөн 385.8342 мкм, *Allium senescens* урт 849.472 мкм өргөн 398.647 мкм *Allium schoenoprasum* урт 699.030 мкм өргөн 283.302 мкм, жижиг үр *Veronica incana* урт 146.0137 мкм, өргөн 91.7606 мкм байв (1-р хүснэгт).

2-р хүснэгт. Зарим зүйл ургамлын үрийн урт ба өргөний хэмжээ

Д/Д	Зүйлийн нэр	Урт (мкм)	Өргөн (мкм)
1	<i>Achillea asiatica</i>	719.602	178.404
2	<i>Allium bidentatum</i>	740.780	521.451
3	<i>Allium leucocephalum</i>	907.04	385.834
4	<i>Allium senescens</i>	849.472	398.647
5	<i>Allium schoenoprasum</i>	699.030	283.302
6	<i>Campanula Turczaninovii</i>	538.624	194.257
7	<i>Campanula glomerata</i>	445.313	220.290
8	<i>Dianthus versicolor</i>	583.168	380.360
9	<i>Galium verum</i>	386.264	239.081
10	<i>Geranium pratense</i>	579.834	298.563
11	<i>Hedysarum inundatum</i>	550.000	348.000
12	<i>Iris flavissima</i>	885.302	416.125
13	<i>Melandrium apricum</i>	262.366	195.816
14	<i>Oxytropis myriophylla</i>	525.589	443.927
15	<i>Oxytropis strobilacea</i>	502.063	458.004
16	<i>Oxytropis glandulosa</i>	712.859	300.665
17	<i>Potentilla tanacetifolia</i>	351.294	289.620
18	<i>Potentilla sericea</i>	438.223	300.665
19	<i>Rumex acetosa</i>	827.531	673.631
20	<i>Silene repens</i>	324.826	284.344
21	<i>Schizonepeta multifida</i>	574.344	227.015
22	<i>Scutellaria baicalensis</i>	604.476	420.000
23	<i>Thalictrum minus</i>	719.672	303.486
24	<i>Trollius asiaticus</i>	506.793	382.214
25	<i>Veronica incana</i>	146.013	91.760

Үрийн нөөц судлах арга

Германы эрдэмтэн К.Томсоны (Thompson 1993,1996) арга зүйг ашигласан. Үүнд:

- Шигшүүр дээр угаах
3мм, 2мм, 1мм, 0,45мм голчтой шигшүүр дээр хөрсийг угааж шигшүүр тус

бүрээр үрийг бинокуляр ашиглан ялгаж авна.

- Үрийн тал судлах буюу шууд тарих

10*16*2 см хэмжээтэй пластик саванд хөрсийг 1-1,5 см зузаантайгаар тараан байршуулж тасалгааны нөхцөлд ургуулан цухуйцыг тоолсон болно.



5-р зураг шигшүүр ашиглан үрийг ялгах



6-р зураг Цухуйцын судалгаа

Судалгааны үр дүн ба хэлэлцүүлэг

Хөрсөн дэх үрийн нөөц

Далбайн хөндийн хөрснөөс 202 үр, Турагийн хөндийн хөрснөөс 39 үр нийт 241 үр илэрсэн. Далбайн хөндийн 202 үрний 3 үр уулын энгэрээс, 23 үр уулын бэлээс, 176 үр нугаас, Турагийн хөндийн хөрснөөс 39 үрний 3 үр уулын энгэрээс, 13 үр уулын бэлээс, 23 үр нугаас олдсон (1-тахирмаг).

Бидний судалгаагаар хөрсөн дэх үрийн тоо хөрсний чийгтэй $r=0,7327$ гэсэн эерэг хамааралтай байсан ба хөрсний чийг ихтэй орчинд ургамлан бүрхэц өндөр бөгөөд хөрсөн дэх үрийн тоо олон байдаг гэж дүгнэж болох юм. Иймээс хоёр хөндийн хөрсөн дэх үрийн нөөцөөр эрс ялгаатай байгаа нь Тураг болон Далбайн хөндийн мал бэлчээрлэлтийн эрчимтэй холбоотой байж болох юм. Учир нь 2006 оны судалгаагаар Турагийн хөндий хэт талхлагдсан ба уур амьсгалын дулаарлаас болж хөрсний чийгээ алдсан гэсэн үр дүн гарчээ (Annual report. 2006).


Мөн ургамлын цэцэглэлт, үрлэлтийн үе шатанд хэт олон тооны мал бэлчсэнээр ургамлын вегетатив эрхтнийг тасдаж хөрсөнд хадгалагдах үрийн нөөцийг багасгаж болох магадлалтай юм.

Хөрсөн дэх үрийн тоогоороо хамгийн олон амьдрах орчин нуга учир нь ургамлын зүйлийн баялаг болон бүрхэц ихтэй. Мөн салхиар болон урсацаар үр хуримтлагдах боломж хамгийн ихтэй орчин юм.

Хөрсний 0-5 см-ийн гүнд 223 ш үр, 5-10 см-ийн гүнд 39 ш үр хадгалагдаж байв. Урьд хэвлэгдсэн бүтээлүүдэд хөрсний үрийн нөөц дэх үрийн нягтшил хөрсний гүн нэмэгдэх тусам буурдаг гэжээ (Thompson et al, 1997). Мөн Австралид хийгдсэн үрийн нөөцийн судалгаагаар 0-5 см-ийн гүнд үрийн тоо олон байв (Prince et al, 2010). Бидний судалгааны үр дүн дээрх судалгаануудын үр дүнтэй нийцэж байна. Иймээс аливаа газрын хөрсөн дэх үрийн нөөцийг судлахдаа энэхүү гүнээс дээж авч ашиглах боломжтой.


Хөрсний гүнүүд хоорондоо үрийн овор хэмжээгээр ялгаагүй ($P=0,057$) гарсан нь Manuel нарын судалгааны 0-5 см-ийн гүнд жижиг, дунд зэрэг

хэмжээтэй үрнүүд 5-10 см-ийн гүнд жижиг үрнүүд зонхилдог гэсэн үр дүнтэй тохирохгүй байна (Manuel, 2002). Энэ нь дээрх газруудын хөрсний шинж чанар өөр байсантай холбоотой байж болох юм. Учир нь бидний судалгааны талбайн хөрс элсэрхэг бүтэцтэй дээр ялзмагт давхрага 25 см тул үрийн нэвтрэх чадвар сайн харин Manuel нарын судалгааны талбайн хөрс нь элсэрхэг бүтэцтэй боловч чийг ихтэй, нэвчимхий чанар бага, бүтцээр ядмаг гэсэн байна.



1-р тахирмаг. Амьдрах орчнуудын үрийн тоо

2-р тахирмаг. Хөрсний гүнүүд дэх үрийн тоо




3-р тахирмаг. Хөрсний гүн тус бүрийн үрийн овор хэмжээ, тоо

Цухуйц

Далбайн хөндийн дээжнээс 39 цухуйц, Турагийн хөндийн дээжнээс 27 цухуйц нийт 66 цухуйц ургасан. Далбайн хөндийгөөс олон цухуйц ургасан нь мөн эн хөндийн хөрсөнд амьдрах чадвар сайтай олон үр агуулагдаж байсантай холбоотой.

Цухуйцын тоог амьдрах орчноор харьцуулахад 66 цухуйцын 14 цухуйц уулын энгэрийн, 24 цухуйц уулын бэлийн, 28 цухуйц нугын дээжнээс гарсан. Чийг ихтэй орчинд үрийн амьдрах чадвар сайн байх ба нугад хөрсний чийг харьцангуй их мөн ургамлын зүйлийн бүрдлээрээ баялаг, ургамлан бүрхэц ихтэй байсан нь олон тооны цухуйц гарах шалтгаан байж болох юм.

Цухуйцын тоог хөрсний гүнээр харьцуулахад 66 цухуйцын 51 цухуйц 0-5 см-ийн гүний, 15 цухуйц 5-10 см-ийн гүний дээжнээс ургасан (5-р тахирмаг). Хоёр гүний дээжнээс ургасан цухуйцын тоогоор ялгаатай эсэхийг шалгахад ялгаатай гарсан. ($P=0,0123$) Энэ нь 0-5 см-ын гүнд амьдрах чадвар сайтай үрнүүд хадгалагдаж байдагтай холбоотой.



4-р тахирмаг. Амьдрах орчин бүр дэх цухуйцын тоо

5-р тахирмаг. Хөрсний гүнүүд дэх цухуйцын тоо

Дүгнэлт

1. Далбай ба Турагийн хөндий хөрсөнд агуулагдах үрийн нөөцөөрөө ялгаатай байгаа нь эдгээр хөндийн ургамлын зүйлийн бүрдэл болоод мал бэлчээрлэлтийн эрчимтэй хобоотой байж болох юм.
2. Амьдрах орчны хувьд нугаас хамгийн олон үр илэрсэн нь энэхүү орчин ургамлын зүйлийн бүрдэл болон үр хуримтлагдах боломж ихтэй орчин юм.
3. Хөрсний гүн нэмэгдэх тусам үрийн тоо буурч байсан ба 0-5 см-ийн гүнд олон үр агуулагдаж байна.
4. Хөрсийг шууд тарих аргаар судлахад 0-5 см гүнээс олон цухуйц ургасан нь энэ гүнд амьдрах чадвар сайтай үрнүүд хадгалагдаж байдагтай холбоотой.

НОМ ЗОХИОЛ

- Өлзийхутаг Н. 1989. Монгол орны ургамлын аймгийн тойм. УБ. 59-62-р тал
- Al-yemeni N. M. 2002. Germinable soil seed bank of desert plant communities in wadi Al – Ammaria, Riyadh, Saudi Arabia. Kuwait J. Sci. Eng. 29-р тал
- Annual report. 2006. The dynamics of biodiversity loss and permafrost melt in lake Hovsgol National Park, Mongolia. 6-7-р тал
- Baker J. P. 1989. Nature management by grazing and cutting. Kluwer Academic publishers. Dordrecht. 440-р тал
- Bakoglu A. et al. 2009. Seed stocks of grazed and ungrazed rangelands on Palandoken Mountains of Eastern Anatolia. Journal of Food, Agriculture & Environment .7 : 674-678-р тал
- Bekker R. M et al. 1998. Seed size, shape and vertical distribution in the soil: indicators of seed longevity. Functional ecology., 12: 834-842-р тал
- Chaideftou E. et al. 2009. Seed bank composition and above-ground vegetation in response to grazing in sub- Mediterranean oak forests. Plant Ecol, 201:255-265
- Erenler H. E. 2010. Factors determining species richness of soil seed banks in lowland ancient woodlands. Biodivers Conserv 19:1631-1648-р тал

- Harper, J. L. 1977. The Population Biology of Plants. Academic Press, London. 892-894-р тал
- Manuel G. S. 2002. Effect of seed shape and size on their distribution in the soil seed bank. Journal of mediterranean ecology. 4:11-17-р тал
- Pellissier V. 2008. Relationships between soil seed bank, vegetation and soil fertility along an urbanization gradient. Applied Vegetation Science 11: 325-334-р тал
- Price N. J et al. 2010. Comparison of seedling emergence and seed extraction techniques for estimating the composition of soil seed banks. Methods in Ecology & Evolution. 5-6-р тал
- Roberts H. A. 1981. Seed banks in the soils. Advances in Applied Biology. 6: 3-6-р тал.
- Simpson et al . 1989. Seed banks: General concepts and methodological issues. Ecology of Soil Seed Banks. Academic Press, Inc., San Diego. 462-р тал
- Shaukat S. S. 2004. Spatial pattern analysis of seeds of an arable soil seed bank and its relationship with above-ground vegetation in an arid region. Journal of Arid Environments 57: 311-327-р тал
- Thompson K. 1993. Seed size and shape predict persistence in soil. 236-238-р тал
- Thompson et.al .1997 . The soil seed banks of north west Europe: Methodology, density and longevity. Cambridge University Press. 97-100-р тал

SUMMARY SOME RESULTS OF SOIL SEED BANK OF DALBAY AND TURAG VALLEY

¹Sumjidmaa. S, ²Oyuntsetseg. B

¹Department of Ecology, NUM

²Department of Botany, NUM

Key words: seed bank of soil, seed number, soil depth, seed morphology

We had proposed to study soil seed bank of three habitat of Dalbay and Turag valley, located in east shore of Huvsgul lake. 202 seeds of all seeds were found from Dalbay valley and 39 seeds were found from Turag valley. That difference related to the grazing intensity and species richness. 199 seeds were found from riparian because that habitat is more species richness comparing to the others and possibility seeds are accumulated by wind and run off. 223 seeds of all 242 seeds in 0-5 cm of the soil. Therefore we can may use that depth to the soil seed bank study. Two depths of soil had been significant difference of seedling number ($P=0.0123$).

ДОРНОД АЙМГИЙН УРГАМАЛЖЛЫН АНГИЛАА, ЗУРАГЛАЛ, ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

И.Түвшинтогтох¹, Д.Энхмаа¹, Ч.Мөнгөнчимэг¹, Ц.Батцэрэн¹

¹ШУА-ийн Ботаникийн хэрээлэн, Ургамалжлын экологи, ургамлын нөөц судлалын салбар

Хураангуй

Бид энэхүү өгүүлэлдээ 2008, 2009 онд Дорнод аймгийн нутагт явуулсан геоботаникийн судалгааны дүнгээс толилуулж байна. Нийт 208 ширхэг геоботаникийн бүрэн бичиглэл, 950 уут ургацын дээжийг боловсруулан ургамалжлын ангилааг экологи-фитоценологийн зарчимаар үйлдэж, ургамалжлын хэвшинж 3, дэд хэвшинж 7, хэвшил 24, бүлэг эвшил 31-ийг тус тус ялгав. Энэхүү ангилааг үндэслэн Дорнод аймгийн ургамалжлын 1:500000 хэмжээст зургийг зохиов. Тус аймгийн нутагт ой 960,5 км², алаг өвст болон үетэнт нугын хээр -13784,2 км², зүр өвст хээр -12306,8 км², том хялганат хээр -51383,0 км², харганат хээр -1902,5 км², крыловийн хялганат хээр - 3157,1 км², хазаар өвст хээр - 13092,1 км², таанат -3748,6 км², дэрст - 1430,9 км², татмын нуга -5814,0 км², давст хотосын ургамалжил -15146,2 км², элсний ургамалжил- 288,2 км² талбай нутгийг тус тус эзэлж байна. Сүүлийн 30-40 жилд Дорнод аймгийн ургамал нөмрөгт Монгол орны бусад нутгийн адил хуурайших үйл явц эрчимтэй явагдан, доройтож байгааг нотлов. Үүнд: Нугын хээрийн эзлэх талбай 3 дахин багасч том хялганат (*Stipa grandis*) жинхэнэ хээрт шилжиж байна. Жижиг дэгнүүлт үетэн-хялганат (*Stipa krylovii*, *Cleistogenes squarrosa*, *Koeleria macrantha*, *Leymus chinensis*) хээрийн зонхилогч Крыловийн хялганыг Дэрвээн хазаар өвс болон таана түрж, өмнө байгаагүй хазаар өвст хээр /нийт нутгийн 10,64%, таанат хээр /3,05% бий болж байна. Давсаг ургамалжилын эзлэх талбай 2,7 дахин нэмэгдэж, Улаан бударгана (*Reumurea songoricica*), Шар бударгана (*Kalidium gracile*), Орог тэсэг (*Eurotia ceratoides*), таана (*Allium polyrrhizum*) зонхилсон бүлгэмдлүүд тэлсээр байна. Дорнод аймгийн ургамал нөмрөгт үнэлгээ хийхэд өөрчлөгдөөгүй буюу хүний болон бусад гадны нөлөөнд бага өртсөн нутаг 39,95%, дунд өртсөн нутаг 34,51%, доройтсон нутаг 26,51% тус тус байна.

Зангилаа үг: ургамалжил, ангилаа, ургамалжлын зураг, зонхилогч ургамал, *Stipa grandis*, *Cleistogenes squarrosa*, *Allium polyrrhizum*, ургамал нөмрөгийн үнэлгээ

Оршил

Дорнод аймаг нь 123,5 мян ам км нутаг дэвсгэртэй бөгөөд Монгол орны зүүн хязгаарт оршино. Физик газарзүйн мужлалтын хувьд тус аймгийн ихэнх нутаг нь Дорнод Монголын талын их мужид багтах бөгөөд ерөнхийдөө д.т.д 560 – 990 орчим метр өндөртэй ухаа гүвээт талын байдалтайгаараа онцлог юм. Нутгийн зүүн хэсгээр орших Хянганы нурууны салбар уулс нь 1000-1500 метр өндөр өргөгдсөн. Баруун хойд хэсэгт Хэнтийн нурууны захын уулс 1300 м өндөртэй Эрээний нуруу оршино. Аймгийн нутгийн баруун хэсэг нь Хэнтийн нурууны захын намхан уулс толгодтой (Шагдар, 2007). Н.Өлзийхутагийн (1986) Монгол орны ургамал – газарзүйн мужлалаар Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрог, Хянганы нутаг хээрийн тойрог, Дорнод Монголын хээрийн тойрогт тус тус хамаардаг.

Дорнод аймгийн ургамал нөмрөгт нөлөөлөх гол хүчин зүйлс нь цаг уурын өөрчлөгдөл, бэлчээрийн талхлагдал, түймэр байна. Монгол орны бүх нутгаар дунджилсан жилийн дундаж агаарын температур сүүлийн 60 жилд 1,9°C-аар дулаарсан байна (Уур амьсгалын өөрчлөлтөнд сав шим тогтолцоо, мал аж ахуй өртөх, дасан зохицохуй, 2005). Жилийн дулаан улиралд агаарын температур огцом нэмэгдэж байгаа боловч түүнийг дагаад хур тунадас

зохих хэмжээнд өсөж чадахгүй байгаа нь Монгол оронд тохиолдож байгаа хуурайшил, гандалтын гол шалтгаан болно. Монгол орны зүүн бүсэд хур тунадасны бага зэргийн өсөлт нь нийлбэр ууршицын өсөлтөөс 5-6 дахин бага байх юм (Нацагдорж, 2008).

2009 оны байдлаар Дорнод аймаг нийт 1450,7 мянган толгой мал тоологдсон нь улсын нийт малын 3,3% болж байна (Статистикийн бюллетень, 2009). Энэ үзүүлэлт бусад аймгуудтай харьцуулахад өндөр биш ч гэсэн сүүлийн жилүүдэд малчид суурин болон гол горхи зэрэг газрын эрэг хөвөө орчмын бэлчээрийг жилийн дөрвөн улирлын турш тухайн газар нутгийг эргэж сэргэн ургах чадварыг алдагдал нь ашиглаж байна. Сумын төвийн эргэн тойрон 5-10 км, аймгийн төвийн эргэн тойрон 25-40 км-ийн газар нутаг хэт ашиглагдан доройтож жил бүр ургамлын тусгаг бүрхэц буурах, зүйлийн тоо цөөрч, нэг наст болон хог ургамал ихсэж байна (Ариунгэрэл, 2001).

Монгол орны тал хээрийн түймрийн ихэнх хувь нь Дорнод Монголд гарч ургамлан нөмрөг доройтох, хуурайших бас нэг шалтгаан болж байна (Түвшинтогтох, 2005).

Иймд байгаль цаг уур, нийгэм эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн ургамлан нөмрөгт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг илрүүлэн, Дорнод аймгийн нөмрөгийн төлөв байдлыг үнэлэхийг зорилоо.

Судалгааны аргазүй, материал


Бид хээрийн судалгааг 2008 онд Монгол-Оросын хамтарсан биологийн экспедици, 2008-2009 онд Говийн бэлчээр төслийн хүрээнд тус тус явуулж, нийт 208 ширхэг геоботаникийн бүрэн бичиглэл, 950 уут ургацын дээж цуглуулсан. Геоботаникийн бичиглэлийг 10мХ10м талбайд үйлдэж, өвслөг ургамлын арвийг О.Друдегийн хувиараар, сөөгний арвийг бодгалийг тоолох аргаар тус тус тооцож, тусгагийн бүрхэц, өндөр, үзэгдэлзүйн үе шатыг тогтоосон болно. Ургацын дээжийг 2008-2009 онд тус бүр 50 талбайд 10 давталттай 1м голдочтой тойргоос газрын гадаргууд шүргүүлэн хайчлах замаар авсан.

Дорнод аймгийн ургамалжлын том хэмжээст зургийг үйлдэхдээ тус аймгийн физик-газарзүйн зургийн зэрэгцээ 2008, 2009 онуудын 8 дугаар сарын сансрын зурагт боловсруулалт хийх замаар ашигласан болно. Ургамалжлын ангилааг үйлдэхдээ экологи-фитоценологийн зарчмыг баримтлав.



Судалгааны үр дүн

Дорнод аймгийн ургамалжлын ангилаа, зураглал

Бид ургамалжлын ангилааг экологи-фитоценологийн зарчимаар үйлдэж, ургамалжлын хэвшинж 3, дэд хэвшинж 7, хэвшил 24, бүлэг эвшил 31-ийг тус тус ялгав. Энэ ангилааг үндэслэн Дорнод аймгийн ургамалжлын 1:500000 хэмжээст зургийг үйлдсэн ба зургийн таниур нь бүлэг эвшилтэй дүйцнэ. Ургамалжлын зураглал үйлдэхдээ 2008, 2009 онуудын судалгаа явуулсан үеийн сансрын зурагт боловсруулалт хийж, ургамалжлын индексээр 20 анги болгон ангилж, дүнг ашиглав (1-р зураг).



1-р зураг. Дорнод аймгийн 2008-2009 оны 8 дугаар сарын ургамалжлын индекс



2-р зураг. Дорнод аймгийн ургамалжлын зураг

Дорнод аймгийн ургамалжлын зургийн таниур
I.НАМ УУЛС, ЦАВ ТОЛГОДЫН УРГАМАЛЖИЛ

1.1. Ой

1.1.1. Өвслөг ургамалт хус-шинэсэн ба зарим газраа хус-шинэс-нарсан ой (*Larix sibirica*, *Betula platyphylla*, *B.hippolytii*, *Pinus sylvestris*, *Calamagrostis purpurea*, *Geranium pseudosibiricum*, *Anemone crinita*)

1.1.2. Элсний ургамалт нарсан ой (*Pinus sylvestris*, *Ulmus pumila*, *Artemisia halodendron*)

1.1.3. Өвслөг ургамалт хусан ба улиангаран ой (*Betula platyphylla*, *Populus tremula*, *Fragaria orientalis*, *Geranium pseudosibiricum*, *Campanula glomerata*, *Vicia unijuga*)

1.1.4. Сөөг –өвслөг ургамалт манж хусан ой (*Betula mandshurica*, *Spiraea fleuxosa*, *Rhododendron dahuricum*, *Rosa acicularis*, *Crataegus dahurica*, *Lonicera venulosa*, *Viburnum sargentii*, *Lathyrus humilis*, *Fragaria orientalis*, *Dianthus superbus*, *Geranium sibiricum*)

1.2. Нугын болон уулын хээр

- 1.2.1. Алаг өвс-үетэнт уулын хээр (*Koeleria macrantha*, *Festuca lenensis*, *Stipa baicalensis*, *S.sibirica*, *Agropyron cristatum*, *Cleistogenes squarrosa*, *Filifolium sibiricum*, *Polygonum angustifolium*, *Potentilla tanacetifolia*, *Allium anisopodium*, *Gypsophyla dahurica*, *Buplerium scorzonerifolium*, *Artemisia frigida*) зарим газраар алаг өвс-үетэн-ленийн ботуульт (*Festuca lenensis*, *Stipa sibirica*, *S.baicalensis*, *Clematis hexapetala*, *Allium senescens*, *A.anisopodium*, *Buplerium scorzonerifolium*, *Pulsatilla turchaninovii*), Хянганд хялгана-алаг өвс-бутнуурт (*Helictotrichon shellianum*, *Lespedeza dahurica*, *Allium senescens*, *Artemisia frigida*, *Heteropappus hispidus*, *Artemisia macilantha*, *Stipa grandis*, *S.sibirica*)
- 1.2.2. Үетэн-чулуусаг алаг өвст уулын хээр (*Arenaria capillaris*, *Amblynotus rupestris*, *Potentilla leucophylla*, *P.acaulis*, *Filifolium sibiricum*, *Orostachys spinosa*, *Polygonum angustifolium*, *Stellera chamaejasme*, *Festuca lenensis*, *Koeleria macrantha*, *Cleistogenes squarrosa*)
- 1.2.3. Үетэн-алаг өвс-улалжит уулын хээр (*Carex pediformis*, *Filifolium sibiricum*, *Artemisia dracunculus*, *A.freyniana*, *Heteropappus hispidus*, *Serratula centauroides*, *Thalictrum squarrosum*, *Galium verum*, *Stipa baicalensis*, *S.sibirica*, *Bromopsis inermus*)
- 1.2.4. а. Чулуусаг алаг өвс-үетэн-зүр өвст уулын хээр (*Filifolium sibiricum*, *Festuca lenensis*, *Agropyron cristatum*, *Koeleria macrantha*, *Stipa baicalensis*, *Cleistogenes squarrosa*, *Poa attenuata*, *Polygonum angustifolium*, *Saussurea salicifolia*, *Ptilotrichon canescens*, *Buplerium scorzonerifolium*, *Allium tenuissimum*, *A.bidentatum*, *Potentilla leucophylla*, *Orostachys spinosa*, *Artemisia macilantha*, *Lespedeza hedezaroides*, *Leuzea uniflora*)
- 1.2.4. б. Үетэн-баялаг алаг өвс-зүр өвст нугын хээр (*Filifolium sibiricum*, *Allium senescens*, *Polygonum divaricatum*, *Serratula centauroides*, *Buplerium scorzonerifolium*, *Euphorbia pallasii*, *Hemerocallis minor*, *Iris dichotoma*, *Leontopodium leontopodioides*, *Astragalus tenuis*, *Polygala hybrida*, *Trifolium lupinaster*, *Sanguisorba officinalis*, *Festuca sibirica*, *F.lenensis*, *Stipa baicalensis*, *Leymus chinensis*)
- 1.2.5. Алаг өвс-үетэн-түнгэт нугын хээр (*Leymus chinensis*, *Stipa grandis*, *S.baicalensis*, *Bromopsis inermus*, *Agropyron cristatum*, *Carex pediformis*, *Filifolium sibiricum*, *Artemisia frigida*, *Pulsatilla turzaninovii*, *Buplerium scorzonerifolium*, *Allium tenuissimum*, *Allium odorum*, *Hemerocallis minor*, *Lilium bushianum*, *Sanguisorba officinalis*)
- 1.2.6. Гүйлс бүхий алаг өвс –хялганат уулын хээр (*Stipa sibirica*, *S.baicalensis*, *Chamaroides altaica*, *Leontopodium leontopodioides*, *Serratula centauroides*, *Arenaria capillaris*, *Allium senescens*, *Armeniaca sibirica*)
- 1.2.7. Улалж-үетэн-алаг өвст нугын хээр (*Serratula centauroides*, *Sanguisorba officinalis*, *Trifolium lupinaster*, *Galium verum*, *Leontopodium leontopodioides*, *Artemisia macilantha*, *A.freyniana*, *A.gmelinii*, *Polygonum divaricatum*, *Filifolium sibiricum*, *Leymus chinensis*, *Stipa baicalensis*, *S.sibirica*, *Poa attenuata*, *Carex pediformis*)

II.УХАА ГҮВЭЭТ БА ТЭГШ ТАЛЫН УРГАМАЛЖИЛ

2.1. Жинхэнэ хээр

- 2.1.1. Үетэн-алаг өвс-сонгинот (*Allium senescens*, *Allium anisopodium*, *A.odorum*, *A.tenuissimum*, *Serratula centauroides*, *Potentilla tanacetifolia*, *Artemisia frigida*, *A.macilantha*, *Buplerium scorzonerifolium*, *Glycyrrhiza uralensis*, *Stipa grandis*, *Leymus chinensis*, *Cleistogenes squarrosa*, *Agropyron cristatum*) эсвэл алаг өвс-түнгэт (*Leymus chinensis*, *Allium senescens*, *A.odorum*, *A.tenuissimum*, *Hemerocallis minor*, *Thalictrum squarrosum*, *Artemisia macilantha*, *Serratula centauroides*)
- 2.1.2.а. Алаг өвс-үетэн-том хялганат (*Stipa grandis*, *Cleistogenes squarrosa*, *Agropyron cristatum*, *Poa attenuata*, *Stipa baicalensis*, *S.sibirica*, *Leymus chinensis*, *Serratula centauroides*, *Allium tenuissimum*, *A.senescens*, *Artemisia gmelinii*, *Iris dichotoma*, *Saposhnikovia divaricata*, *Artemisia frigida*)
- 2.1.2.б. Үетэн-том хялганат (*Stipa grandis*, *Cleistogenes squarrosa*, *Leymus chinensis*, *Caragana microphylla*, *Potentilla bifurca*, *Haplophyllum dauricum*, *Scutellaria hybrida*)
- 2.1.2.в. Харгана бүхий хазаар өвс-том хялганат (*Stipa grandis*, *Cleistogenes squarrosa*, *Leymus chinensis*, *Agropyron cristatum*, *Caragana stenophylla*, *Carex duriuscula*, *Artemisia frigida*, *Serratula centauroides*, *Leuzea uniflora*)
- 2.1.2.г. Үетэн-агь-том хялганат (*Stipa grandis*, *Artemisia frigida*, *Cleistogenes squarrosa*, *Stipa krylovii*, *Leymus chinensis*, *Agropyron cristatum*)
- 2.1.2.д. Үетэн-харгана-том хялганат (*Stipa grandis*, *Caragana stenophylla*, *Cleistogenes squarrosa*, *Leymus chinensis*, *Ephedra sinica*)
- 2.1.3. Ганц нэг нарс, хайлаас бүхий элсний ургамалтай зүр өвст хээр (*Filifolium sibiricum*, *Euphorbia mandshurica*, *Pimpinella thellungiana*, *Polygonum divaricatum*, *Ulmus pumila*, *Pinus sylvestris*)

2.2. Хуурай хээр

- 2.2.1.Алаг өвс-үетэн-крыловийн хялганат хуурай хээр (*Stipa krylovii*, *Cleistogenes squarrosa*, *Agropyron cristatum*, *Leymus chinensis*, *Artemisia frigida*, *Potentilla bifurca*, *P.acaulis*, *Serratula centauroides*, *Saussurea salicifolia*, *Allium bidentatum*, *Haplophyllum dauricum*, *Iris tenuifolia*) зарим газраар агь-крыловийн хялганат, хазаар өвс-крыловийн хялганат талхлагдсан бүлгэмдэлтэй
- 2.2.2.а. Үетэн-хазаар өвст (*Cleistogenes squarrosa*, *Stipa grandis*, *S.krylovii*, *Agropyron cristatum*, *Leymus chinensis*, *Koeleria macrantha*, *Artemisia frigida*, *Allium anisopodium*, *Carex duriuscula*, *Ephedra sinica*) элсэрхэг хөрстэй газраараа ганц нэг хайлаастай
- 2.2.2.б. Түнгэ-хазаар өвст (*Cleistogenes squarrosa*, *Leymus chinensis*, *Agropyron cristatum*, *Artemisia frigida*, *Carex duriuscula*, *Lespedeza daurica*, *Convolvulus ammanii*, *Potentilla bifurca*)
- 2.2.3. Хялгана-харганат (*Caragana stenophylla*, *C.microphylla*, *C.pygmaea*, *Stipa krylovii*, *Kochia prostrata*, *Artemisia frigida*, *Convolvulus ammanii*, *Ephedra sinica*)
- 2.2.4. Харгана бүхий крыловийн хялгана-гаанат (*Allium polyrrhizum*, *Stipa*

krylovii, Caragana stenophylla, Carex duriuscula, Convolvulus ammanii)

III. НАМ ДООР ГАЗРЫН УРГАМАЛЖИЛ

3.1. Давсархаг хөрстэй хотосын ургамалжил

3.1.1. Үетэн –түнгэт (*Leymus chinensis, Cleistogenes squarrosa, Stipa krylovii, Achnatherum splendens, Carex duriuscula*)

3.1.2. Цахилдаг-үетэн-дэрст (*Achnatherum splendens, Leymus chinensis, Stipa krylovii, Iris lactaea, Artemisia frigida, Allium polyrrhizum*)

3.1.3. Хотгорын төвд Бадаргана-улаан бударганат (*Reaumuria soongorica, Kalidium gracile, Salsola bassarina, Nitraria sibirica*) захаар нь Дэрс-таанат (*Allium polyrrhizum, Achnatherum splendens*) бүлгэмдлүүд хам нэгдэл үүсгэсэн

3.2. Нугын ургамалжил

3.2.1. Бургас бүхий Үетэн-улалжит (*Carex vesicaria, C.atherodos, Scirpus hippolitii, Heleocharis intersida, Glyceria triflora, Beckmannia syzigachne, Calamagrostis neglecta, Sium suave, Hippuris vulgaris*)

3.2.2. Сөөг (*Padus asiatica, Salix miyabeana, S.pseudopentandra, Cornus alba*) бүхий Шарилж-үетэн-алаг өвст (*Geranium sibiricum, Achillea asiatica, Vicia cracca, Sanguisorba officinalis, Thalictrum simplex, Alopecurus arundinaceus, Poa subfastigiata, P.pratensis, Leymus chinensis, Agrostis mongolica, Artemisia lacianata, A.umbrosa*)

3.2.3. Улалж-баялаг алаг өвст (*Sanguisorba officinalis, Ligularia sibirica, Dianthus superbus, Senecio flammeus, Adenophora pereskiifolia, Achillea asiatica, Geranium pratensis, Carex caespitosa, Aconitum turczaninowii*)

3.2.4. Бургас бүхий үетэн-алаг өвс-эгэл нишингэт (*Phragmites australis, Equisetum pratensis, Thalictrum simplex, Sanguisorba officinalis, Artemisia integrifolia, Vicia cracca, V.amoena, Angelica dahurica, Calamagrostis epigeios, Agrostis mongolica, Salix miyabeana, S.schwerinii*)

Дорнод аймгийн ургамалжлын өөрчлөгдлийг илрүүлсэн дүнгээс

Ургамалжлын мониторинг судалгааны нэг арга нь өөр өөр жилүүдэд хийгдсэн ургамалжлын зургуудыг харьцуулан өөрчлөгдлийг илрүүлэх явдал юм. Бид сүүлийн жилүүдэд гарсан ургамалжлын өөрчлөгдлийг илрүүлэх зорилгоор 1975 онд хэвлэгдсэн Монгол орны ургамалжлын 1:1500000 хэмжээст зургийг ашиглав. Энэхүү зургийг дижитал хэлбэрт шилжүүлэн Дорнод аймгийн нутгийг өөрсдийн үйлдсэн зургийн ижил хэмжээст оруулан харьцууллаа (1-р хүснэгт).

1-р хүснэгт. Дорнод аймгийн 1975, 2010 онуудын ургамалжлын зургуудыг харьцуулсан дүн

Хэвшинж, дэд хэвшинж	Ургамал бүлгэмдэл	1975		2010		Өөрчлөгдсөн талбай кв.км
		Талбай кв. км	Аймгийн нийт талбайгаас эзлэх хувь	Талбай кв. км	Аймгийн нийт талбайгаас эзлэх хувь	
Ой	Шинэс, нарс ба хуса	971.6	0,79%	960.5	0,78%	-11,1
Уулын нугын хээр	Үетэн-улалж-алаг өвст, Жижиг дэгнүүлт үетэн, Алаг өвс-түнгэ-хялганат, Зүр өвс-алаг өвс-хялганат (<i>Stipa baicalensis, Poa tenuata, Filifolium sibiricum</i>)	43411.5	35,14%	13784.2	11,21%	-29627,3
дөх өвсхэн хээр	Зүр өвст хээр	16935.6	13,71%	12306.8	10,01%	-4628,8
	Харгана бүхий Хазаар өвс-хялганат, Жижиг дэгнүүлт үетэн - хялганат (<i>Stipa grandis, S. krylovii, Cleistogenes squarrosa, Koeleria macrantha, Caragana microphylla</i>)	8984.4	7,27%	51383.3	41,77%	+42398,9
	Хялгана-дааган сүүлт, Хялгана-жижиг дэгнүүлт үетэн-дааган сүүлт (<i>Koeleria cristata, Stipa krylovii, S. baicalensis, Cleistogenes squarrosa, Agropyron cristatum, Potentilla tanacetifolia, Lespedeza davurica, Allium ramosum</i>) түнгэ болон харганатай (<i>Leymus chinensis, Caragana stenophylla, C.microphylla</i>)	6670.1	5,40%	-	-	-6670,1
	Хэсэг хэсэг тархсан алаг өвс-үетэнг хээрийн бүлгэмдэл бүхий сөөгт бүрэн хэлбэржээгүй элсний ургамалжил	1576.7	1,28%	288.2	00,23%	-1287.8

Хуурай хээр	Хялгана-жижиг дэгнүүлт үетэн-харганат, Хялгана-харганат	6.4	0,005%	1902.5	1,55%	+1896.1
	Жижиг дэгнүүлт үетэн-хялганат (<i>Stipa krylovii</i> , <i>Cleistogenes squarrosa</i> , <i>Koeleria macrantha</i> , <i>Leymus chinensis</i>)	39157.4	31,70%	3157.1	2,57%	-36000.3
	Үетэн-хазаар өвст (<i>Cleistogenes squarrosa</i> , <i>Stipa grandis</i> , <i>S.krylovii</i> , <i>Agropyron cristatum</i> , <i>Leymus chinensis</i> , <i>Koeleria macrantha</i> , <i>Artemisia frigida</i> , <i>Allium anisopodium</i> , <i>Carex duriuscula</i> , <i>Ephedra sinica</i>)	-	-	13092.1	10,64%	+13092.1
	Харгана бүхий Крыловийн хялгана-таанат (<i>Allium polyrrhizum</i> , <i>Stipa krylovii</i> , <i>Caragana stenophylla</i> , <i>Carex duriuscula</i> , <i>Convolvulus ammanii</i>)	-	-	3748.6	3,05%	+3748.6
Нуга ба давст хотосын ургамалжил	Үетэн-улалжит, Үетэнт, Алаг өвст татмын нуга	6227.50	5,04%	5814	4,73%	-413.5
	Дэрст (<i>Achnatherum splendens</i>)	56.10	0,005%	1430.9	1,16%	+1374.8
	Алаг өвс-улалжит, Алаг өвс-түнгэт (<i>Carex duriuscula</i> , <i>Leymus chinensis</i> , <i>Artemisia adamsii</i> , <i>Chenopodium acuminatum</i> , <i>Ch.aristatum</i>)	6186.00	5,01%	15146.2	12,31%	+8960.2

Судалгааны дүнгээс үзэхэд ойн талбай харьцангуй бага өөрчлөгдсөн нь Дорнод аймгийн хувьд мод бэлтгэл, огтлол бага, ойн байгалийн нөхөн сэргэлт сайн явагдаж байгаатай холбоотой. Уулын нугын хээр 1975 оны ургамалжлын зургаар аймгийн нийт нутгийн 35,14% буюу 1/3-ийг эзэлж байсан бол 2010 оны байдлаар 11,21% болж, 3 дахин багассан байна. Байгаль хялгана зонхилсон хээр бараг үгүй болсныг онцлон энд тэмдэглэе. Мөн зүр өвст хээрийн эзлэх талбай 3%-аар буюу 4628,8 км кв. нутгаар багасаж, дааган сүүл (*Koeleria macrantha*) зонхилсон хээр үгүй болжээ.

Хамгийн их нэмэгдсэн ургамал бүлгэмдэл нь харгана бүхий Хазаар өвс- хялганат, Жижиг дэгнүүлт үетэн - хялганат (*Stipa grandis*, *S.krylovii*, *Cleistogenes squarrosa*, *Koeleria macrantha*, *Caragana microphylla*) жинхэнэ хээр юм. Нийт нутгийн 7,27% -ийг эзэлж байсан бол 2010 онд 41,77%-ийг эзлэн талбайн хэмжээ 5,7 дахин нэмэгдсэн байна. Эндээс харахад нугын хээр хуурайшин чийгсэг алаг өвсний оролцоо ихээхэн буурч, жижиг дэгнүүлт үетнүүд (*Koeleria macrantha*, *Poa attenuata*) том дэгнүүлт хялганаар (*Stipa grandis*, *S.krylovii*) солигдож байна.

Хуурай хээрийн хувьд чанарын нэлээд өөрчлөлтүүд гарсан байна.

Koeleria macrantha, *Leymus chinensis*) хээрийн зонхилогч крыловийн хялганыг дэрвээн хазаар өвс болон таана ихээхэн түрж байна. Ийнхүү өмнө байгаагүй хазаар өвст хээр 10,64%, таанат хээр аймгийн нийт нутгийн 3,05%-ийг тус тус эзлэх болжээ. Мөн байгаль цаг уурын дулаарал, хуурайшилтаас үүдэн хуурай хээрийн зарим нутаг давсжин, давсаг ургамалжилын эзлэх талбай 2,7 дахин нэмэгдсэн байна. Давсархаг хөрстэй хотос газраар Улаан бударгана (*Reumurea songoorica*), Шар бударгана (*Kalidium gracile*), Орог тэсэг (*Eurotia ceratoides*), таана (*Allium polyrrhizum*) зонхилсон бүлгэмдлүүд тэлж байна.

Судалгаанаас харахад Дорнод аймгийн хувьд *Cleistogenes squarrosa*, *Allium polyrrhizum* сүүлийн жилүүдэд газар нутгаа эрчимтэй тэлж байна. Бидний судалгааны энэ үр дүн өмнөх судлаачдын И.Түвшинтогтох (2007, 2009), П.Д.Гунин ба бусад (2009) гаргасан үр дүнг давхар баталж байна. Дэрвээн хазаар өвс бэлчээрийн их ашиглалтын үед хялганыг түрж, зонхилон

Дорнод аймгийн ургамлын нөмрөгийн үнэлгээ


Бид ургамлын нөмрөгийн төлөв байдлыг үнэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг шалгуур болгон авлаа. Үүнд:

1. Ургамал бүлгэмдлийн ангилаа
2. Ургамал бүлгэмдлийн тусгагийн бүрхэц, хагдны бүрхэц
3. Ургамал бүлгэмдлийн зонхилогч ургамал, зүйлийн баялаг
4. Ургацын хэмжээ
5. Талхлагдлын индикатор зүйлүүдийн бүлгэмдэл дэх оролцоо
6. Нэг наст ургамлуудын бүлгэмдэл дэх оролцоо
7. Аймаг, сумдын төв, суурингуудын байршил

Ургамал нөмрөг доройтоход бүлгэмдлийн тусгагийн бүрхэц буурах, зүйлийн тоо цөөрөх, үндсэн ургамлуудын оролцоо буурч, нэг наст болон талхлагдлын арвин судлаачид хэдийн тогтоогоод байна.

Талхлагдлын индикатор ургамлууд ургамалжлын бүс бүслүүр, хэв шинж бүрд нэлээд ялгаатай байдаг. Дорнод аймгийн хувьд бид ургамлын нөмрөгийн доройтлын индикатор ургамал болгон дараах зүйлүүдийг сонгож авсан. Үүнд: *Artemisia frigida*, *A.adamsii*, *Potentilla bifurca*, *P.acaulis*, *Ephedra sinica*, *Cleistogenes squaeosa*, *Carex duriuscula*, *Caragana нэг наст ургамлуудаас* *Chenopodium viride*, *Ch.acuminatum*, *Ch.aristatum*, *Salsola collina*, *Axyris amaranthoides*.

Дээрх шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн ургамал нөмрөгийг өөрчлөгийн түвшингээр 5 зэрэглэлд хувааж, зурагласан болно. (3-р зураг)



3-р зураг. Дорнод аймгийн ургамал нөмрөгийн үнэлгээ

2-р хүснэгтэд ургамал нөмрөгийн үнэлгээний 5 зэрэглэлийг бүлгэмдлийн тусгагийн бүрхэц, зүйлийн баялаг, доройтлын индикатор ургамлуудын бүлгэмдэл дэх оролцоо зэргийг харьцуулан үзүүлэв.

2-р хүснэгт. Дорнод аймгийн ургамлан нөмрөгийн төлөв байдлын үнэлгээ

Зэрэглэл	Бүлгэмдлийн тусгагийн бүрхэц	Зүйлийн тоо	Доройтлын индикатор ургамлуудын эзлэх хувь	Талбайн хэмжээ	
				Кв км	Хувиар
I	Өөрчлөгдөөгүй буюу сайн	(26) 35-48	0	35314	28,59%
II	Бага өөрчлөгдсөн	50-80%	22-41	12798	10,36%
III	Дунд өөрчлөгдсөн	30-65%	15-27	42632	34,51%
IV	Доройтсон	20-60%	6-15	31078	25,16%
V	Хэт доройтсон	55-70%	э	1678	1,35%
Нийт				123500	100%

I зэрэглэл. Өөрчлөгдөөгүй гэдэг нь хүний үйл ажиллагааны нөлөө бараг илрээгүй климаксийн эсвэл түүнтэй адилтгах шатанд байгаа ургамал бүлгэмдлүүд юм. Энд голдуу Хянган, Хэнтийн салбар уул нуруудад тархах үетэнт, алаг өвст, зүр өвст нугын хээр, уулын хээр хамаарч байна. Уулс, цав толгодын орой, энгэр хажуугийн чулуурхаг үетэнт, алаг өвст уулын хээрийн бүлгэмдлийн тусгагийн бүрхэц бага (40%), зүйлийн баялаг харьцангуй цөөвтөр (26 зүйл) хэдий ч гадны ямар нэгэн нөлөөнд бага өртсөн тул энэ зэрэглэлд оруулсан. I, II зэрэглэлийн хоорондын ялгаа бага, ерөнхийдөө доройтлын индикатор ургамлуудын оролцоогоороо ялгаатай. Энэ хоёр зэрэглэлд Дорнод аймгийн нийт газар нутгийн 39,95% хамаарч байна.

III зэрэглэлд хүний үйл ажиллагааны шууд ба шууд бус нөлөө тод илэрсэн, цаг уурын өөрчлөлтөнд эмзэг тал газрын хээрийн бүлгэмдлүүд багтана. Энд голдуу том хялганат хээрийн олон хувилбарууд багтана. Нийт газар нутгийн 34,51% буюу гуравны нэгийг эзэлж байна.

Үлдсэн 26,51% нь ургамал нөмрөгийн хувьд доройтсон байна. Үүнд хүний төрөл бүрийн үйл ажиллагааны нөлөө, бэлчээрийн талхлагдал, олон жилийн ган, хөрсний элэгдэл зэргийн улмаас ургамал бүлгэмдэл өөрчлөгдөж, үндсэн ургамлуудын эзлэх хувь багасаж, түүний орон зайг нэг наст болон доройтлын индикатор ургамлууд эзлэн ургаж, хоёрдогч бүлгэмдлүүдийг бий болгожээ. Хазаар өвст, харганат, таанат зэрэг зүйлийн бүрэлдэхүүн ядмаг, ургамал нөмрөг тачир сийрэг бүлгэмдлүүд багтана. Ихэнхдээ үлийн цагаан оготны колони ихтэй. Төв суурингийн эргэн тойрон 6-10 км, нуур, уст цэгүүдийн орчим үндсэн ургамал бүлгэмдэл үндсээрээ устаж дан нэг настууд болон зээргэнэ, харгана, улалж, имт гичгэнэ зэрэг цөөн зүйлийн ургамлаас бүрдсэн бүлгэмдэл зонхилж байна.

Дорнод аймаг нь малын тоо толгой харьцангуй цөөн, газар нутаг том, хүн амын төвлөрөл багатай тул Төвийн болон Баруун бүсийн аймгуудтай харьцуулахад ургамлан нөмрөгийн доройтол харьцангуй бага байна гэж бид

дүгнэж байна. Дорнод аймгийн хувьд ургамал нөмрөгийг доройтуулж буй гол шалтгаан нь бэлчээрийн талхлагдлын зэрэгцээ цаг уурын хуурайшил болж байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Дүгнэлт

1. Дорнод аймгийн нутагт ургамалжлын хэвшинж 3, дэд хэвшинж 7, хэвшил 24, бүлэг эвшил 31-ийг тус тус ялгав. Тус аймгийн нутагт ой 960,5 км², алаг өвст болон үетэнт нугын хээр -13784,2 км², зүр өвст хээр -12306,8 км², том хялганат хээр -51383,0 км², харганат хээр -1902,5 км², крыловийн хялганат хээр - 3157,1 км², хазаар өвст хээр – 13092,1 км², таанат -3748,6 км², дэрст – 1430,9 км², татмын нуга -5814,0 км², давст хотосын ургамалжил -15146,2 км², элсний ургамалжил- 288,2 км² талбай нутгийг тус тус эзэлж байна.
2. Сүүлийн 30-40 жилд Дорнод аймгийн ургамал нөмрөгт Монгол орны бусад нутгийн адил хуурайших үйл явц эрчимтэй явагдан, доройтож байгааг нотлов. Үүнд: Нугын хээрийн эзлэх талбай 3 дахин багасч том хялганат (*Stipa grandis*) жинхэнэ хээрт шилжиж байна. Жижиг дэгнүүлт үетэн-хялганат (*Stipa krylovii*, *Cleistogenes squarrosa*, *Koeleria macrantha*, *Leymus chinensis*) хээрийн зонхилогч крыловийн хялганыг дэрвээн хазаар өвс болон таана түрж, өмнө байгаагүй хазаар өвст хээр /нийт нутгийн 10,64%/ таанат хээр /3,05%/ бий болж байна. Давссаг ургамалжилын эзлэх талбай 2,7 дахин нэмэгдэж, улаан бударгана (*Reumurea songoorica*), шар бударгана (*Kalidium gracile*), орог тэсэг (*Eurotia ceratoides*), таана (*Allium polyrrhizum*) зонхилсон бүлгэмдлүүд тэлсээр байна.
3. Дорнод аймгийн ургамлан нөмрөгийн төлөв байдлыг үнэлэхэд өөрчлөгдөөгүй эсвэл хүний үйл ажиллагааны болон бусад гадны нөлөөнд бага өртсөн ургамал бүлгэмдлүүд аймгийн нийт нутгийн 39,95% -ийг эзэлж байна. Дунд зэргийн өөрчлөлттэй нутаг 34,51%-ийг хамарч, үлдсэн 26,51% нь ургамлан нөмрөгийн хувьд доройтолд оржээ. Энд бүлгэмдлийн зүйлийн бүрэлдэхүүн 4-10 зүйл болон цөөрч, бүлгэмдлийн нийт тусгагийн бүрхэцийн 80-100%-ийг доройтлын индикатор ургамлууд бүрдүүлж байна. Орон нугийн удирдлагууд эдгээр доройтсон газрыг нөхөн сэргээх тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

НОМ ЗОХИОЛ

- Ариунгэрэл Д. Дорнод аймгийн зарим ургамлын бүлгэмдэл дэх бэлчээрийн эрүүл ахуйн урт хугацааны мониторинг // Дорнод монголын экосистем 1-р дэвтэр 2001, X.131-136
- Гунин П.Д. ба бусад. Особенности деградации и опустынования пастбищных экосистем Монголии (на примере Среднеобийского аймака) // Бот. Хүр. Бүтээл. №21, 2009, 104-128 х.
- Монгол орны ургамалжлын зураг 1:1500000 хэмжээст (1975)
- Монголын Газарзүйн нэрийн товч толь бичиг Ш.Шагдар 2007, X.159-162
- Нацагдорж Л. Монгол орны уур амьсгалын хуурайшил ба цөлжилт // Монгол орны геоэкологийн асуудал, №7, УБ: Согоо нуур, 2008, X.194-212
- Өлзийхутаг Н. Монгол орны ургамлын аймгийн тойм, УБ., 1989
- Статистикийн бюллетень, 2009 оны 12-р сар, УБ., 2009
- Түвшинтогтох И. Мөнгөнчимэг Ч. Жаргалсайхан Л. Түмэнцогт сумын ургамалжлын ангилал, төлөв байдал // Ботаникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл, №21, УБ.,

2009, X.162-178

Түвшинтогтох И., Ариунболд Э. Монгол орны зүүн-өмнөд нутаг дахь зонхилогч ургамлуудын өөрчлөгдөл // Шинжлэх ухааны Академийн мэдээ, дугаар 183, №1, Улаанбаатар, 2007, х. 41-53

Уур амьсгалын өөрчлөлтөнд сав шим тогтолцоо, мал аж ахуй өртөх, дасан зохицохуй (зөвлөмж) Ус цаг уурын хүрээлэн, УБ:Адмон, 2005

Tuvshintogtokh I., Urgamal M. Fire effect on Productivity and Community Dynamics of Mongolian grassland // International Forest Fire News (IFFN) No.36 (January-July 2007, 67-75), ISSN 1029-0864 (web)

VEGETATION CLASSIFICATION, MAPPING AND SITUATION OF DORNOD AIMAG

I.Tuvshintogtokh¹, D.Enkhmaa¹, Ch.Mungunchimeg¹, Ts.Battseren¹

¹Institute of Botany, MAS

Keywords: Vegetation, plant community, classification, mapping, dominant, *Stipa grandis*, *Cleistogenes squarrosa*, *Allium polyrrhizum*, rating of vegetation cover

This paper presents the some results of our study, is introducing classification, mapping and rating of vegetation cover of Dornod aimag. The present vegetation classification is based on total of 208 releves, with were collected during field research in August 2008 and 2009. Was discriminated vegetation into 3 type, 7 formation group, 24 formation, 31 association group in the area Dornod aimag, using the Ecology-Morphology dominance-based classification plant community. Vegetation map of Dornod aimag with 1:500000 scales were made based this classification. Dornod aimag has forest with 960,5 км² area, mountain meadow steppe -13784,2 км², Filifolium sibiricum steppe -12306,8 км², *Stipa grandis* steppe -51383,0 км², *Caragana* steppe -1902,5 км², *Stipa krylovii* steppe - 3157,1 км², *Cleistogenes squarrosa* steppe – 13092,1 км², *Allium polyrrhizum* steppe -3748,6 км², *Achnatherum splendens* community – 1430,9 км², flood-plain meadow -5814,0 км², solonchak community -15146,2 км², sandy plant community- 288,2 км².

Our study showed within last 3-4 decade, vegetation of Dornod aimag is dried by grazing and climate change, such as a typical steppe is decreased by 3 times and changed as typical (*Stipa grandis*) steppe and *Stipa krylovii* steppe is changed as *Cleistogenes squarrosa* steppe (10.64% of total area aimag) and *Allium polyrrhizum* (3,05%). A solonchak community is decreased by 2.7 times and communities dominated by *Reumurea songoorica*, *Kalidium gracile*, *Eurotia ceratoides*, *Allium polyrrhizum* are distributed widely.

We were classified area of Dornod aimag by degradation category. The non degraded area has 39,95% of total area, moderate degraded area- 34,51%, heavy degraded area 26,51%.

УРГАМАЛ ТАРИМАЛЖУУЛАЛТ, НУТАГШУУЛАЛТ

ТАВИЛГАНЫТӨРЛИЙН (SPIRAEA L.) УРГАМЛЫГ НОГООН БАЙГУУЛАМЖИНД АШИГЛАХ БОЛОМЖ

Я. Гэрэлчулуун

ШУА, Ботаникийн хүрээлэн

E-mail: gerelch_77@yahoo.com

Хураангуй

Байгалийн болон гадаадын тавилганы төрлийн ургамалд интродукцийн судалгаа явуулж тарималжих, нутагших боломжийг үнэлэхэд 8 зүйл 3 хэлбэр дасан зохицож ургах чадвартай шинэ таримал ургамлаар шалгарч, үрээр тарьсан 3 настай тарьц стандартын шаардлага хангасан суулгацын хэмжээнд хүрч, үйлдвэрлэлийн зориулалтаар үржүүлэх боломжтойг тогтоов.

Зангилаа үг : *Spiraea*, ногоон байгууламж

Оршил

Тавилганы (*Spiraea* L.) төрлийн ургамал нь хотын ногоон байгууламжинд гоёл чимэглэлийн, зөгийн аж ахуйд таримал бэлчээрийн зориулалтаар ашиглах боломжтой балт сөөг ургамал юм. Өөрийн орны болон гадаад орны чимэглэлийн ургамлыг нутагшуулан тарималжуулж тэдгээрт нутагших боломжийн үнэлгээ өгч ирээдүйтэй зүйлийг сонгон авч шалгаруулах, тарималжуулж буй ургамлын дасан зохицох биологийг судлах, шинэ зүйлийн таримал ургамлаар өөрийн орны ургамлын аймгийг баяжуулан тэдгээрийг үрээр үржүүлж цэцэрлэгжүүлэх ажилд шаардлагатай жишиг тарьц суулгацыг ургуулах зорилгоор дараах зорилтуудыг тавьж ажиллав. Үүнд:

1. Тавилганы (*Spiraea* L.) төрлийн ургамлын цуглуулга бүрдүүлэх
2. Ботаникийн цэцэрлэгийн нөхцөлд үзэгдэлзүйн үе шатыг илрүүлэх
3. Улаанбаатар хотын нөхцөлд дасан зохицож ургах чадварыг үнэлэж ирээдүйтэй зүйл, хэлбэрийг сонгон шалгаруулах
4. Үрээр тарих, тайрч хэлбэржүүлэх арга боловсруулах

Судалгааны аргазүй, материал

Ботаникийн цэцэрлэгт мод, сөөг ургамал тарималжуулах, нутагшуулах нэгдсэн аргазүйг үндэслэн боловсруулж, Ботаникийн хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2007 онд батлуулсан аргазүйг баримтлан судалгааны ажлыг явуулав.

Судалгааны эх материалыг хээрийн хайгуул судалгаанд явж байгалийн ургамлын үр, суулгац цуглуулах, гадаадын таримал ургамлын үр дээжийг ботаникийн цэцэрлэгийн үр солилцооны шугамаар захиалан авах, суулгац материалыг худалдан авах замаар бүрдүүлэв. 2008-2010 оны үзэгдэлзүйн

ажиглалт судалгааны 10.710ш тоон материал цуглуулсан.

Энэхүү судалгааг 2002 оноос эхлэн явуулсаны дүнд одоогоор байгальд тархан ургадаг Тавилганы төрлийн 6 зүйл, гадаадын таримал 5 зүйл 3 хэлбэр, нийт 11 зүйлийн амьд ургамлын цуглуулга бий боллоо (1-р хүснэгт).

1-р хүснэгт. Эх ургамлын жагсаалт

Д.д	Ургамлын нэр	Үр, дээж цуглуулсан газрын нэр	Дээж материал	Цуглуулсан он
1	<i>Spiraea aquilegifolia</i> Pall.	Төв аймгийн Батсүмбэр сум шар жалгын ам Сэлэнгэ аймгийн Зүүн хараа Тарнийн амралтын орчмоос Сэлэнгэ аймгийн Сант сум бүдүүний эх	үр, суулгац	2004 2005 2007
ii	<i>S. alpina</i> Pall.	Төв аймгийн Мөнгөнморьт сум Мөнгөн уул Хөвсгөл аймгийн Хатгал сумны нутгаас	үр, суулгац	2004 2006
3	<i>S. dahurica</i> (Rupr.) Maxim.	Улаанбаатар хотын Хандгайтын амнаас	суулгац	2004
4	<i>S. salicifolia</i> L.	Төв аймгийн Батсүмбэр сум шар жалгын ам Улаанбаатар хотын Хандгайтын амнаас Сэлэнгэ аймгийн Зүүн хараа Тарнийн амралтын орчмоос	үр, суулгац	2004 2004 2005
5	<i>S. media</i> Franz Schmidt	Улаанбаатар хотын Баянбулагийн ам Төв аймгийн Батсүмбэр сум шар жалгын ам Сэлэнгэ аймгийн Зүүн хараа Тарнийн амралтын орчмоос Сэлэнгэ аймгийн Сант сум бүдүүний эх	үр, суулгац	2002 2004 2005 2007
ii	<i>S. flexuosa</i> Fisch.	Төв аймгийн Батсүмбэр шар жалга Төв аймгийн Батсүмбэр наян тэмээтийн амнаас Сэлэнгэ аймгийн Сант сум Бүдүүний эх	үр, суулгац	2003 2005 2007
7	<i>S. hypericifolia</i> L.	Дорноговийн аймгийн их нарт	суулгац	2003
8	<i>S. chamaedryfolia</i> L.	ОХУ-ын Ерөнхий ботаникийн цэцэрлэг	үр	2003
9	<i>S. miyabei</i> Koidz		үр	2008
10	<i>S. japonica</i> "Golden press"	ОХУ-ын Ирхүү муж Ургамлын биохими физиологийн хэрээлэнгийн дэргэдэх мод үржүүлгийн газар	суулгац	2008
11	<i>S. japonica</i> "firelingt"		суулгац	
12	<i>S. japonica</i> "nana"		суулгац	
13	<i>Spiraea</i> "little prences"		суулгац	
14	<i>Spiraea</i> "gymjea"		суулгац	2009

Судалгааны үр дүн

Үзэгдэлзүйн шат

Тавилганы төрлийн ургамлын нахиа хөөх, задрах, навчлах, навчны

өнгө хувирах, навч унах, 2-р хүснэгт. Тавилганы төрлийн ургамлын ургал үе (2008-2010 он) найлзуурын өсөлт эхлэх, төгсөх үе, цэцгийн бундуй үүсэх, цэцэглэх, үр жимс боловсрох, үрээ гөвөх зэрэг үе шатуудад тогтоохын тулд үзэгдэлзүйн ажиглалт судалгааг явуулж 10.710ш тоон материал цуглуулан боловсруулав.

Д.д	Ургамлын нэр	Ургал үе		үргэлжлэх хугацаа
		Эхлэх	Төгсөх	
1	<i>Spiraea alpina</i> Pall.	V.13± 7	IX.18± 5	128
2	<i>S. aquilegifolia</i> Pall.	V.11± 4	IX.14±5	126
3	<i>S. dahurica</i> (Rupr.) Maxim.	V.10± 5	IX.15± 4	129
4	<i>S. flexuosa</i> Fisch. Ex Chambess	V.11± 6	IX.26± 4	137
5	<i>S. media</i> Franz Schmidt	V.11± 5	IX.24± 6	137
6	<i>S. salicifolia</i> L.	V.09± 5	IX.25± 5	137
7	<i>S. chamaedryfolia</i> L.	V.13± 5	IX.29± 6	136
8	<i>S. japonica</i> 'Golden press'	V.15± 5	X.05± 4	137
9	<i>S. japonica</i> 'firelingt'	V.16± 5	X.05± 4	138
10	<i>S. japonica</i> 'nana'	V.15± 5	X.03± 4	136

Тавилганы төрлийн ургамлын ургалтын үе агаарын хэм +5°C дээш тогтворжсон V/15-ын үеэр эхлэж, агаарын хэм +5°C -аас доош орсон IX/15-ын үеэс тайван байдалд орж эхлэх ба ургал үе нь дунджаар 129-136 хоног үргэлжилж байна (2-р хүснэгт).

Ургамлуудын цэцэглэх үе нь V/25-VI/20 хооронд эхлэж дунджаар 10-15 хоног, VI/27-VII/10-ны хооронд үр жимс боловсорсноор 14 хоног, навчны өнгө хувирах үе нь IX/20-X/20 хүртэл 30 хоног тус тус үргэлжилж байгааг тогтоосон бөгөөд тухайн жилийн цаг уурын нөхцлөөс хамааран үзэгдэлзүйн үе шатуудын үргэлжлэх хугацаа нь 3-10 хоногоор хэлбэлзэж байна.

3-р хүснэгт. Тавилганы (*Spiraea L.*) төрлийн ургамлын

цэцэглэлтийн хуанли

Д.д	Ургамлын нэр	5 сар			6 сар			7 сар			8 сар
		1	2	3	1	2	3	1	2	3	1
1	<i>Spiraea aquilegifolia</i> pall.										

2	<i>S. flexuosa</i> Fisch. Ex Chambess										
3	<i>S. dahurica</i> (Rupr.) Maxim.										
4	<i>S. media</i> Franz Schmidt										
5	<i>S. alpina</i> Pall.										
6	<i>S. salicifolia</i> L.										
7	<i>S. chamaedryfolia</i> L.										
8	<i>S. japonica</i> golden press										
9	<i>S. japonica</i> fireling										
10	<i>S. japonica</i> nana										

Тавилганы төрлийн ургамлын цэцэглэлтийн үе нь V.25-VIII.15 хооронд зүйлүүд цувран цэцэглэдгийг ажиглан тогтоов. Иймд энэ төрлийн ургамлаар дангаар нь цувран цэцэглэх цэцэрлэг байгуулахад ашиглах боломжтой юм (3-р хүснэгт).

4-р хүснэгт. Тавилганы (*Spiraea L.*) төрлийн зарим ургамлын цэцэглэх, үр жимс боловсрох үе (2008-2010 он)

Д.д	Ургамлын нэр	Цэцэглэх үе		Үргэлжлэх хугацаа	Үр жимс боловсрох үе		үргэлжлэх хугацаа
		Эхлэх	Төгсөх		Эхлэх	Төгсөх	
ö	<i>Spiraea alpina</i> Pall.	VI.21±3	VII.05±3	14	VII.16±3	VIII.8±3	19
ü	<i>S. aquilegifolia</i> Pall.	V.20±4	VI.06±4	16	VI.05±2	VI.25±2	16
ö	<i>S. dahurica</i> (Rupr.) Maxim.	VI.10±3	VI.24±2	14	VII.03±2	VII.23±3	18
ü	<i>S. flexuosa</i> Fisch. Ex Chambess	V.25±3	VI.11±3	16	VI.27±3	VII.15±3	18
ö	<i>S. media</i> Franz Schmidt	VI.12±3	VI.27±2	15	VII.08±2	VII.25±2	17
ü	<i>S. salicifolia</i> L.	VII.06±3	VII.25±2	14	VII.28±2	VIII.15±3	19
č	<i>S. chamaedryfolia</i> L.	VI.13±3	VII.05±2	18	VII.10±3	VII.30±4	20
š	<i>S. japonica</i> 'Golden press'	VII.12±4	VIII.03±2	23	VIII.08±2	VIII.27±2	19
j	<i>S. japonica</i> 'fireling'	VII.13±3	VIII.05±2	24	VIII.10±4	VIII.29±2	19

Дээрхи хүснэгтээс үзэхэд Ботаникийн цэцэрлэгт уг төрлийн ургамлууд нь ихэвчлэн 15 хоног үргэлжлэн цэцэглэж, үр жимс нь 16-20 хоногт боловсорч гүйцдэг болох нь тогтоогдлоо.

Тарималжуулж буй ургамлын үзэгдэлзүй, хөгжлийн үе шатыг судлан тогтоосны үндсэн дээр тухайн газраа цаашид дасан зохицож ургах чадварыг нь Лапин, Сидневагийн /1973/ аргаар үндсэн 7 үзүүлэлтээр үнэлэв.

5-р хүснэгт. Тарималжуулж буй тавилганы ургах чадвар

Д.д	Ургамлын нэр	Үнэлгээний утга									
		Нас (жилээр)	Найлуурын молжилт	Өвөлжилт байдал	Хэлбэрээ хадгалах байдал	Найлуур үүсэх байдал	Өндрийн өсөлт	Үрлэж үрээ өгч байвал	Тарималжих байгаа нутагтаа уржих чадвартай	Тохиргоо онооны нийлбэр	Ангилал
1	<i>Spiraea flexuosa</i> Fisch. Ex Cambess	5	20	25	10	5	5	25	6	96	I
2	<i>S. flexuosa</i> Fisch. Ex Cambess	3	15	20	10	5	5	-	-	60	I
3	<i>S. media</i> Franz Schmidt	7	20э	20	10	3	5	25	5	88	II
4	<i>S. media</i> Franz Schmidt	3	20	20	9	3	5		-	57	II
5	<i>S. salicifolia</i> L.	7	20	25	10	3	5	25	-	83	II
6	<i>S. salicifolia</i> L.	3	20	20	8	3	5		-	56	II
7	<i>S. japonica</i> 'Golden press'	3	15	15	8	3	5	-	-	46	I
8	<i>S. japonica</i> 'fireling'	3	15	15	8	3	5	25	-	71	I
9	<i>S. japonica</i> 'nana'	3	15	15	8	3	3	-	-	47	I
10	<i>S. chamaedryfolia</i> L.	7	20	20	10	3	5	25	5	88	

Тавилганы төрлийн ургамлын тарималжин ургах боломжийг зохих аргазүйн дагуу зүйл тус бүрээс 3, 5, 7 настай ургамалд 10-ын давталттай 3 жилийн үнэлгээнээс харахад нас гүйцсэн ургамлуудын хувьд 83-96 оноо, балчир ургамлууд 46-60 оноогоор үнэлэгдэж Улаанбаатар хотын нөхцөлд дасан зохицох бүрэн ирээдүйтэй I, ирээдүйтэй II гэсэн ангилалд тус тус хамаарч байгаа нь хотын ногоон байгууламжинд тэдгээрийг ашиглах боломжтойг тогтоолоо (5-р хүснэгт).

Үрээр ургуулсан судалгааны дүн

Тавилганы үрийн хэмжээс 2 мм урт 0,5 мм өргөн, 1000 үрийн жин нь дунджаар 0,2 гр бөгөөд зүйл тус бүрийн үрийн жин бага зэрэг ялгаатай байна. Бусад сөөг ургамалтай харьцуулахад үр жижиг хэмжээтэй, нимгэн хальсан бүрхүүлтэй учир гадаад орчны нөлөөнд амархан өртөгдөж хөврөл хатах, хөлдөх зэргээр хадгалалт даахдаа муу байдаг. Үрийг түүсэн жилдээ тасалгааны хэмд петрийн аяганд соёолуулахад ихэнх нь 3-5 өдөрт соёолж 85-90% -ийн ургах чадвартай байв. Харин 1 жил хадгалахад *Spiraea dahurica*, *S. alpina*, *S. media*, *S. salicifolia*, *S. flexuosa* - д үрийн ургах чадвар 40-50% буурсан бол *S. aquilegifolia* -д 55-60%-иар буурсан. 3 жил хадгалсан үрийн ургах чадварыг үзэхэд ургах чадвараа бүрэн алдсан байв. Харин хөрсөнд соёолох чадамж нь *Spiraea media* -д 45% , *S. alpina*- 30%, бусад зүйлд 35-

40% -тай хэлбэлзэж байсан. Тавилганы төрлийн ургамлын хөрсний соёлолт дунджаар 38% -тай байв.



1-р зураг

Spiraea flexuosa –г *S. flexuosa*, *S. alpina*, *S. media*, *S. salicifolia* -ийн тарьц эхний (тарьц эхний жилд жилдээ дунджаар 15-18 см, хоёр дахь жилд 35-45 см өндөр, гурав дахь жилдээс дунджаар 55-65 см өндөр болж байна. Модлог ургамлын өсөлтийн хурдны ангилалаар аажуувтар өсөлттэй II бүлэгт хамаарагдаж байна.



2-р зураг

3 настай-*Spiraea flexuosa*



3-р зураг

5 настай- *Spiraea media*



4-р зураг

7 настай-*Spiraea media*

Тавилганы төрлийн ургамлын үрээр тарьсан 3 настай тарьц 6-8 салаалсан үржлийн найлзуур үүсэж улмаар 45-50 см орчим өндөртэй болж цэцэглэж эхлэх ба үндэсний хөгжил сайн, ухаж авсан суулгацын дичкиний голч /үндэсний / 25-30 см, оройн нахиа бүрэн зангидаж байгаа зэрэг үзүүлэлтүүд УСТ 1795-2009-д заагдсанаар хотын ногоон байгууламжинд шилжүүлэн тарих 1-р зэргийн суулгацын стандарт хэмжээнд хүрч байна.

Тавилганыг үрээр тарих арга

Тавилганыг үрээр тарихдаа тусгайлан бэлтгэсэн модон хайрцагт тарьж хүлэмжинд байлгаж үрслэг бэлтгэж, дараа нь задгай талбайд шилжүүлэн суулгана.

Үрийг түүсэн жилийн намар тарих, дараа хавар нь V сарын 20-30 хооронд тарина.

Үр тарих хөрсийг бэлтгэхдээ хар шороо, үртэс, бууцыг 3:1:1-ийн

харьцаатай холимогийг 30x50 см модон хайрцагны хайрцагны амсарнаас 5см доор байхаар хийнэ.

Ийнхүү бэлтгэсэн модон хайрцагтай хөрсөнд, үрээ гурван эгнээгээр зурваслан тарьж хар шороо, элсний 2:1-ийн харьцаатай холимоогоор нимгэн хучиж гараар бага зэрэг дарж дагтаршуулан зөөлөн шүршиж услана. Үр соёлолтод хөрсний чийгийг тогтмол 60 хувьтай байлгана. Цухуйснаас хойш зэрлэг ургамлыг зулгаах, хөрсийг сийрүүлэх услах зэргээр 7 хоног тутамд агро арчилгааг тогтмол явуулна. Ургасан тарьцыг 6-10 навчтай 1-2 салаа найлзууртай болсон үед нь задгай талбайд шилжүүлэн суулгана.

Тарьц шилжүүлэн суулгахаар сонгосон талбайн хөрсийг боловсруулахдаа 30-40 см гүн хагалж, хөрсний том хэсгийг нь буталж, чулуу ургамлын үндсийг нь түүж цэвэрлээд 1м² талбайд нэг хувин бууц (6-8кг) нэг хувин элс хийж, хольж тэгшилсэний дараа тарьцыг ургамал хооронд 10 см, мөр хооронд 30 см зайтай суулгасан.

Шилжүүлэн суулгасан тарьцыг 7 хоногт 3-4 удаа усалж, зун, намрын эхэн үед бууц болон сангасны уусмалаар бордож, хөрсийг өрөмтөж, хатуурахаас сэргийлэн хөрсийг сийрүүлж, хог ургамлыг нь устгасан. Ургалт үе төгссөний дараа үртэсээр хучиж өвөлжүүлнэ. Тарьцыг 2 дахь жилд нь бойжуулгын талбайд шилжүүлэн суулгахдаа хөрсийг дээрхийн адил боловсруулж тарьцыг ургамал хооронд 30 см, мөр хооронд 40 см зайтай суулгасан. Мөн долоо хоногт 3-4 удаа усалж, 5 дугаар сарын 3 дугаар 10 хоног, 6 дугаар сарын 3 дугаар 10 хоногт бууц сангасны уусмалаар бордож, хөрсийг сийрүүлж, хог ургамлыг нь устгана. Ургалт үе төгссөний дараа 2 дахь жилдээс хучилгагүй өвөлжүүлнэ.

Хэлбэржүүлэн тайрах арга

Бид 3, 4 настай суулгацыг хавар эрт, хаврын сүүлч, зуны эхэн, дунд, сүүлчээр намрийн эхэн үед хугацааны хувьд тэгш дөрвөлжин, титмийг нь бөөрөнхий хэлбэрээр тайралт хэлбэржүүлэлт хийж туршсан. Намхан хашлага (40см) хэлбэрт оруулах, зүлгэн дунд толбо тавих зэрэгт суулгацын 3 наснаас хавар эрт эхлэн тайралтыг хийвэл тохиромжтой байсан бол (0,8-1м) өндөр хашлага, тасархайтсан эмжээр, ургамлын өөрийн ерөнхий хэлбэрээр нь засаж бусад сөөгтэй хослуулах бол 4 наснаас нь тайралтыг хийвэл тохиромжтой байв. Үүнд:



3 настай тарьцыг хавар шилжүүлэн тарьсаны эхний жилдээ нэг настай бүх найлзуурыг хөгжил сайтай нахиа хүртэл нь гадагшаа чиглэсэн байдалтайгаар тайрна.



Зун цэцэглэж дуусмагц баг цэцгийн угаар, хажуугийн найлзууруудаас өөрийн сонгосон хэлбэрийн дагуу хэлбэржүүлэн тайрна.



Шилжүүлэн тарьсаны 2 дахь жилийн хавар нэг настай найлзуурын 50%-ийг тайрч мөн зун цэцэглээд дуусмагц багцэцгийн угаар нь тайрна.



Шилжүүлэн суулгасны гурав дахь жилд нь хөгширсөн мөчрийг 3-4 сард тайрах ба хавар, зуны тайралтыг дээрхийн адил хийнэ. Цэцэрлэгт байгууламжинд тарьсан тавилганыг хэлбэржүүлэх, залуужуулах тайралт хийснээр тухайн төгөл үргэлж гоёмсог харагдах болно.



5-р зураг

3 настай-*Spiraea media*



6-р зураг

6 настай-*Spiraea chamaedryfolia*

Уг төрлийн ургамлыг хотын ногоон байгууламжинд намхан хашлага эмжээр, цувран цэцэглэх цэцэрлэг, бусад мод сөөгтэй хослуулах, зүлгэн дунд толбо хэлбэрээр тарих зэргээр ашиглах боломжтой төдийгүй тэдгээрийг тайрч хэлбэржүүлэхэд нэн тохиромжтой таналт тайралт сайн даадаг, чимэглэлийн ач холбогдолтой сөөг юм.

Дүгнэлт

Тавилганы төрлийн ургамлаас Ботаникийн цэцэрлэгийн нөхцөлд Монгол оронд тархдаг 6 зүйл, гадаадын таримал 5 зүйл 3 хэлбэр, нийт 11 зүйлийн амьд цуглуулга бүрдүүлэв.

Ботаникийн цэцэрлэгийн нөхцөлд тарималжуулж нутагшуулж буй Тавилганы төрлийн ургамлын ургалтын үе нь дунджаар 5-р сарын 14-өөс 9-р сарын 25-ны хооронд 129-130 хоног үргэлжилж харьцангуй тайван байдалд орж байна.

Тарималжуулж буй ургамалд тарималжин ургах ирээдүйг үнэлэхэд *Spiraea aquilegifolia*, *S. dahurica*, *S. alpina*, *S. media*, *S. salicifolia*, *S. flexuosa*, гадаадаас нутагшуулж буй *S. japonica* “Golden press”, “firelingt”, “nana” сортууд, *S. chamaedryfolia* -ийн тарьц 56-60 оноо, бие гүйцсэн ургамлууд 83-96 оноогоор үнэлэгдэн I-II ангилалд хамаарч Улаанбаатар хотын нөхцөлд цаашид тарималжин ургах бүрэн ирээдүйтэй шинэ таримал ургамлаар сонгогдон шалгарлаа.

Үрээр тарьсан Тавилганы тарьц нь 3 дахь жилээсээ УСТ 1795-2009-ийн I-р зэргийн шаардлага хангаж хот цэцэрлэгжүүлэх ажилд шаардлагатай жишиг тарьц суулгачын хэмжээнд хүрч байгааг тогтоов.

Уг төрлийн ургамлыг үрээр үржүүлэх аргачлал боловсруулсан нь үйлдвэрлэлийн зориулалтаар үрээр үржүүлж, хотын ногоон байгууламжинд цувран цэцэглэх цэцэрлэг, бусад мод сөөгтэй хослуулах, намхан хашлага эмжээр, зүлгэн дунд толбо хэлбэрээр ашиглах боломжтой.

НОМ ЗОХИОЛ

Байтулин И. О., Шарловская Л. П. Таволги в озеленении Центрального Казахстана. Алма-Ата., 1987. 110 с

Цэрэннадмид П. Эколого-Биологическое обоснование интродукции декоративных кустарниковых растений и их использование и зеленом строительстве. Авторефер. дисс. На соис. учен. степ. канд. биол. наук. УБ., 1995. 26 С.

Чанцалням Д. Биологические особенности некоторых полезных кустарников при интродукции. Автореф. дисс. На соис. учен. степ. канд. биол. наук. УБ., 1995. 28С.

Резюме

ПЕРСПЕКТИВЫ ИСПОЛЬЗОВАНИЯ В ОЗЕЛЕНЕНИИ РОДА SPIRAEA L.

Я. Гэрэлчулуун¹

¹ Институт Ботаника, АНМ

Ключевые слова: интродукции, зеленении, формировать

У нас в озеленении города пересаживают из леса некоторых видов из рода спиреи. Это оказывает не только негативное влияние к природе, но и по декоративному свойству и по приспособляемости хуже чем растения с питомника. По этому важно подготовить посадочные материалы, обеспечивающих требований стандарта, путем выращивания в питомниках растений рода спиреи семенами. Установлен видовой состав, дана оценка зимостойкости, декоративности, жизнеустойчивости и жизненной формы их в условиях города Улаанбаатора.

АЛТАЙН БҮСЭД НУТАГШИЖ БУЙ СӨӨГӨН ИНТООРЫН (*CERASUS FRUTICOSA* (PALL.) MAXIM.) ӨСӨЛТ БИЕЖИЛТИЙН СУДАЛГАА

Д.Хандсүрэн¹

DN_HANDA33@YANOO.COM

¹ХААИС, Экологи технологи хөгжлийн сургууль, Экологийн тэнхим

Хураангуй

Сөөгөн Интоорын сортуудыг Алтайн бүсийн нөхцөлд анх удаа нутагшуулж, биологи, аж ахуйн судалгаа хийж, үзэгдэлзүйн үе шат бүрт найлзуурын өсөлтийг тодорхойлохыг зорилоо. Сөөгөн Интоорын сортуудын найлзуур, мөчрийн өсөлт үр жимс боловсрох үед тодорхой хугацаагаар удааширдаг онцлогийг илрүүлсэн.

Сөөгөн Интоорын сортуудын 2002-2006 онуудын найлзуурын өсөлтийг жил, сар, 10 хоногээр жил бүр, нэг ижил хугацаанд хэмжсэн бөгөөд тухайн жилийн байгаль цаг уур, орчинзүйн нөхцөл, агротехникийн арчилгаанаас хамааран янз бүрийн өсөлттэй байлаа.

Интоорын нутагшуулсан анхны жилийн найлзуурын өсөлт бусад жилийнхтэй харьцуулахад хамгийн бага буюу удаан байсан нь интоор тухайн орчинтойгоо дасан зохицох чадвартай шууд холбоотой байв

Аливаа ургамал нэгээс нөгөөд шилжих явцад удамзүйн бөгөөд сортын онцлог шинжүүдээс болж дасаж зохицох чадвар янз бүр байдаг. Эдгээр сортууд чийглэг дулаан уур амьсгалтай орчноос хахир ширүүн уур амьсгалтай манай орны нөхцөлд шилжин ургаж байгаа сөөгөн Интоорын сортууд орчин нөхцөлтэйгээ дасан зохицох чадвар жилээс жилд сайжирч байлаа. Соорт бүрийн мөчир, найлзуурын өсөлт 2002 онд бага байсан нь уг ургамал шинэ нутагт дасан зохицох анхны жилийн бэрхшээлийг даван туулах биологийн нөөц, онцлогтой холбоотой байсан гэж үзэж болох юм.

Зангилаа үг: Алтайн бүс, Сөөгөн Интоор, найлзуурын өсөлт, нутагшуулалт

Оршил

Манай оронд жимст цэцэрлэгийг хөгжүүлэх үйлсэд интоор чухал байрыг эзлэх учиртай. Интоорын сортын мөчир, найлзуурын өсөлтийг судалснаар жимсний шилдэг сортуудыг шалгаруулан үйлдвэрлэлд нэвтрүүлэх, иргэдийг хэрэгцээт жимсээр хангахын зэрэгцээгээр жимсний аж ахуйг ашиг орлого ихтэй салбар болгоход ихээхэн ач холбогдолтой.

Монгол орон төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээр сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдлийн үйлдвэрлэлийн хэрэгсэл хувьчлагдахад жимст цэцэрлэг ихэвчлэн мэргэжлийн биш хувь хүмүүсийн гарт шилжсэн юм.

Ингэснээр жимсний таримлын арчилгаа муудаж, мод бут хөгширч, жимст цэцэрлэгийн хэмжээ олон арван га- гаар устаж алга болсон билээ. Мөн суулгац үржүүлэх ажил далайц муутай болов.

Яст жимс болох интоорын сортууд нь манай орны нөхцөлд дасан зохицох чадвар сайтай, ургалтын хугацаа богино, ургац арвин, өвөл болон хүйтэнд тэсвэртэй, зардлаа богино хугацаанд нөхдөг зэрэг чанараар алим болон бусад жимснээс давуутай таримал бөлгөө.

Хөрш зэргэлдээ ОХУ-ын Алтайн хязгаарын Барнаул хотоос Сөөгөн Интоорын сортуудын суулгацыг авчирч, биологи аж ахуйн зарим судалгааны ажил хийж, өвөлд болон хүйтэнд тэсвэртэй, арвин ургацтай сортыг шалгаруулан нутагшуулах санал санаачлагыг бид сэдэж дэвшүүлсэн юм.

Судалгааны материал, аргазүй

2002 онд ОХУ-ын Алтайн хязгаарын Барнаул хотын М.И. Лисавенкогийн нэрэмжит Сибирийн Жимс-жимсгэний Эрдэм шинжилгээний хэрээлэнгээс интоорын гурван сорт (Касмалинка, Змейногорская, Максимовская)-ын 225 ширхэг суулгац авчирч ХААИС-ийн Алтайн бүсийн салбарын туршилт-үйлдвэрлэлийн талбайд тариалснаар эдгээр нь бидний судалгааны гол объект болсон юм.

Судалгааны ажлын хүрээнд сөөгөн Интоор (*Cerasus fruticosa* (Pall.) Maxim.) сортыг 3 давталттайгаар системийн аргаар байрлуулж, нийт 90 бодгаль дээр хэмжилт судалгааг хийв.

Бид ОХУ-ын Жимс-жимсгэнийн ургамалд үзэгдэл зүйн ажиглалт хийх нэгдсэн аргазүйг удирдлага болгон ажиллав. Үүнд: өсөлт биежилтийн үе шатны ажиглалтыг И.В. Мичурин (1974), Б.А. Доспехов (1979), сөөгийн өсөлтийн хөдлөлзүйг А. Петров, И. Митов (1990) нарын аргаар тус тус судлав.

Судалгааны үр дүн

1 Соортуудын 10 хоног болон жилийн өсөлтийн байдал

Судалгааны хүрээнд 2002-2006 онуудад сөөгөн Интоорын 3 сорт тус бүрт найлзуурын өсөлтийн хөдлөлзүйг тодорхойлж, тоон боловсруулалт хийв.

2002 он


Найлзуурын өсөлтийн жигдрэлт, түүний үргэлжлэх хугацаа нь гадаад дотоод олон хүчин зүйлээс шалтгаалан харилцан адилгүй явагдаж байлаа. Судалгаанд хамрагдсан сөөгөн Интоорын сортуудыг эх нутгаас нь шилжүүлэн Монгол орны Алтайн бүсэд шилжүүлэн нутагшуулав. Ургалтын үеийн найлзуурын 10 хоногийн өсөлтийн дундаж буюу хоногт хичнээн уртсах боломжтойг илрүүлэх судалгаа судлахыг хичээлээ.

6 дугаар сарын хоёрдугаар 10 хоногт Максимовский 1 см, Змейногорский 1.2 см өссөн бол Касмалинка соорт хамгийн их буюу 1.4 см тус тус өсчээ.

Харин 6 дугаар сарын сүүлчийн 10 хоногт хамгийн сайн буюу “Максимовский” 2.6 см, Касмалинка хамгийн муу буюу 1.7 см-ээр харин Змейногорская 2.3 см буюу дундаж ургалттай байв. Энэ үед найлзуурын өсөлт янз бүр байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байлаа.

7 дугаар сарын эхний 10 хоногт “Максимовский” соорт 2.5 см өссөн бөгөөд өмнөх хэмжилтээс 0.1 см-ээр буурсан хандлага ажиглагдаж байгаа бол Касмалинка соорт хамгийн их өссөн буюу 2.95 см, Змейногорский соорт 2.6 см-ээр нэмэгджээ.

7 дугаар сарын хоёрдугаар 10 хоногт “Максимовский”, “Змейногорский” сортууд өсөлт жигд нэмэгдэж байхад, “Касмалинка” соорт 1.9 см –ээр буурсан байна. 7 дугаар сарын гуравдугаар 10 хоногос жигд өсөлттэй байсан төдийгүй 8 дугаар сарын хоёрдугаар 10 хоногос өсөлт тогтворжиж, 8 дугаар сарын сүүлчийн 10 хоногт найлзуурын өсөлт зогсов. Хамгийн их өссөн “Максимовский” соорт 8 дугаар сарын хоёрдугаар 10 хоногт 3.8 см, “Змейногорский” соорт 3.7 см, харин “Касмалинка” соорт 3.0 см-ээр тус тус нэмэгдсэн байна.



1-р зураг. Интоорын найлзуурын 10 хоногийн өсөлтийн дундаж /2002/.см-ээр


Үүнээс үзэхэд 2002 онд найлзуурын өсөлт ургалт дуусах үед хамгийн их эрчимжиж байв. Шинээр нутагшиж буй соортууд орчин зүйн нөхцөл, агротехникийн арчилгаанд жигд бус дасан зохицож байгаа нь 2002 оны байдлаар

“Касмалинка” соортод мэдэгдэхүйц илэрч байлаа.

2003 он

Ургалтын эхэн үед сортын 10 хоногийн өсөлтийн дундаж тогтвортой байсан бол Максимовский 6 дугаар сарын хоёрдугаар 10 хоногт 1.1 см-ээр буурсан ба 6 дугаар сарын сүүлчийн 10 хоногт 0.6 см, 8 дугаар сарын гуравдугаар 10 хоногоос 1.2 см-ээр өссөн хандлага ажиглагдав. “Змейногорский”, “Касмалинка” соортууд 8 дугаар сарын эхний 10 хоногоос 0.3-0.6 см-ээр өссөн байна.

Харин 8 дугаар сарын 10-ны байдлаар бүх соортын өсөлт буурсан бөгөөд дараагийн 10 хоногт ижил хэмжээтэй уртассан байв.




2-р зураг. Интоорын найлзуурын 10 хоногийн өсөлтийн дундаж /2003/, см-ээр

Найлзуурын өсөлтийн хэлбэлзэлийг 2002 оныхтой харьцуулахад удаан ургалттай байлаа.

2004 он

Залуу шинээр ургаж буй сөөгөн Интоорын найлзуурын өсөлт 2004 онд хамгийн хүчтэй байсан нь сөөгийг хэлбэржүүлэх таналт, тайралт хийх ажил зайлшгүй шаардлагатай болов. Иймд ургалтын хурдыг зохицуулах, титмийг хэлбэржүүлэх, сийрүүлэх таналт, тайралтыг хийхээс гадна сортуудын хөлдөж гэмтсэн, өвлийн хучлаган дор хугарсан мөчрийг тайрах, зайлуулах ажиллагаа хийж гүйцэтгэлээ.

Найлзуурын өсөлтийн 10 хоногийн явцаас үзвэл 2004 онд “Максимовский” соортод VI.20, VII.20, IX.1 гэсэн 3 хугацаанд, “Змейногорский” соортод VI.30, IX.20 гэсэн 2 хугацаанд Касмалинка соортод VI.20, VII.20 гэсэн эдгээр хугацааны хооронд хамгийн их өсөлт ажиглагдлаа.




3-р зураг. Интоорын найлзуурын 10 хоногийн өсөлтийн дундаж явц, /2004/, см-ээр

Найлзуурын өсөлтийг өмнөх жилүүдтэй харьцуулахад VII.20- нөөс VIII.10-ны хооронд өсөлт буурч зогсонги байдалд байснаа дахин ургалт уртсаж байлаа (3-р зураг).

2005 он

Хавар ургалтын үед шилжихийн өмнө интоорын титмүүдэд хэлбэржүүлэх болон хязгаарлах тайралтыг хийв. Тайралт хийснээр ургалтын явц эрчимжиж, мөчирлөлтийн тоо, нахианы тоо нэмэгдэж байв.

2005 оны найлзуурын жилийн өсөлт сорт бүрт харилцан адилгүй явагдсан ба дунджаар “Максимовский” 44.0 см, “Змейногорский” 44.6, “Касмалинка” 39.0, см тус тус уртассан нь өмнөх жилүүдтэй харьцуулахад харьцангуй их өсчээ. Судалгааны үр дүнгээс харахад VII.10-VIII/1-ний хооронд физиологийн завсрын үе ажиглагдсан нь бидний сонирхолыг татаж байлаа.




4-р зураг. Интоорын найлзуурын 10 хоногийн өсөлтийн дундаж, /2005/, см-ээр

Интоорын жимс VIII/1- ээс боловсорч, хураасны дараа найлзуурын өсөлт дахин эрчимжиж, дунджаар 4.6- 6.0 см- ээр тус тус уртгассан байв.

2006 он

Бидний судалгааны дүнгээс үзэхэд 2006 онд ургасан найлзуурын хоногийн өсөлт харилцан адилгүй хэлбэлзэлтэй байгаа нь ажиглагдаж байлаа (5- р зураг).



5- р зураг. Найлзуурын 10 хоногийн өсөлтийн дундаж явц, /2006/

Судалгаанд хамрагдсан сортуудын найлзуурын 10 хоногийн өсөлт хамгийн их өссөн “Максимовский” VIII сард 7.2 см, хамгийн бага “Касмалинка” сорт VI сард 4.9 см-ээр өсчээ. Жимсэлж эхэлснээс хойш мөчрийн өсөлтийн 10 хоногийн явцад VII/20- VIII /10 хооронд өсөлт буурч байгаа нь ажиглагдлаа. Энэ үед жимс бүрэлдэх, яст үр үүсэхтэй давхцаж, шим гэжээлийн бодис хуваагдсантай холбоотой гэж үзлээ.

2. Сөөгөн Интоорын сортуудын найлзуурын өсөлтийг харьцуулсан дүн

Сөөгөн Интоорын сортуудын 2002-2006 онуудын найлзуурын өсөлтийг жил, сар, 10 хоногоор жил бүр, нэг ижил хугацаанд хэмжсэн бөгөөд тухайн жилийн байгаль цаг уур, орчинзүйн нөхцөл, агротехникийн

арчилгаанаас хамааран янз бүрийн өсөлттэй байлаа.


Эдгээр сортууд чийглэг дулаан уур амьсгалтай орчноос хахир ширүүн уур амьсгалтай манай орны нөхцөлд шилжин ургаж байгаа сөөгөн Интоорын сортууд орчин нөхцөлтэйгээ дасан зохицох чадвар жилээс жилд нутагт дасан зохицох анхны жилийн бэрхшээлийг даван туулах биологийн нөөц, онцлогтой холбоотой байсан гэж үзэж болох юм. Мөн 2002 оны жилд унах нийт тунадасны хэмжээ 85.6 мм байсан нь олон жилийн дундажаас 2,5 дахин бага байсан нь шинэ залуу интоорын тарималд хүрэлцэхүйц чийг байж чадсангүй. Сортуудын хамгийн их өссөн 2002 оны VI.30- нд агаарын хамгийн их температур 27°C, хамгийн бага температур 13.1°C байсан бол VII.10- нд үед хамгийн их температур 21.8°C, хамгийн бага температур 11.9°C байжээ.

Манай орны нутаг дэвсгэрийн 25 хувийг хамарсан ган 2-3 жилд 1 удаа, нутгийн 50 хувиас илүү хэсгийг хамарсан ган 4-5 жилд 1 удаа тохиолддог бөгөөд тал хээр, говийн бүсийн нутгаар шороон шуургатай өдрийн тоо 21-р зууны босгон дээр 1960 оныхтой харьцуулахад 3-4 дахин нэмэгджээ. Энэ нь Баруун бүс нутагт 2002 онд 5- 9 дүгээр сард үргэлжилсэн гантай жил байлаа (Аззаяа, 2005).

Сөөгөн Интоорын 2005 онд дасан зохицох чадвар сайжирч, бусад жилүүдтэй харьцуулахад өсөлт хамгийн сайн байлаа. Ургалтын хурд сайн байгаа нь сортууд байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлд дасан зохицож байгаагийн нэг илрэл юм.

Интоорын ургалтанд 2005 он таатай жил байсан төдийгүй өмнөх жилтэй харьцуулахад соорт бүр ижил хэмжээнд жигд өссөн байлаа.

Найлзуурын ургалт VII.10- VIII.1- ны хооронд буурсан бөгөөд 2004 онтой харьцуулахад 10 хоногийн дараа эхэлж, мөн 10 хоногийн дараа дуусаж, удаашралт 20 хоногийн хугацаанд үргэлжилж байлаа.



6- р зураг. Мөчрийн өсөлт, тунадасны хамаарал

Сорт бүрийн мөчрийн өсөлт, агаарын тунадас хоорондын хамаарал нь 0.74-0.88 гэсэн эерэг хамааралтай байна.

Яст жимсний найлзуурын өсөлт тодорхой хугацааны турш харьцангуй удаан ургах ба энэ үед жимсний яс үүсэж хатуурах, жимсний махлаг эд томрох явц үргэлжилдэг. Энэ нь соорт бүрийн онцлогоос шалтгаалан харилцан адилгүй байх боловч гол төлөв 15-20 хоногийн хугацаанд үргэлжилдэг (Митов, 1990). Иймд жимсний махлаг эдийн хэмжээ томрох, жимсний яс үүсэх явц нь найлзуурын ургалттай эсрэг хамааралтай байна.


Бидний судалгааны дүнгээс үзвэл 2004 оноос сөөгөн Интоор жимсэлж,

эхэлсэн бол, 2004, 2005, 2006 онуудад найлзуурын өсөлтөнд бууралт ижил давтамжтай үргэлжилж байгаа нь ажиглалтын явцад илэрлээ. Судалгааны дүнгээс үзэхэд жил бүрийн цаг уурын өөрчлөлт, орчинзүйн онцлогоос хамаарч өсөлт янз бүр байгаа боловч 17- 23 хоногийн хугацаанд удаашралт үргэлжилж байгаа нь дээрх судлаачийн үр дүнтэй дүйж байна.


Соортуудын мөчрийн ба найлзуурын дундаж өсөлт 2005 онд хамгийн их байсан бол хамгийн бага 2002 онд өссөн байлаа /7, 8, 9,10,11,12-р зургууд/.

Аливаа ургамлын өсөлт, хөгжилт эхний жилдээ шинээр нутагшиж буй нутагт дасан зохицох үзэгдэл 1-2 жил үргэлжлээд зогсоогүй энэ нь мөчир, найлзуурын өсөлтөнд нөлөөлөхийг үгүйсгэх аргагүй юм.


Байгалийн тэнцвэрт байдал хаа сайгүй алдагдаж, газрын доройтол ихсэж байгаа энэ үетэй давхцан бидний судалгааны ажил хийгдсэн нь нутагшиж байгаа сөөгөн Интоорын соортуудын өсөлт, биежилтэнд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй зарим үед ургамлын үе шатууд удааширч байлаа.




7-р зураг. Максимовский сортын мөчрийн жилийн өсөлт /2002-2006/




8-р зураг. Максимовский сортын найлзуурын жилийн өсөлт /2002-2006/




9-р зураг. Змейногорская сортын мөчрийн жилийн өсөлти /2002-2006 /



10-р зураг. Змейногорская сортын найлзуурын жилийн өсөлт /2002-2006/



11-р зураг. Касмалинка сортын мөчрийн жилийн өсөлт /2002-2006/



12-р зураг. Касмалинка сортын найлзуурын жилийн өсөлт /2002-2006/

Дүгнэлт

1. Алтайн өндөр уулын тариалангийн бүсийн говийн бор хөрсөнд сорьж, нутагшуулж байгаа сөөгөн Интоор (*Prunus fruticosa (Pall.) Maxim.*)-ын Касмалинка, Змейногорский, Максимовский соортуудын суулгацыг талбайд суулгасан эхний 2 жилд 78,6-82,6 хувийн амьдралтай байв. Харин 4 дэх жилээс хөрсөн доороос үндэсний хэсгээс цурав үүсч 14,5-19,1 хувийн үлдэцээр сэргэж байна.

2. Касмалинка, Змейногорский, Максимовский соортуудын Жимсэлж эхлэхийн өмнөх 10 хоногийн явцаас үзвэл гурван жилийн дунджаар 6-р сарын нэг дэх 10 хоногт хамгийн эрчимтэй буюу 6.1-6.5 см өссөн байв. Ургалтын хугацааны хур тунадас, мөчрийн өсөлтийн хооронд мөчрийн хүчтэй эерэг (r=0.74-0.88) хамааралтай байв.

3. Жимсэлж эхэлснээс хойш мөчрийн өсөлтийн 10 хоногийн явц 7-р сарын 2 дахь 10 хоногт эрчимтэй өсөлтийн үеийнхээс 2.5-4.1 см-ээр буурч байгаа нь жимс бүрэлдэж, ид томрох, яст үр үүсэх үетэй давхцаж, шим тэжээлийн бодис хуваагдсантай холбоотой гэж үзлээ.

4. Жимсэлж эхэлснээс хойш мөчрийн өсөлтийн 10 хоногийн явц 7-р сарын 2 дахь 10 хоногт эрчимтэй өсөлтийн үеийнхээс 2.5-4.1 см-ээр буурч байгаа нь жимс бүрэлдэж, ид томрох, яст үр үүсэх үетэй давхцаж, шим тэжээлийн бодис хуваагдсантай холбоотой гэж үзнэ.

НОМ ЗОХИОЛ

Азаяа Д. Хэт халалт түүний нөлөө// Баруун бүс нутгийн уур амьсгалын нөөц, түүний өөрчлөлт. УБ, 2008, 169-177-р тал.

Очирбат Г. Ургамлын интродукци, УБ, 2001, 10-50 –р тал
Хандсүрэн Д. Чацаргана үржүүлэх биоэкологийн үндэс. Ховд, Алтайн бүсийн хөдөө аж ахуйн сургалт- эрдэм шинжилгээний хүрээлэнгийн бүтээл, №1, 20-24-р тал.

Хандсүрэн Д. Об итогах акклиматизации вишни в котловине Больших озёр, Аграрная наука- сельскому хоз. III Международная научно- практическая конф-я, книга-1, 2003, Барнаул.
Хандсүрэн Д., Очирбат Г.Некоторые результаты биохимического эксперимента с черешней птичьей (*Cerasus fruticosa. Pall.*)” Аграрная наука-Сельскому хозяйству. III Международная научно-практическая конференция Книга I, Барнаул. 554-556 с.

Хандсүрэн Д. “Алтайн бүсэд тарималжуулж байгаа (*Cerasus fruticosa Pall.*)-ын судалгааны ажлын дүнгээс. УГТЭШХ- ийн бүтээл № 27, 2009, 125-134-р тал.

Хандсүрэн Д. Алтайн бүсэд тарималжуулж байгаа (*Cerasus fruticosa Pall.*)-ын өсөлт,

хөгжилт, өвлийн тэсвэр” УИС-ын тех-гийн фак-т эрдмийн бичиг № 5, УБ, 2009, 162-172-р тал.

Доспехов. Б.А. Методика полевого опыта, Москва, 1979.

Мичурин И. В. Программа и методика сортоизучения плодовых ягодных культур Мичуринск, 1978, 24-83 с.

Петров А. и др. Биологично особености на растежа и плододаването на овошните растения. Пловдив, 1969

Митов.П., Ангелов. Т и др.“Периодичност на биологичните процеси в годишния цикл от живота на овошните растения, София, 1990.

Khandsuren, D. Badamkhand, D. Enkhsukh, G. Ochirbat “Some results of chemical stude of Cherry (*Serasus avium*) growing in Mongolia”, Annual Scientific Report №8(34), Ulaanbaatar, 2007, 202- 204 page

SUMMARY

RESULTS OF STUDY ON PLANTION SURVIVAL OF ACCLIMATIZED CHERRY (*CERASUS FRUTICOSA PALL. MAXIM.*) IN ALTAI REGION OF MONGOLIA D.Khandsuren¹

¹MSUA, Ecology and technology development school, department of ecology

Key words: Altai region, cherry, plantation survival, growth speed

Fruties and berries are one of the sources of healthy and good quality food products for human populations at present time of increasing the demand of foods day be day world wide.

This research lies on planting some cultivars cherry (which have high nutritional values) in Altai region of the country for the first time and studying their producibility.

The branch growth is different year after year depending on the climatic conditions. For instance, while, the Kasmalinka variety grew be 30.1 cm, in 2002, it grew by 57.9 cm in with abundant precipitations. This depends of precipitation distribution. In 2006 and 2008, the annual branch growth was 36,6-38,2 cm and growth speed was relatively good compared with previos year.

For the period after fruit set, the growth became slower. For example, for the second ten days of July it decreased by 2.5-4.1 cm in comparison to it's fastest growing stage. The reason is that the food reserve during this period is also divided for fruit maturity and stone formation.

In the sixth year of sow, the crown of Maksimovskaya was 105±3.0 cm tall which was taller than the other sorts by 7-10 cm and its stem thickness was 2.1±0.15 cm which was thicker than the other two by 0.3-0.5 cm.

Therefore these cultivars have been selected as Zmeinogorskaya a promising cultivar and Maksimovskaya a acclimatized cultivar capable to be planted in higher altitudes in Altai zone of Mongolia.

БОТАНИКИЙН ЦЭЦЭРЛЭГТ САРААНЫ (LILIUM L.) ТӨРЛИЙН ЦУГЛУУЛГА БҮРДҮҮЛЖ, УРГАЛ ЭРХТЭНЭЭР ҮРЖҮҮЛСЭН ДҮН

Л.Энхтуяа¹ Б.Хандмаа²
1ШУА, Ботаникийн хүрээлэн
2 ХААИС-ийн магистрант

Хураангуй

Ботаникийн цэцэрлэгийн нөхцөлд Дагуур сараана, Бушийн сарааныг болцуу, болцууны хайрс, нахиан болон нялх болцуугаар хуваан үржүүлж буй үр дүнг оруулав. Цаашид сарааны төрлийн ургамлыг үржүүлэн олшруулж хотын ногоон байгууламж болон цэцгийн аж ахуйд ашиглах бүрэн боломжтой юм.

Зангилаа үг: Сараана, болцуу

Оршил

Сарааны (*Lilium L*) төрлийн ургамлууд дэлхийн хамгийн үзэсгэлэнт цэцгийн тоонд ордог. Иш нь өндөр, нэг баг цэцгэндээ 20 гаруй цэцэгтэй байхаас гадна цэцгийн өнгө хурц тод, үнэр анхилуун сайхан голч нь 20 см хүрдэг. Ногоон байгууламжинд сарааны олон зүйл сортуудыг ашиглах боломжтой. Ургамлын өндөр, цэцгийн олон янзын хэлбэр, өнгө, цэцэглэлтийн хугацааг харгалзахаас гадна экологийн онцлогийг харгалзан үздэг. Дэлхийд ойролцоогоор байгалийн 114 орчим зүйл (Баранова, 1990), манай оронд 5 зүйл ургадаг (Грубов, 2008).

2009 онд Орос Холбооны Улсын Иркутск хотоос Сарааны 20 гаруй сортыг авчран тарьж цуглуулгыг баяжуулан тарималжуулан нутагшуулах судалгааг хийж байна. Улаан номонд *Lilium Buschianum Lodd, L.dahuricum Ker.-Gawl.* бүртгэгдсэн (Монгол Улсын Улаан ном, 1997, Тусгай хамгаалалттай... 2002). Байгаль цаг уурын хүчин зүйлээс гадна хүн амьтны зохисгүй үйл ажиллагаанаас болж сараанын тархалтын хүрээ хумигдаж байна. 200 гаад жилийн тэртээгээс Орос, Герман зэрэг улс оронд сараанын зүйлүүдийг эрлийзжүүлэх ажлыг хийж, хүйтэнд тэсвэртэй, үзэмжтэй том цэцэгтэй олон сортуудыг гарган авчээ (Баранова1990).

Судалгааны арга зүй

Орос Улсын Ерөнхий Ботаникийн цэцэрлэгийн нэгдсэн аргазүйг (1974) хэрэглэн ажиглалт судалгаа хийж, материал боловсруулалтыг Н.Т.Зайцевын (1978) аргаар боловсруулав.

Судалгааны үр дүн

ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгийн өвслөг ургамлын цуглуулганд Монгол орны Сарааны 4 зүйлийг цуглуулаад байна. Үүнд: *Lilium Buschianum Lodd.-ийг* Дорнод аймгийн Сүмбэр сумын Хянганаас, *L.dahuricum Ker.-*

Gawl.-ийг Дорнод аймгийн Сүмбэр сумын Хянган, Эрээн даваа, Онон голын зүүн урьд биеээс, *L.martagon* L.-ийг Сэлэнгэ аймгийн Шарын гол, Моностойн ам, Зүүнхараа, Тарниас, *L. pumilum* DC.-ийг Улаанбаатар хот орчим, Сэлэнгэ аймгийн Атарын САА-гаас тус тус цуглуулсан болно.



1-р зураг. *Lilium pumilum* DC.

2-р зураг. *Lilium martagon* L.



3-р зураг. *Lilium Buschianum* Lodd.

4-р зураг. *Lilium dahuricum* Ker.-Gawl.

ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт Улаан номонд (Монгол Улсын Улаан ном, 1997) орсон нэн ховор эдгээр ургамлын амьд цуглуулгыг бүрдүүлэх, генофондыг үр болон үржлийн материал болцуугаар хадгалах, ургал эрхтэнээр үржүүлснээр (үр, болцууны хайрс, нахиан болон нялх болцуу, болцууг хувааж) био бүтээмжийг нэмэгдүүлж үржүүлэн олшруулах материалыг бүрдүүлэв. Сарааны үзэгдэлзүйн үе шатны шилжилт: 2007-2009 оны үзэгдэлзүйн ажиглалтын дундажаар *Lilium Buschianum* Lodd, *L.dahuricum* Ker.-Gawl нь V.26-наас сэргэн ургаж, V.30-наас навч задарч, VI.10-наас навч бүрэн задарч, VI.14 –нээс бундуу үүсэн, VI.20-ноос эхлэн цэцэглэж, VII.15-наар цэцэглэж дуусав. Ургалтын үргэлжлэх хугацаа нь Ботаникийн цэцэрлэгийн нөхцөлд 110 хоног, цэцэглэлтийн тасралтгүй үргэлжлэх хугацаа 23 хоног байв.

Тарималжих ургамлын онооны үнэлгээгээр Сараанын төрлийн ургамлууд маш ирээдүйтэй буюу 15-18 оноо, ирээдүйтэй буюу 10-14 оноогоор үнэлэгдэж байна.

Ургал эрхтэнээр үржүүлсэн судалгаа: *Lilium Buschianum* Lodd, *L.dahuricum*

Ker.-Gawl зүйлийг Дорнод аймгийн Нөмрөгийн Дархан газраас алаг өвст элсэрхэг хээр, нуга, ойн цоорхой, чийглэг хөндийн нутгаас тус тус 2002 онд цуглуулж, Ботаникийн цэцэрлэгт анх удаа болцуу, болцууны хайрс, нахиан болон нялх болцуу, болцууг хуваан үржүүлэн эх материалтай болов. Сарааныг ургал эрхтэнээр үржүүлэх нь цэцгийн аж ахуйн практикт хамгийн өргөн тархсан хэлбэр юм. Ургал эрхтэнээр үржүүлэхдээ 6-р сарын эхний 10 хоногт хийсэн болно.

Дагуур сарааны 8,5 см голчтой нийт 60 ширхэг болцууг цуглуулгын талбайд тарихад 98% нь ургасан. Гурав дахь жилдээ 80% нь цэцэглэж үрлэсэн болно. Бушийн Сарааны ургал эрхтэнээр үржих чадвар нь Дагуур сараантай харьцуулахад доогуур зөвхөн болцуугаар үржиж байна. Дагуур сарааныг болцууны хайрсаар 80%, нялх болцуугаар 60-75%, болцууг хувааж үржүүлэхэд 90% байгаа нь бусад сараанаас хамгийн өндөр үржих чадвартай болох нь туршлагын ажлын үр дүнд харагдлаа (1-р хүснэгт, 5-р зураг).

1-хүснэгт. Сарааны болцууны амьдралт


Зүйлийн нэр	Т а р ь с а н болцуу, ш	Болцууны голч, см	Амьдралтын хувь, эхний жилд
Дагуур сараана	᠖᠑	᠘,᠕	᠑᠘
Бушийн сараана	᠖᠐	᠕,᠐	᠔᠘

Зүйлийн нэр Тарьсан болцуу, ш Болцууны голч, см Амьдралтын хувь, эхний жилд

Дагуур сараана 60 8,5 98

Бушийн сараана 60 5,0 48

Цэцгийн аж ахуй практикт ургал эрхтэнээр үржүүлэх арга аргачлал байдаг боловч Ботаникийн цэцэрлэгт Дагуур сарааныг болцууны хайрс, нялх болцуу, том болцууг хуваан үржүүлэх аргыг судалгааны үр дүнд боловсруулан гаргав.



5-р зураг. Дагуур сарааныг ургал эрхтэнээр үржүүлсэн амьдралтын хувь

Үрээр үржүүлэх: Энэ арга нь түгээмэл дэлгэрсэн хамгийн сайн аргын нэг бөгөөд ихээхэн хэмжээгээр тарьж ургуулахад тохиромжтой юм. Сарааны зарим үр эхний жилдээ соёолж байхад зарим үр нь дараа жил соёолох учир үр

тарьсан сав буюу газраа хоёр зун арчилж ажиглах нь зүйтэй. Үрийг суулгах газар ус тунадаггүй наранд ээвэр нөмөр газрыг сонгох нь зүйтэй. Хөрс нь маш хөнгөхөн хүрз гишгэхэд чөлөөтэй байх хэрэгтэй. Бие гүйцсэн товарийн болцуу болоход 3-7 жил болно. Иймээс ургал эрхтэнээр үржүүлэхэд цаг хугацаа хэмнээд зогсохгүй .

Болцууны хайрсаар үржүүлэх: Ухаж авсан болцуугаа ангилан томыг ялган аваад гадна талын том хайрсуудыг ялган авч салгана. Ялгасан хайрсуудаа зассан талбайдаа 8-10 см зайтай суулгаад хөнгөхөн шороогоороо булж өгөөд шүршүүрээр усалсны дараа плёнкоор хучиж өгнө. Ингээд 14 хоногийн дараа цухуйц гарч эхэлдэг. Хэрэв салгаж авсан даруйдаа суулгаж чадахгүй бол 7 хоног чийгтэй үртэсэнд хадгалж байгаад тарьж болно.



6-р зураг. Дагуурын сарааныг болцууны хайрсаар салгахын өмнө

Нялх болцуугаар үржүүлэх: Сарааны иш буюу үндэслэг ишний хөрсний дээд давхарга үнд бяцхан төл болцуу үүсдэг. Сарааныг бундуужиж эхэлмэгц цэцгийн бундууг тасдаж аваад ишний угийг тойруулан шороогоор хучивал нялх болцуу үүсэх явц түргэсдэг. Мөн сарааны ишийг тахийлган газарт налуулаад тал талаас нь илүү шороогоор дарвал нялх төл болцуу үүсэлт сайжирдаг. Бас сарааны ишийг дагавар үндэсний хамт болцуунаас салган авч суулгахад нялх төл болцуу үүсдэг. Үржүүлэхэд зориулж бойжуулсан нялх болцууг суулгасанаас хойш 2 жилийн дараа цэцэглэж эхэлнэ.



7-р зураг. Нялх болцууг тарихад бэлтгэсэн байдал 8-р зураг. Дагуурын сарааныг болцуугаар хувааж үржүүлсэний дараа

Болцууг хуваан үржүүлэх: Сарааны болцууны ёроолд буюу газрын доорхи хэсэгт үндэслэг ишэнд жил бүр залуу болцуу буй болж хөгжин, 2-3 жилийн дараа болцууны бүхэл бүтэн үүр болдог. Энэ үүр нь 4-5 жилийн дараа болцуу нь жижгэрч цэцэглэлт багасаж эхэлдэг. Иймээс шилжүүлэн суулгах шаардлагатай болдог. Олон болцуунуудыг бие биенээс нь гараараа салгах ба үндэслэг ишийг бол хутгаар огтлож салгана. 4 жилийн дараа 1 болцуунаас 5-6 буюу түүнээс илүү болцуу авдаг. Болцууг хуваахдаа хавар 5-р сард юмуу намар 8, 9-р сард хуваахад тохиромжтой.

Дүгнэлт

Ботаникийн цэцэрлэгийн өвслөг ургамлын цуглуулгын талбайд Сараанын төрлийн *Lilium Buschianum* Lodd., *L.dahuricum* Ker.-Gawl., *L.martagon* L., *L. pumilum* DC зэрэг 4 зүйлийг цуглуулав. Ботаникийн цэцэрлэгийн нөхцөлд *L.dahuricum* Ker.-Gawl- ийг болцуу, болцууны хайрс, нахиан болон нялх болцуу, болцууг хуваан үржүүлэхэд 60-90 %-ийн амьдралттай байгаа нь цаашид үржүүлэн олшруулж хотын ногоон байгууламж болон цэцгийн аж ахуйд ашиглах бүрэн боломжтой юм.

Ном зохиол

Монгол Улсын Улаан ном. УБ., 1997. 311-312 р тал
Тусгай хамгаалалт газар нутгийн сүлжээ, үнэлгээ өргөжүүлэх асуудал. УБ., 2002. 33-35-р тал
Баранова М.В. Лилии. Ленинград МО “Агропромиздат” Ленинградское отделение.: 1990 107 с
Грубов В.И. Монголын гуурст ургамал таних бичиг. УБ.: 2008. 79-р тал
Зайцев Г.Н. Фенология травянистых многолетников. Т., Изд-во АН СССР, ГБС, 1978. 254 с
Методика фенологических наблюдений в ботанических садах СССР // Совет ботанических садов СССР. М.: 1974.9 с

Summary

The collection of *Lilium* L at the Botanical Garden and Results of breeding of Lily through its vegetative organs

L.Enkhtuya1 B.Khandmaa2
1Institute of Botany,MAS
2 Mongolian State University of Agriculture

Key words: *Lilium*,bulb

The following four species of *Lilium* genera were collected at the herbal plant collection of the Botanical Garden.

Lilium Buschianum Lodd., *L.dahuricum* Ker.-Gawl., *L.martagon* L., *L. pumilum* DC.

The breeding of *Lilium dahuricum* Ker.-Gawl. by separating its bulb, bulb scale and young bulb has 60-90 percent of survival, which shows that it possible to further reproduce and cultivate it in urban greenery and for floricultural practice

УРГАМЛЫН БИОТЕХНОЛОГИ, БИОХИМИ

TRANSFORMATION OF RICE (*Oryza sativa* L.)

Bolormaa Dogsom¹, Choon-Hwan Lee¹

¹Department of Molecular Biology, Pusan National University, Republic of Korea

Abstract

PsbS is a 22-kDa protein of photosystem II involved in nonphotochemical quenching of chlorophyll fluorescence but the mechanism is still unclear.

We designed and generated transgenic rice plants with significantly reduced PsbS1 protein level using RNA interference (RNAi). Transformation confirmed by vector-specific primers and transformants were screened by RT-PCR for *OsPsbS1* transcript levels and PsbS1 protein level. We could identify three PsbS1-RNAi lines.

Keyword: Rice (*Oryza sativa*.), PsbS1, RNAi, transformation

Introduction

Rice (*Oryza sativa*.) is the most important staple food for a large part of the world's human population. It is the grain with the second-highest worldwide production, after maize.

Rice is emerging as a model cereal for molecular biological studies. The main reasons for this are as follows: 1. The complete genome has been sequenced. 2. Tools for functional genomics are available. 3. Production of transgenic plants is relatively easy compared to that of other major cereals.

Light is one of the most important environmental factors that control the growth and development of plants. The synthesis of many component proteins of photosynthesis, which are encoded by nuclear and chloroplast genes, is positively regulated by light at the level of transcription.

PsbS1 is necessary for photoprotective thermal dissipation (qE) of excess absorbed light energy in plants, measured as non-photochemical quenching of chlorophyll fluorescence (Krishna, 2004). But the mechanism of qE is still unclear.

RNA interference (RNAi) is a post-transcriptional gene-silencing phenomenon induced by double-stranded RNA. It has been widely used as a knockdown technology to analyze gene

function in various organisms (Makoto, 2004). During the 1990s, a number of gene silencing phenomena that occur at the post-transcriptional level were discovered in plants, fungi, animals and ciliates (Abdolhamid 2010).

Materials and Methods

Preparation of callus. Mature seeds of rice (*Oryza sativa* cv. Dongjin) were used as explants material in this experiment. Seed of rice were sterilized with 70% ethanol for 1 min, followed in 4% sodium hypochlorite solution containing 20 ul Tween 20 for 15 min, and then rinsed three times with sterilized distilled water.

16 seeds were plated in Petri dish (90mm in diameter) containing 25 ml of callus induction medium and sealed with micropore surgical tape.

Cultures were incubated at 25°C and 18 hours photoperiod of 45µmol m⁻²s⁻¹ illumination provided by cool white fluorescent lamps. Summary of mediums used in the tissue culture and transformation system of *Oryza sativa* were shown in **Table 1**.

Table1. Summary of medium used in the tissue culture and transformation

Type of medium	Composition
Callus induction	N6 salts and vitamins, myo-inositol 100mg/L, 30g/L sucrose, 2mg/L 2,4-D, 3g/L gelrite, pH=5.8
Agrobacterium culture	LB medium supplemented with 50 mg/L hygromycin, pH=7.0
Agrobacterium suspension	AA medium and B5 vitamins, 20g/L sucrose, 2mg/L 2,4-D, 0.2mg/kinetin, pH=5.8, 30mg/L acetosyringone
Co-cultivation	Calcium free N6 and vitamins, 30mg/L sucrose, 10g/L glucose, 2 mg/L 2,4-D, 120 mg/L betaine, 3g/L gelrite, pH=5.2, 30mg/L acetosyringone
Agrobacterium elimination	N6 salts and vitamins, myo-inositol 100mg/L, 30g/L sucrose, 2mg/L 2,4-D, 3g/L gelrite, pH=5.8, cefotaxime 250 mg/L
Shoot induction	MS salts and vitamins medium supplemented with myo-inositol 100mg/L, 15g/L sucrose, 30 g/L sorbitol, 4g/L casamino acid, 0.5 g/L NAA, 2mg/L BA, 0.5 g/L L-proline, 4g/L gelrite, pH=5.8, 250mg/L carbenicillin, 30mg/L hygromycin
Root induction	MS medium supplemented with myo-inositol 100mg/L, 30g/L sucrose, 8g/L agar, pH=5.8, 100mg/L carbenicillin, 50mg/L hygromycin

Plants and growth conditions

One-month-old seedlings of WT and PsbS1-knockout, PsbS1-RNAi mutant rice (*Oryza sativa* L.) plants were grown in soil in a greenhouse under sunlight or in a culture room at an irradiance of 200 µmol photons m⁻²s⁻¹ white light (16/8 h light – dark cycle) at a temperature of 28±2°C (28°C /22°C temperature cycle). For some experiments, rice seeds were germinated and grown on nutrient Murashige and Skoog (MS) solid agar medium for one week.

Generation of *OsPsbS1*-RNAi Transgenic Rice

To generate RNA interference vector of *OsPsbS1*, gene fragment of 102 base pair size was amplified by PCR using primers (Forward primer: 5'- ATA GGA TCC CTC GAG CGC GCG GTG TCC GTC AAG AC-3', Reverse primer: 5'- GCG

GAA TTC AAG CTT GTC CTC GGT CTT GAA CTT TG-3'), and the fragment was cloned

into XhoI-HindIII, BamHI-EcoRI sites of pFGL727 (pBSIIKS-Intron). The SacI-KpnI fragment of the pBSIIKS-Intron-OsPsbS1 was transferred into SacI-KpnI sites of pGA1611. The name of final construct is pFGL702. The OsPsbS1- RNAi plasmid was then transformed into rice using *Agrobacterium* strain LBA4404, as described previously (Dai et al., 2001).

Reverse transcription polymerase chain reaction (PCR) with an internal standard

Total cellular RNA was isolated from plant leaves using TRIzol REAGENT® (Life Technologies, USA) according to the manufacturer's instructions. Reverse transcription was performed according to the manufacturer's protocol using RNA samples with RQ1 RNase-free DNase (Promega) and M-MLV (Promega). RNA quality was monitored using the ratio of absorbance at 260 nm and 280 nm and by ethidium bromide staining following gel electrophoresis. The standard PCR conditions involved initial heating at 94°C for 5 min followed thereafter by 35 cycles of denaturation at 94°C for 30 sec, primer annealing at 56°C for 30 sec and primer extension at 72°C for 30 sec. The cycles were followed by a final extension at 72°C for 10 min. The final PCR products (10 µl) were analyzed on 1.5% (w/v) agarose gels.

Immunoblotting analysis of the PsbS1 protein

For RNA extraction and immunoblot analysis, leaves were harvested 3 h into the light period, frozen immediately in liquid nitrogen, and then stored at -80°C. Isolation of thylakoid membranes for immunodetection of proteins was performed as described by Oh et al. (Oh et al., 2003). Thylakoid membranes equivalent to 2~10 µg Chl were solubilized in buffer composed of 62.5 mM Tris-HCl, 10% glycerol, 10% SDS, 2.5% β-mercaptoethanol and 6 M urea for 30 min at room temperature. D1 protein analysis was performed according to the procedure of Miyao (Miyao, 1994). After SDS-PAGE, proteins were transferred to nitrocellulose membranes for immunoblotting. After washing, they are incubated with HRP-conjugated secondary antibody (Amersham). The ECL detection system (Amersham) was used to visualize the protein bands.

Result and discussion

Isolation of a rice PsbS1 knock-out line and generation of PsbS1-RNAi transgenic plants

To confirm that the PsbS1-KO phenotype was caused by the insertion in the *OsPsbS1* gene and not by insertion of multiple T-DNAs or other uncontrolled genetic variations including chromosomal rearrangements, inactivation of loci where the T-DNA is inserted, etc, we generated transgenic rice plants with significantly reduced PsbS1 protein level using RNA interference (RNAi). Rice plants were transformed with an RNAi construct consisting of an inverted repeat of a unique 102 bp region of the *OsPsbS1* gene, with a portion of the pBSIIKS vector as a linker, driven by ubiquitin I promoter (Figure1).



Figure 1. Schematic diagrams of the rice PsbS genes and insertion positions of T-DNA.

RB- right border; UBI promoter- ubiquitin I promoter; *OsPsbS1* an inverted repeat of a unique 102 bp of the coding region of PsbS1 gene; Intron- a portion of the pBSIIKS vector; Tnos; LB- left border

Transformants (Figure 2) were screened by RT-PCR for *OsPsbS1* transcript levels (Figure 3A) and confirmed by Western blotting (Figure 3B), where we could identify three PsbS1-RNAi lines with varying *OsPsbS1* transcript and PsbS1 protein levels. Among them, the PsbS1-RNAi#2 line produced very little PsbS1.




Figure 2. *Agrobacterium tumefaciens*-mediated transformation of *Oryza sativa* L




Figure 3. Characterization of the PsbS1-KO and PsbS1-RNAi rice plants.

A. The transcript level of the PsbS1 gene in WT, PsbS1-KO, PsbS1-RNAi construct and Vector only rice plants. The numbers are lines of the PsbS1-RNAi transformants. B. Western blot analysis of the PsbS1-RNAi transformants and vector only rice plants. WT and PsbS1-KO rice plants used as positive and negative control.

Conclusion

1. We designed and transformed PsbS1-RNAi construct to rice plants.
2. Transformation confirmed by vector-specific primers and by germination of seeds in media with hygromycin.
3. Transformants were screened by RT-PCR for *OsPsbS1* transcript levels, and three PsbS1-RNAi lines without *OsPsbS1* transcript level were identified.

REFERENCE

- Abdolhamid Angaji¹, Sara Sadate Hedayati¹, Reihane Hosein poor¹, Sanaz Samad poor¹, Shima Shiravi¹, Safoura Madani (2010) Application of RNA interference in plants POJ 3(3):77-84
- Dai, S., Zheng, P., Marmey, P., Zhang, S., Tian, W., Chen, S., Beachy, R.N., and Fauquet, C. (2001). Comparative analysis of transgenic rice plants obtained by Agrobacterium-mediated transformation and particle bombardment. Mol. Breed. 7: 25–33.
- Krishna K. Niyogi, Xiao-Ping Li, Vanessa Rosenberg and Hou-Sung Jung (2004) Is PsbS the site of non-photochemical quenching in photosynthesis? Journal of Experimental Botany, Vol. 56, No. 411
- Makoto Kusaba (2004) RNA interference in crop plants Current Opinion in Biotechnology, 15:139–143
- Miyao, M. (1994). Involvement of active oxygen species in degradation of the D1 protein under strong illumination in isolated subcomplexes of photosystem II. Biochemistry 33: 9722–9730.
- Oh, M.-H., Moon, Y.-H., and C.-H. Lee. (2003). Increased stability of LHCII by aggregate formation during dark-induced leaf senescence in the *Arabidopsis* mutant, *ore10*. Plant Cell Physiol. 44: 1368-1377.

ЦАГААН БУДААНЫ (*Oryza sativa* L.) МУТАНТЫГ ГАРГАН АВСАН
СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮНГЭЭС

Д. Болормаа¹, Choon-Hwan Lee

¹Солонгосын Пусаны Улсын Их Сургуулийн Молекул биологийн Тэнхим

Зангилаа үг: цагаан будаа, трансген ургамал, мутант

Хураангуй

Дэлхийн хүн амын хүнсний гол үр тарианы ургамал болох цагаан будаа (*Oryza sativa*) хэрэглээгээрээ эрдэднэшишийн дараа ордог. Цагаан будаа молекул биологийн судалгааны загвар ургамалд зүй ёсоор тооцогдох бөгөөд түүний геном бүрэн тогтоогдсон тул түүний үйл ажиллагааг судлах нь зайлшгүй чухал юм. Трансген цагаан будааг бусад үр тарианы томоохон төлөөлөгчидтэй харьцуулан судлахад хялбар бөгөөд түүний ургал, хөгжилд нөлөөлдөг бөөмийн болон хлоропластын генүүдээр кодлогддог фотосинтезийн гол бүрэлдэхүүн уургууд нь транскрипцийн төвшиндөө гэрлээр зохицуулагддаг онцлогтой.

Судалгааны үр дүнд бид цагаан будааны PsbS1-RN_{Ai} мутантыг гарган авч, транскрипцийн төвшинд нь RT-PCR болон Western blot-ын аргаар шалгасан. PsbS1-RN_{Ai} мутант нь фотосистем II-ын PsbS1 уургийг нийлэгжүүлэхгүй knock-out болсон бөгөөд фено типээрээ PsbS1 T-DNA knock-out мутантай адил шинж тэмдгийг үзүүлсэн онцлогтой юм.

ЗАРИМ УРГАМЛЫН БИОЦИД ҮЙЛЧИЛГЭЭГ
СУДАЛСАН ҮР ДҮНГЭЭС

С.Дэлгэрмаа¹, С.Цэрэндулам²

¹ ШУТИС, Хүнсний инженер биотехнологийн сургууль

² ШУТИС, Үйлдвэрлэлийн технологи, дизайны сургууль, Нэхмэлийн хүүрээлэн

Хураангуй

Судалгааны үр дүнд боловсруулаагүй ноосноос гэмтэл үүсгэгч бактери болон хөгц мөөгөнцөрийг ялган авч, түүний микробиологийн шинж чанарыг судаллаа. Ноос, ноолууран бүтээгдэхүүний чанарт сөрөг нөлөө үзүүлэгч бичил биетний өсөлт үржлийг зогсоох зорилгоор бактерийн эсрэг үйлчилгээтэй зарим ургамлыг сонгон авч бичил биетний эсрэг үзүүлэх нөлөөг судалсан зарим дүнгээс толилуулж байна.

Зангилаа үг: бактери, өсгөвөр, хөгц мөөгөнцөр, биоцид бодис

Удиртгал

Манай орны үйлдвэрлэлийн чухал салбарын нэгд хөнгөн үйлдвэр, ялангуяа ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл зүй ёсоор орно. Ноос, ноолууран бүтээгдэхүүн биологийн эвдрэлд өртөмтгий байдаг тул боловсруулах явцад төрөл бүрийн химийн бодисыг ашиглаж ирсэн. Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээр биологийн арга ашиглан боловсруулсан ноос, ноолууран бүтээгдэхүүний борлуулалт өндөр хувьтай байна. Бид ноос, ноолууран бүтээгдэхүүний боловсролтийг боловсронгуй болгох зорилгоор биологийн оновчтой аргыг эрж хайх зорилт тавин ажиллаа.

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

Судалгааны ажлын хүрээнд төрөл бүрийн ургамлаас бактерийн эсрэг үйлчилгээт биоцид бодис ялган авч, ноос боловсруулах явцад туршихаар туршилт судалгааг явуулав. Судалгаагаар боловсруулаагүй ноосноос бичил биетэн ялган авч, тэдгээрийн ангилалзүйн хамаарлыг тодотгож улмаар зарим нэг ургамлын хандыг ашиглан биоцид үйлчилгээ үзүүлж буй эсэхийг нарийвчлан тогтоов.

Олон тооны түүхий эд материалаас шаардлагад нийцсэн боловсруулаагүй монгол хонины ноос, торомны ноос зэргийг сонгон дээж материалаа боловсруулан микробиологийн нарийвчилсан аргазүйн дагуу бактери, хөгц мөөгөнцөрийн өсгөврийг ялган гаргаж авсан. Ялган авсан бактериуд гол төлөв спор үүсгэдэг савханцар хэлбэрийн *Bacillus* төрлийнх бол хөгц мөөгөнцөр Аспергилиус, Пенициллины төрөлд хамаарах биотууд байна. Хонины ноосноос ялган авсан бактери дотор *Sarcina* төрлийн кокки хэлбэрийн бактериуд давамгайлж тэмдэглэгдлээ.

Харин ургамлын ханд бэлтгэхдээ *Rheum undulatum* L., *Thymus dahurica* L., *Plantago major* L., *Chelidonium majus* L., *Urtica dioica* L. зэрэг ургамлын газрын дээд ногоон массаас дээж материалыг ашиглаж зохих концентраци бүхий хандалсан уусмалыг бэлтгэв.

Судалгааны үр дүн

Бидний туршилт судалгааны явцад ялган гаргаж авсан бактериуд МПШ /макс-пептоны шил/ дээр нимгэн хальс, зарим споргүй савханцар нь тунадас үүсгэж байсан онцлогтой. Янз бүрийн нүүрс уст 9 гаруй орчинд ялгаж авсан бактериудын нүүрс ус шингээх чадварыг тодорхойлоход зарим өсгөврүүд лактозыг задалж, шингээдэггүй бол цөөн тооны нэг хэсэг өсгөвөр сахароза, сорбит зэргийг шингээх чадваргүй нь ажиглагдсан. Харин бусад олон тооны өсгөвөр нүүрс усыг сайн шингээж байв.


Мөн ихэнхи өсгөвөр цардуулыг задалж чадах шинж чанартай болох нь ажиглагдаж улмаар нийлмэл тэжээлт орчинд үржиж ургалт өгч байлаа. Харин азот шингээх чадварыг тодорхойлоход ихэнх өсгөвөр харьцангуй өндөр үзүүлэлттэй гарсан. Нитратаас нитрит үүсгэх мөн хүхэрт устөрөгч үүсгэх чадвар олон тооны өсгөвөрт илүү ажиглагдлаа. Хүчилтөрөгч ашиглах чадвараараа ихэнхи нь факультатив анаэроб шинжтэй байхад зөвхөн №13 дугаар бүхий өсгөвөр аэроб шинжтэй нь батлагдсан. Ихэнхи спор үүсгэгч бактерийг урьдчилсан байдлаар *Bacillus subtilis*- ийн ангилалд хамааруулж авч үзлээ. Энэ бактериуд пептид болон целлюлоз зэрэг бодис элементийг задлах өндөр чадвартай байдаг. Харин бидний ялган гаргаж авсан хөгц мөөгөнцөрийн хувьд ихэнх нь ногоон өнгийн колонтой пенициллины төрөлд хамаарагдаж буй нь тодорхой бөгөөд харин торомны ноосноос Аспергилиусын төрлийн хөгц мөөгөнцөр давамгайлан илэрсэн онцлог талтай. Ноосноос ялган авсан бактери болон хөгц мөөгөнцөрөө И.Н. Ермиловагийн арга зүйн дагуу биоцид үйлчилгээтэй гэж тооцогдох доорх Гишүүн (*Rheum undalatum* L.) Халгай (*Urtica dioica* L.) Шүүдэргэнэ (*Chelidonium majus* L.) зэрэг гурван ургамлын хандалсан уусмал бүхий тэжээлт орчин дээр өсгөвөрлөх замаар үйлчилгээг тогтоосон болно. Үр дүнг 1-р хүснэгтэд үзүүлэв.

Уг хүснэгтээс харахад, бактерийн өсөлтийг сонгон авсан ургамлуудаас *Urtica dioica* L., *Rheum undalatum* L. ургамлуудын уусмал дарангуйлж байна. Уг зүйлүүдийн хандалсан уусмалыг агуулсан тэжээлт орчин дээр бактерийн колонны тоо буурч, зарим нь ямар ч ургалт өгөхгүй байна. Харин хөгц мөөгөнцөрийн өсөлтийг *Chelidonium majus* L. хандалсан уусмал илүү сайн дарангуйлж буй нь ажиглагдлаа (1-р зураг).


1-р хүснэгт. Сонгон авсан ургамлын хандтай орчин дээр ургасан колонны тоо /48 цаг/

Өсгөвөрийн дугаар	Хяналт	Ургамлын нэр		
		<i>Rheum undalatum</i> L.	<i>Urtica dioica</i> L.	<i>Chelidonium majus</i> L.
Бактерийн өсгөвөр				
№1	23	-	-	30
№6	500	500	-	-
№9	500	-	500	500
№7	500	270	500	100
№11	290	280	100	150
№12	500	500	350	500
№13	250	250	-	125
Хөгц мөөгөнцөрийн төрөл				

<i>Penicilium</i>	ᠪᠢᠭ	ᠪᠢᠭ	ᠳᠦᠴ	ᠳᠢᠭ
<i>Aspergillus</i>	ᠳᠠᠭ	ᠳᠢᠭ	ᠳᠢᠳ	ᠳᠢ
<i>Trichoderma</i>	ᠳᠢᠭ	ᠳᠠᠳ	ᠳᠢᠭ	-



1-р зураг. E.coli колонны тооны өөрчлөлт (ургамлын 60% ханд)



2-р зураг. Хөгц мөөгөнцөрийн колонны тоо (ургамлын 60% ханд)

Дээрх ургамлуудын хандалсан тэжээлт орчин дээр колонны тооноос гадна колонны хэмжээг тодорхойлсон дүнг дараах 2-р хүснэгтээр харуулж байна.

2-р хүснэгт. Колонны хэмжээ /48 цагийн дараа/

Өсгөврийн дугаар	Хяналт	Ургамалын нэр		
		<i>Rheum undalatum</i> L.	<i>Urtica dioica</i> L.	<i>Chelidonium majus</i> L.
Бактерийн өсгөвөр				
№1	5 см	4.5см	5см	5см
№6	7 см	5см	4.5см	6см
№9	5см	5см	8см	7см
№7	5см	4.5см	4см	5см
№11	5.5см	5см	4см	4.5см
№12	9см	4.5см	5см	9см
№13	9см	5см	5.5см	9см
Хөгц мөөгөнцөрийн төрөл				
<i>Penicilium</i>	5.1см	4.1 см	2.4см	1см
<i>Aspergillus</i>	9см	7.4см	9см	6см
<i>Trichoderma</i>	ᠳᠦᠴ	ᠳᠢ	ᠳᠢᠴ	-


2-р хүснэгтээс харахад, *Urtica dioica* L. бүхий хандалсан уусмалт орчин өсгөврийг илүү сайн дарангуйлж буй нь ажиглагдлаа. Мөн №9 дугаар бүхий өсгөврийн хувьд *Chelidonium majus* L. болон *Urtica dioica* L. зэрэг ургамлуудын хандалсан уусмал өсөлтийг сайн дэмжсэн нь ажиглагдлаа. Харин *Chelidonium majus* L. хандалсан уусмалын тэжээлт орчин дээрх бактерийн колонь хэмжээ бараг жижигэрч өөрчлөгдөөгүй байгаа байдал тэмдэглэгдлээ. Иймд уг бактерийн өсгөврийн хувьд өөр ургамлын уусмал хандыг шилж сонгох нь зүйтэй гэж үзэж үзлээ. Хөгц мөөгөнцөрийн хувьд өсөлтийг нь *Chelidonium majus* L.-ийн хандалсан уусмал илүү дарангуйлж байна. Харин *Urtica dioica* L. бүхий хандалсан уусмалт орчин Аспергилиусын төрлийг дарангуйлах чадваргүй байгаа нь тогтоогдлоо.

Ургамлын хандалсан уусмалын биоцид үйлчлэлийг нарийвчлан тогтоохын тулд дээрх уусмалууд дахь химийн бүрэлдэхүүн хэсгүүдийг илрүүлэхийг зорьж туршилт судалгааг тавилаа. Бид сонгож авсан дээрх ургамлын хандалсан уусмалуудыг тодорхой нэр төрлийн органик уусгагчийн тусламжтайгаар хандлаад Драгендорфын уусмалаар шүршиж, нимгэн үеийн хроматографийг явуулсан. Туршилтын явцын дүнд *Chelidonium majus* L. хандалсан уусмалд туйлт алкалоид илэрч буй нь ажиглагдсан. Спектрофотометрийн аргаар долгионы 254нм, 365нм уртад хэмжилтийг явуулахад уг алкалоид нь шар толбо үзүүлж байлаа (3-р зураг).




3-р зураг. Нимгэн үеийн хроматографи (1–254 нм, 2- 365нм, 3-Драгендорфын уусмал)

Мөн энэхүү хандалсан уусмалууд дахь химийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тогтоох туршилт судалгаагаар уг *Chelidonium majus* L. ургамал дахь флаванонид бодисыг илрүүлэх явцад рутиныг илрүүлж тогтоосонг 4-р зурагт үзүүлэв.



4-р зураг. *Chelidonium majus* L. –ийн хандалсан уусмал дахь рутиныг илрүүлэхэд рутин тригидраттай харьцуулсан хроматограмм

Энэхүү нимгэн үеийн хроматографийн аргаар туршсан судалгааны дүнг баталгаажуулахын тулд бид шингэний хроматографийн багажин дээр туршилтыг давхар хийсэн. Ингэхэд *Chelidonium majus* L. хандалсан уусмалт орчинд бид рутин байгааг дахин тогтоосон. Үүнд, рутины стандарт уусмалыг эталон болгон ашигласан болно (5-р зураг).



5-р зураг. Шингэний хроматографийн харьцуулсан бичиглэл

Дүгнэлт

Туршилт судалгааны дүнд боловсруулаагүй ноосноос бичил биетэн ялган авч, тэдгээрийн ангилалзүйн хамаарлыг тодотгоход спор үүсгэгч, савханцар хэлбэрт бактери ихэнх хувийг эзэлж байна.

Ноос, ноолуурыг гэмтээгч мөөгөнцөрүүд Пенициллин, Аспергилиусын төрлийн хөгц мөөгөнцөр болох нь тодорхойлогдлоо.

Бичил биетний өсгөврийг *Rheum undalatum* L., *Urtica dioica* L., *Chelidonium majus* L. зэрэг ургамлын хандалсан уусмалын тэжээлт орчин дээр өсгөвөрлөж колонь тоо, хэмжээний өөрчлөлтийг тодорхойлоход *Urtica dioica* L. бактерийн колонь багасгаж, дарангуйлах үйлчилгээ үзүүлж, харин *Chelidonium majus* L. хандалсан уусмал дээрх үйлчилгээ үзүүлэх чадваргүй байгаа нь тогтоогдлоо.

Хөгц мөөгөнцөрийн хувьд *Rheum undalatum* L. хандалсан уусмал илүү дарангуйлах үйлчилгээ үзүүлсэн. Харин *Urtica dioica* L. хандалсан уусмалт орчин Аспергилиусын төрлийн хөгцний эсрэг үйлчилгээ үзүүлэхгүй байна. Зарим биоцид үйлчилгээт ургамлын хандалсан уусмал дахь биоцид бодисыг илрүүлэн тодотгох явцад бид туйлт алкалоид, *Chelidonium majus* L. хандалсан уусмалд рутин байгааг олж тогтоов.

НОМ ЗОХИОЛ

Егоров Н.С. Практикум по микробиологии. М.: изд-во МГУ, С.40-56

Лигая У. Монгол орны эмийн ургамалыг Өрнө Дорны анагаах ухаанд хэрэглэхүй. УБ, 2005. 26-р тал

Морыгалов П.А. Подбор ингредиентов композиционных препаратов для антибактериальной отделки льносодержащих материалов. //Текстильная промышленность, М.: 2004, С. 5-10

Методика проведения тонкослойной хроматографии. М.: изд-во МГУ, 80 с.

SUMMARY

BIOCIDE ACRION OF SOME PLANT EXTRACTS

S.Delgermaa¹, S.Tserendulam²

¹Food ingeneering and biotechnology school, MUST

²Production technology and design school, MUST

Key words: bacteria, fungi, culture, biocide's component

Now different ways of protection by one of them are applied to protection of textile and carpet materials against biodestruction under action of various species of microorganisms is the application at dyeing of filament of extracts of plants having biocide action.

The purpose of research - study biocide action of extracts of plants and revealing of chemical substances contained in them.

As objects of research we have chosen *Rheum undalatum*, *Thymus dahurica* L., *Plantago major* L., *Chelidonium majus* L., *Urtica dioica* L., which grows everywhere in territory of our country.

Plants contain various chemical connections, main of which are alkaloids and flavonoids. Alkaloid is contain basically in ground parts of plants and are phenolic compounds.

A plants which selected for research are extracted very good in spirit and water. The contents of dry substances in 60 % of spirit solution of these plants are 18-18.2 %. At addition of these solutions on nutritious environment for cultivation of microorganisms of most optimum volume is considered 1 ml of an extract. the growth of microorganisms decreases almost in 5-8 times at this volume. This volume is pernicious for *E.coli*. At study of chemical structure of the given plants, we fractionated the given extracts in the various organic solvents and spent thin layer chromatography. Thus in an extract *Chelidonium majus* L. is found out polar alkaloid. For revealing flavonoid we spent comparison of results TLC with results liquid chromatography. We are established, that in a fraction ETAC of *Rheum undalatum* and *Chelidonium majus* L. is contains flavonoid of routines.

ХҮНСНИЙ ЗАРИМ МӨӨГИЙН ҮРТ БИЕЭС ЦЭВЭР ӨСГӨВӨР ЯЛГАСАН СУДАЛГААНЫ ДҮНГЭЭС

Н.Хэрлэнчимэг¹, Э.Алтанцэцэг¹

ШУА, Ботаникийн хүрээлэн¹

Хураангуй

Agaricus bisporus (lange) Singer /Далбига мөөг/, *Lentinus edodes* /Бор мөөг/- ийн үрт биеэс цэвэр өсгөвөр ялган мах пептонг агар, хату сабуру болон төмс декстроз агарт тэжээлт орчинд өсгөвөрлөн ургуулж, мицелийг янз бүрийн субстрат /арвай буудай, улаан буудай, сүрэл ба адууны хомоолын холимог/-д нэвчин ургах идэвхийг тодорхойлж хадгалах боломжийг судлав. Судалгааны дүнгээс харахад in vitro нөхцөлд *Agaricus bisporus* (lange) Singer /далбига мөөг/-ийн үрт биеэс ялган авсан эх омог хату сабуру тэжээлт орчинд илүү тохиромжтой ургаж байсан бөгөөд *Lentinus edodes* (Berk.) Sing.- Бор мөөг /шийтаке/ мөөгийн үрт биеэс ялган авсан эх омог төмс декстрозтой агар тэжээлт орчинд илүү сайн ургадаг нь тогтоогдсон. Эх омгийг хөргөгчинд 4-5 хэмийн хүйтэнд хадгалах нь хамгийн тохиромжтой энгийн арга юм. Бидний судалгааны үр дүнд мөөг тариалах сонирхолтой аж ахуйн нэгж, хувь хүмүүсийг мөөгийн үрийн материалаар хангах боломж бүрдэх юм.

Зангилаа үг: Базидит мөөг, үрт бие, эх омог, цэвэр өсгөвөр, тэжээлт орчин, инокуляци, in vitro

Сүүлийн жилүүдэд монголчуудын хүнсний хэрэгцээний нэр төрөл олширч олон төрлийн мөөгийг хоол хүнс, эмчилгээнд хэрэглэх болжээ. Манай оронд хүнсний мөөг тарималжуулах сонирхолтой хувь хүмүүс, аж ахуйн нэгж, компаниуд олширч байгаа хэдий ч Монгол орны байгаль цаг уурын онцлогт тохирсон мөөгийн үйлдвэрлэл явуулах технологи боловсрогдоогүй, хүнсний мөөг тарималжуулах эх материал/үрийн материал/ болох мицелийн үйлдвэрлэл байхгүй учраас гадаадаас өндөр үнээр үйлдвэрлэлийн мицел худалдан авч мөөгийн үйлдвэрлэлээ явуулж байгаа нь эдийн засгийн хувьд ашиг багатай байгаа юм. Одоогоор хүнсний мөөгийн цэвэр өсгөвөр гаргах судалгааны ажил эхлэлийн шатандаа байна. Иймээс өөрийн орны байгаль цаг уурын онцлогт тохирсон хүнсний мөөг тарималжуулах технологи боловсруулах, өөрийн орондоо мөөг тарих эх омгоо үйлдвэрлэх нь нэн шаардлагатай байна.

Мөөгийг хоол хүнсэндээ өргөн хэрэглэх нь хүн амын хүнсний хэрэгцээн дэх уургийн дутагдлыг нөхөөд зогсохгүй эрүүл мэндээ хамгаалахад (хорт хавдраас урдчилан сэргийлэх, цусны даралтыг тогтворжуулах, биеийн дархлааг сайжруулах, зүрх судасны хүнд өвчний үед болон мэс заслын дараа биеийн тамир тэнхээ сайжруулах) онцгой ач холбогдолтой.

Agaricus bisporus (lange) Singer. – Хүнсний далбига мөөгийн үрт биеэс хүний бие махбодод тустай хавдрын идэвхийн эсрэг үйлчилдэг, холестерин хэмжээг бууруулдаг бодис, 87-90% -ыг ус эзлэх ба, хатаасан мөөгийн 20-25%-ийг уураг, 25-30%-ийг нүүрс ус, 2-3%-ийг өөх тос эзлэх бөгөөд түүний өөх тосны найрлаганд холестерин агуулагддаггүй. Мөн кали, фосфор, төмөр гэх мэт элементээс гадна цинк, бари, бор, магни, ванади, кобальт, молебдин, марганец, никель, кальци, кремни, кадми, рубиди, иод, зэрэг микроэлементүүдийг агуулдаг. Түүний найрлагад V_1 , V_2 , V_6 , V_{12} , D_{12} зэрэг

витамин, биотин, пантотен ба никотины хүчил илэрсэн.

Lentinus edodes (Berk.) Sing.- Бор мөөг /Шийтаке/ мөөг нь хүний биед нэн шаардлагатай амин хүчлүүд, макро, микро элементүүд, тосны хүчил, полисахаридууд, Д витамин зэргийн гол эх үүсвэр болж байдаг. Хатаасан мөөгийн полисахаридын хэмжээ нь уг мөөгийг тарималжуулсан онцлогоос хамааран 35-45% байна. Шийтаке (*Lentinus edodes*) мөөгийг мянга гаруй жилийн өмнөөс Хятадын ардын эмнэлэгт өргөн ашигладаг байсан. 1969 онд Токио хотын үндэсний судалгааны төвийн эрдэмтэд Шийтаке мөөгөөс лентинан гэдэг полисахаридыг илрүүлсэн ба 1998 онд лентинан нь перфорин гэдэг ферментийн үйл ажиллагааг идэвхжүүлдэг, мөн Т-лимфоцитын үйл ажиллагааг хүчирхэгжүүлж макрофагийг идэвхижүүлдэгийг тогтоосон байна. Лентинан полисахаридыг капсул хэлбэрээр, усан болон спиртен ханд байдлаар үйлдвэрлэн эмчилгээнд хэрэглэж байна.

1970-аад онд Японд Шийтаке мөөгийн мицелийн ханд /экстракт/ LEM (*Lentinula edodes mycelium*) гарган авах технологийг боловсруулжээ. 1980-аад онд Японы 16 эмнэлэгт В гепатит бүхий 40 өвчтөнийг клиникийн туршилтанд авч 4 сарын турш өдөр бүр LEM-ыг 6 граммаар өгөхөд бүх өвчтөнүүдийн биеийн байдал сайжирсан төдийгүй 15 төрлийн вирусыг бүрэн идэвхигүй болгож байсан байна.

Шийтаке мөөг нь дархлааны системийг сайжруулдаг, вирусын үржлийг саатуулдаг учраас дараахь өвчнүүдийн үед хэрэглэхэд тохиромжтой (элэгний өвчин; гепатит; судас хатуурах болон зүрх-судасны өвчин; эмэгтэйчүүдийн өвчнүүд сахарын өвчин; химийн эмчилгээний дараа; мэдрэлийн системийг хамгаалах гэх мэт).

Бид энэ судалгааны ажилд дараахь зорилтыг дэвшүүлсэн.

- Хүнсний мөөгийн цэвэр өсгөвөр ялган ургуулах тэжээлт орчны сонголт хийх
- Хүнс, эмийн ач холбогдолтой мөөгийн дээж материал цуглуулах, үрт биеэс цэвэр өсгөвөр ялгах
- Эх омгийг хадгалах боломжийг судлах

Судалгааны материал, аргазүй

Бид судалгаандаа дараахь 2 зүйл хүнсний мөөгийг сонгон үрт биеэс нь цэвэр өсгөвөр ялгах туршилт тавьсан.

Agaricus bisporus (Lange) Singer. – Хүнсний далбига

Малгай 5-10 см голчтой, цөөн тохиолдолд 33 см-т хүрдэг байна. Малгай эхлээд хагас дугуй хэлбэртэй байснаа дараа нь хавтгай, дэлгэгдсэн хавтгай, болох ба заримдаа төвдөө хайрстай байдаг. Малгайн махлаг эд нь цагаавтар өнгөтэй, нягт, шүүслэг. Салбан чөлөөтэй, нарийхан, шигүү, залуу мөөгийнх цайвар ягаан байснаа өнгө нь бараантаж улаан-хүрэндүү өнгөтэй болдог. Хөгшрөхөөрөө бараг хар өнгөтэй болно. Спор нь зууван дугуй хэлбэртэй, хар хүрэндүү өнгөтэй. *Agaricus bisporus* (Lange) Singer мөөг нь далбигын төрлийн бусад зүйлээс ялгарах онцлог шинж нь нэг базид дээр 2 спор боловсордог явдал юм. Бортого хэлбэрт шилбэ 3-6 х, 1-2 см хэмжээтэй, гөлгөр гадаргуутай, шилбэний дотор тал нь цул бөгөөд нягт, малгайн доод хэсэгт улаавтар өнгийн

цагирагтай (Серганина, Змитрович, 1978).

Дээж авсан байдал: 2010 оны 3 сард Меркури хүнсний захаас худалдаж авсан.

Дэлхийд хамгийн өргөн тарималжсан, тарималжуулах технологи боловсрогдсон. Манай оронд сүүлийн 5 жилд тарималжуулж байгаа, зах зээлд үнэ өндөр, Монголчуудын хүнсний хэрэглээнд зохих байраа эзэлсэн мөөг юм.

Lentinus edodes (Berk.) Sing.- /Бор мөөг-Шийтаке/

Малгай 3-7 см голчтой, гүдгэрдүү буюу хагас дугуй хэлбэртэй байснаа дараа нь хавтгайдуу болдог. Малгайн гадаргуу үсэрхэг, шаргалдуу бор өнгөтэй, Махлаг эд нь цайвар бордуу, цагаавтар өнгөтэй, нягт, шүүслэг. Салбан чөлөөтэй, нарийхан, шигүү, цайвар хүрэвтэр өнгөтэй. Спор нь зууван дугуй хэлбэртэй, өнгөгүй. Бортого хэлбэрт шилбэ 3-6 х, 1-2 см хэмжээтэй, үсэрхэг гадаргуутай, шилбэний дотор тал нь цул бөгөөд нягт.

Дээж авсан байдал: 2010 оны 3 сард Меркури хүнсний захаас худалдаж авсан. Одоогоор манай оронд тарималжуулах боломжтой гэж үзэж байна.

Тэжээлт орчныг бэлтгэх: Манай лабораторид хату-сабуру, мах пептон агар зэрэг тэжээлт орчныг Биотехнологийн лабораторийн бэлтгэсэн бэлэн орчныг авч хэрэглэж байгаа бөгөөд төмс декстрозтой агарт тэжээлт орчныг өөрсдөө бэлтгэж байна. Лабораторийн орчныг урдчилан цэвэрлэж ариутгасны дараа тэжээлт орчныг бэлтгэнэ.

а. Тэжээлт орчин найруулахад шаардлагатай урвалж: декстроз-8 г, дрожжийн экстракт-1 г, пептон-0,5 г, агар агар-10 г

б. Тэжээлт орчин найруулахад шаардлагатай багаж, шил сав бусад материал: 1000 мл ба 500 мл-ийн колбо, 100 мл-ийн стакан, соронзон хутгагч, рН метр, цахилгаан жин, юүлүүр, нэрмэл ус, плитка хуруу шил, петрийн аяга, төмс 500 грамм.

Хэмжиж /500гр/ авсан төмсийг хальсалж цэвэрлээд сайтар угаана. Дараа нь жижиглэн хэрчиж 1 литр нэрмэл усанд хагас цагийн турш буцалгана. Шүүсийг ялган авч 1000 мл-ийн колбонд марлиар шүүж хийнэ.

Бэлэн болсон төмсний шүүсэн дээрээ найруулсан уусмалаа /декстроз- 8 г, дрожжийн экстракт -1 г, пептон -0,5 г-ыг 500мл нэрсэн усанд хийж сайтар хутгана./ хийж 1000 мл хүртэл нэрмэл ус нэмнэ. Уусмалын рН –ыг үзэх ба рН нь 5,5-6,5 байвал хамгийн сүүлд нь агар агаараа нэмээд тэжээлт орчны хөөс ялгарч дуустал буцалгах ба сайтар хутгана. Учир нь агар агар нь маш наалдамтгай бодис юм. Бэлэн болсон тэжээлт орчинг (ТДА) сайтар ариутгасан хуруу шилэнд болон 0,5 мл-ээр, петрийн аяганд 1мл-ээр савлаж автоклавт 1атм даралтанд 2 цаг ариутгана. Автоклаваас гаргаж ирээд хуруу шилтэй орчноо налуу байрлалд байрлуулж 20-30 минут царцаагаад 1 хонуулсны дараа цэвэр өсгөвөр ялгаж ургуулах тэжээлт орчин бэлэн болно.

Цэвэр өсгөвөр гарган авах бэлтгэл ажил: Хуруу шилтэй болон петрийн аяга бүхий ТДА-т тэжээлт орчинд мөөгний үрт биеийн өсгөвөр хийхийн тулд дараах бэлтгэл ажлыг хийнэ. Боксын өрөөг урьдчилан цэвэрлэж бэлтгээд 20-30 минутын турш хэт ягаан туяагаар шарсан байна. Инокуляци хийх үед шаардагдах хуруу шил, петрийн аяга бүхий тэжээлт орчин, багаж хэрэгсэл зэргийг сайтар ариутгаад боксын өрөөнд оруулж тавьсан байна. Инокуляци

хийх хүн гараа маш сайн савандаж угаан, цагаан халат, малгай, бээлий, улавч зэргийг өмсөнө.

Дээд базидат мөөгийн ангилалзүйн судалгаа болон тарималжуулах технологи боловсруулах зэрэг судалгааны ажлыг гүйцэтгэхэд тэдгээр мөөгөөс цэвэр өсгөвөр ялгах аргазүй хамгийн чухал. Дээд базидат мөөгийн мицелийн цэвэр өсгөвөр гарган авах ажиллагаа нь штамм гаргах, уургийн агууламж өндөртэй юмуу биологийн идэвхит бодис ихтэй мицелийг их хэмжээгээр хурдан ургуулж, судлан тэдгээрийн онцлогийг судлах, энэ штаммыг үржүүлэхийн тулд үрт биеэс цэвэр өсгөвөр ялгадаг. Базидат мөөгийн цэвэр өсгөвөрийг: -үрт биеэс, базидиоспорыг ургуулах замаар, микориз бүрэлдүүлэгч ургамлын үндэснээс, мөөгийн амьдрах орчин болж буй /мод, хөрс, гэх мэт/ субстратаас нь ялган авна.

Эдгээрээс хамгийн их хэрэглэгддэг, үр дүнтэй арга нь үрт биеэс юмуу базидиоспороос цэвэр өсгөвөр ялгах явдал юм. Зарим тохиолдолд субстратаас нь буюу микориз үүсгэсэн үндэсний үзүүрээс цэвэр өсгөвөр ялгадаг боловч энэ нь удаан ургалттай, мөн тухайн мөөгийн мицелийг ялган салгахад хүндрэлтэй байдаг. Бид энэ удаагийн судалгаандаа дээд базидат мөөгийн үрт биеэс цэвэр өсгөвөр ялгах (Заболотный, 1982) аргазүйн дагуу хийж гүйцэтгэв.

Цэвэр өсгөвөрийг хадгалах арга: Мөөгийн үйлдвэрлэлийн лабораториуд цэвэр өсгөвөрийг байгалийн субстратад нь хадгалах аргыг түгээмэл хэрэглэдэг. байгалийн хадгалахад тохирсон арга бөгөөд спор байдлаар мөөгийн генийн сангийн цуглуулга бүрдүүлж хадгалах арга байдаг (Заболотный, 1982). Улаан буудай, арвай буудай, хөх тариа зэрэг үр тарианд мицелийг халдварлуулж хадгалахаас гадна ариутгасан хөрсөнд (өсгөвөр хийж байгаа зүйл мөөгийн ургах орчныг мэдэж байх нь чухал), халааж ариутгасан элсэнд, модны үртэс гэх мэт байгалийн субстратад ургуулж хадгална. Дээрхи аргачлалаас гадна хатаах, гүн хөлдөөх зэргээр хадгалах ба нам температурт (4-5 хэмийн хүйтэнд) хадгалж болно.

Судалгааны үр дүн

Үрт биеэс цэвэр өсгөвөр ялгах: *Agaricus bisporus* (linge) Singer болон *Lentinus edodes* (Berk.) Sing мөөгийн үрт биеэс цэвэр өсгөвөр ялгахын тулд 3 төрлийн тэжээлт орчинд ижил нөхцөлтэйгөөр туршиж үзлээ. Үүнд: 1-Хату-сабуру, 2-Төмс декстрозтой агар, 3-Мах пептонг агар.

Хүнсний мөөг үржүүлэхийн тулд мицелийн өсгөвөр хийх бол хүлэмжинд тарималжуулсан, өвчин хорлогчид нэрвэгдээгүй үрт биеийг сонгоно.

Үрт биеийг боловсруулах: Дээрх 2 зүйл мөөгийн үрт биеийг хүнсний захуудаас савласан байдлаар худалдан авсан /шинэ мөөг/ учраас үрт бие харьцангуй цэвэр байлаа. Аргазүйн дагуу үрт биед наалдсан гадны биетийн үлдэгдлээс болгоомжтой салгаж цэвэрлэн, үрт биеийг ариутгасан усаар урсгаж зайлж угаагаад эврээж хатаахын тулд фильтрийн цаасан дээр дэлгэж тавьсан.

Инокулюм хийх: /инокуляци/ Урьдчилан цэвэрлэсэн үрт биеийг хагалаад дундаас нь зүсэм “эд” –ийг хурц иртэй хутгаар авч, тэжээлийн орчинд шилжүүлэн суулгана. Цэвэр өсгөвөр ялгахын тулд үрт биеийн янз бүрийн

хэсгээс (малгай, шилбэ, малгай шилбэнд бэхлэгдсэн хэсэг, гимений давхраа гэх мэт) зүсмийг авдаг. Мөөгийн аль хэсгээс зүсэлт хийж авах нь тухайн мөөгийн бүтцийн онцлог, хэмжээнээс хамаарах ба үрт биеийн хамгийн зузаан хэсгээс зүсэлт хийх нь тохиромжтой байдаг. Ийм учраас бидний сонгосон хүнсний Далбига мөөгийн үрт бие залуу, малгай дэлгэгдээгүй буюу хаалттай элгэн тал битүү байсан учраас эдийн зүсэлтийг гимений давхраанаас авлаа. Бор мөөгийн үрт бие нас гүйцсэн мөөг байсан тул хамгийн ариун хэсэг буюу гадаад орчинтой шууд харьцдаггүй малгайн дотор талаас нь эдийн зүсэлтийг /зүсмийн хэмжээ 0,5-1,5 см/ авсан.



1-р зураг. Дээж авсан хүнсний мөөгийн үрт бие

a) *Agaricus bisporus* (linge) Singer - Хүнсний далбига мөөг /шампиньон/ мөөгийн үрт бие

b) *Lentinus edodes* (Berk.) Sing. - Бор мөөг /Шийтаке/ мөөгийн үрт бие

Үрт биеэс авсан зүсмийг хуруу шил, Петрийн аягатай тэжээлт орчинд суулгасан. Суулгац хийсэн он, сар, өдөр, омгийн нэр, дээжийн дугаар зэргийг маш гаргацтай бичиж наана. Зүсмийг байрлуулсан хуруу шилийг термостатад 25°C температурт өсгөвөрлөлөө. Үүнээс өндөр температурт (26-28°C ба түүнээс дээш) тавьбал мицелийн ургалт удааширна (Заболотный, 1982).

Үрт биеэс авсан зүсмэгээс залуу шинэ мицел урган гарч ирэх хугацаа нь мөөгийн зүйл бүрт өөр өөр байдаг. Ихэвчлэн 3-4 өдрийн дараа ургаж эхэлдэг. Мицел ургаж эхлэнгүүт үрт биеийн зүсмэгийг хатахаас хамгаалж хуруу шилний тагийг парафильмын цаасаар битүүлж наана.

Суулгац хийснээс хойш тухайн хугацаа бүрт нь ажиглалт, хэмжилтүүдийг хийж 3 давталтын дундажыг авсан.

1-р хүснэгт. Гурван төрлийн тэжээлт орчинд *Agaricus bisporus* (linge) Singer мөөгний цэвэр өсгөвөрийн ургах эрчмийг харьцуулах нь /см-ээр/

Тэжээлт орчны төрөл	<i>Agaricus bisporus</i> (linge) Singer															
	Хугацаа /хоноогоор/															
	4				8				12				16			
	1	2	3	Дун-даж	1	2	3	Дун-даж	1	2	3	Дун-даж	1	2	3	Дун-даж
Х а т у - сабуру	2.5	2.7	2.6	2	3.6	3.5	3.4	3	4	0	7	6	9.8	6	8.9	8

Т ө м с екстрозтой агар	-	-	-	-	0,3	0,2	0,1	0,2	2	1,5	1	1,5	2,5	2	1,7	2
М а х пептонг агар	-	-	-	-	0,1	1	-	0	0,2	0,1	-	0,1	2	1,5	1	1,5

2-р хүснэгт. Гурван төрлийн тэжээлт орчинд *Lentinus edodes* (Berk.) Sing. мөөгний цэвэр өсгөвөрийн ургах эрчмийг харьцуулах нь /см-ээр/

Т э ж э э л т орчны төрөл	<i>Lentinus edodes</i> (Berk.) Sing.															
	Хугацаа /хоногор/															
	4				8				12				16			
	1	2	3	Дун-даж	1	2	3	Дун-даж	1	2	3	Дун-даж	1	2	3	Дун-даж
Хату-сабуру	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Т ө м с декстрозтой агар	2,5	2	2	2,1	3,5	2,9	2,9	3,1	6	4,5	4,5	5	10,5	9,8	10	10,1
Мах пептонг агар	1,8	1,2	1	1,3	2,3	1,5	1	1,6	4	2,5	1,6	2,2	8	6,5	6	6,8



а) *Agaricus bisporus* (Lange) Singer - Хүнсний далбига мөөгийн үрт биеийн өсгөвөр



б) *Lentinus edodes* (Berk.) Sing.- Бор мөөг /шийтаке/ мөөгийн үрт биеийн өсгөвөр

Agaricus bisporus (Lange) Singer - Хүнсний далбига мөөгийн үрт биеийн өсгөвөр

б) *Lentinus edodes* (Berk.) Sing.- Бор мөөг /шийтаке/ мөөгийн үрт биеийн өсгөвөр

2-р зураг. Хүнсний мөөгүүдийн үрт биеэс өсгөвөр татсанаас хойш 15 хоногийн дараахь ургасан байдал.

Судалгааны дүнгээс харахад in vitro нөхцөлд *Agaricus bisporus* (Lange) Singer /далбига мөөг/-ийн өсгөвөр хату сабуру тэжээлт орчинд илүү тохиромжтой ургаж байсан бөгөөд *Lentinus edodes* (Berk.) Sing.- Бор мөөг /шийтаке/ мөөгийн үрт биеийн нь төмс декстрозтой агар тэжээлт орчинд илүү сайн ургадаг нь тогтоогдсон.

Ижил нөхцөлд, ижил аргазүйн дагуу үрт биеэс цэвэр өсгөвөр ялгахад *Lentinus edodes* (Berk.) Sing. мөөгийн мицелийн ургах хурд нөгөө зүйлийнхээс

5 дахин богино хугацаанд тэжээлт орчныг бүрэн бүрхэн ургаж байв.

Тус хүрээлэнгийн эд эсийн өсгөврийн лабораторид хүнсний мөөгийн үрт биеэс цэвэр өсгөвөр ялгах ажлыг зохих аргазүйн дагуу гүйцэтгэсэн. Нийт 27 ширхэг хуруу шилэнд халдварлуулснаас 12 хуруу шилтэй цэвэр өсгөвөр бохирдолгүй ургасан.

Дээрх 2 зүйл мөөгийн цэвэр өсгөврийг өсгөвөрлөн ургуулсны дараа тэдгээрийг хадгалах туршилт судалгаа хийхэд дараахь аргуудыг ашиглалаа.

1. Улаан буудай, арвай буудай зэрэг үр тарианд мицелийг халдварлуулж хадгалах

Судалгаанд хамрагдсан мөөгүүдээс гарган авсан эх омгоо 2 төрлийн үр тарианд халдварлуулсан боловч арвай буудайд огт ургаагүй, улаан буудайд халдварлуулсан мицел 3 хоногийн дараа ургаж эхлээд ургалт нь зогссон.

2. Ариутгасан хөрсөнд хадгалах янз бүрийн аргачлал байдаг. Энэ аргачлалуудаас сонгохдоо уг мөөг байгальд зэрлэгээр ямар субстрат дээр ургадгийг харгалзан үзэх хэрэгтэй. Далбига мөөг нь байгальд малын өтөг бууц ихтэй, азотлог хөрсөнд малын бэлчээр хашаа саравчны ойролцоо ургадаг, Шийтаке мөөг нь модлог ургамлын ишэн дээр ургадаг тул бид хөрсөө сонгохдоо Далбига мөөгийг адууны хомоол сүрлийн холимог хөрсөнд, Шийтаке мөөгийг дан сүрлэн хөрсөнд ургуулж хадгалахаар сонгож туршилтын ажил хийгдэж байгаа.

3. Нам температурт (4-5 хэмийн хүйтэнд) хадгалах /хөргөгчинд/ арга нь продуцент омгийн идэвхийг алдагдуулахгүйгээр үйлдвэрлэлд шилжүүлэх хүртэл 3-4 сарын турш хадгалахад хамгийн тохиромжтой бөгөөд эх омгийн ургалтын эрчмийг бууруулахгүй, гэмтээлгүй хадгалах, эдийн засгийн хувьд хэмнэлттэй хамгийн энгийн арга гэж үзэж байна. Бидний судалгаагаар гарган авсан үрт биеийн цэвэр өсгөвөрийг 2010 оны 04-р сарын 20-ны өдрөөс эхлэн хөргөгчинд хадгалан, цаашид эх мицельд өсгөвөрлөх бүрэн боломжтой нь харагдаж байна.

Дүгнэлт

1. Судалгааны дүнгээс харахад in vitro нөхцөлд *Agaricus bisporus* (Lange) Singer /далбига мөөг/-ийн үрт биеэс ялган авсан эх омог хату сабуру тэжээлт орчинд илүү тохиромжтой ургаж байсан бөгөөд *Lentinus edodes* (Berk.) Sing.- Бор мөөг /шийтаке/ мөөгийн үрт биеэс ялган авсан эх омог төмс декстрозтой агар тэжээлт орчинд илүү сайн ургадаг нь тогтоогдсон.

2. Эх омгийг хөргөгчинд 4-5 хэмийн хүйтэнд хадгалах нь хамгийн тохиромжтой энгийн арга юм.

НОМЗҮЙ

Алтанцэцэг Х. “Хясаан мөөг” тариалах боловсруулах технологи. УБ. 2004. 154 тал.
Заболотный Д.К. Методы экспериментального микологии Справочник. Киев: Наук. думка. 1985. С.448-4 61.

Teaching Material for International Training Course on Edible Mushroom Technology. Fuzhou: Fujian. China. 2005.

SUMMARY
**SOME RESULTS OF STUDYING ISOLATION A PURE
CULTURE
FROM FRUIT BODIES OF SOME EDIBLE MUSHROOM**

Kherlenchimeg.N¹, Altantsetseg.E¹
Institutue of Botany, Mongolian Academy of Sceince

Key words: Basidiomycete fungus, fruit body, mother of mycelium, pure cultures, medium, vitro inoculation.

This research work was intended to study a conservation possibility and determine the growing activity by sequences of isolating the pure culture from fruit body of *Agaricus bisporus* (lange) Singer and *Lentinus edodes*, growing it in the culture medium of Saburo and PDA, penetrating growth of mycelium in the different types of substrate (barley, wheat, mixture of straw and horse manure).

The result of this study is showing that it is more suitable to grow the mother of mycelium isolated from fruit body of *Agaricus bisporus* (lange) Singer in the hard Saburo medium and the mother of mycelium isolated from fruit body of *Lentinus edodes* (Berk) Sing is growing good in PDA potato dextrose agar medium.

The most suitable storing temperature of this mother of mycelium is 4-5 centigrade of Celsius in the refrigerator.

**ЦАЙНЫ УРГАМАЛД ЭЛЕМЕНТҮҮДИЙН АГУУЛГЫГ
ТОДОРХОЙЛСОН ҮР ДҮНГЭЭС**

Ц. Бямбасүрэн¹, Б. Хүүхэнхүү¹, Ц.Сувдаа²
¹ФТХ Атомын Спектроскопийн лаборатори
²ИХ тайга ХХК

Хураангуй

“Их тайга” ХХК-ийн цайны түүхий эд болгон авсан Хөвсгөлийн уулсаар ургадаг 17 зүйлийн цайны зэрлэг ургамалд Mn, Cu, Zn зэрэг биофиль-бичил элементүүд, Pb, Cd, Cr, Ni, Co зэрэг хүнд элементүүдийн агуулгыг тодорхойллоо. Судалгааны дүнгээс харахад хар тугалга, кадми зэрэг хортой хүнд элементүүдын агууламж мөн амьтан, ургамалд зайлшгүй шаардалагатай биологийн идэвхт микроэлементүүдийн агуулга судлагдсан бүх дээжүүдэд хэвийн хэмжээнд агуулагдаж байна.

Зангилаа үг: биофиль бичил элементүүд, хүнд металл, ургамалд агуулагдах хэлбэржилт, дундаж агууламж

Оршил

Техник технологийн үсрэнгүй хөгжил, байгалийн баялгийн хомсдол, хүрээлэн буй орчны бохирдол зэрэг олон асуудлууд хүн төрөлхтний өмнө тулгараад байгаа энэ цаг үед хүнсний бүтээгдэхүүний экологийн цэвэр байдалд ихээр анхаарал хандуулах болсон.

Ургамалд агуулагдах химийн элементүүдийн хэлбэржилтэд, уг ургамлын ургаж буй хөрс, байгаль цаг уурын нөхцөл, тэдгээрийн орчин зэрэг нь ихээхэн нөлөөлдөг бөгөөд ургамал дахь химийн элементүүд “хөрс-ургамал-амьтан-хүн”, “хөрс-ургамал-хүн” гэсэн тогтолцоогоор амьтны болоод ургамлын гаралтай хоол хүнсээр дамжин хүнд хүрдэг (Рождественская и др. 2008; Ельчанинова, 2008) байна. Иймд цайны үндсэн түүхий эд болгон хэрэглэдэг зарим эмийн бүтээгдэхүүнд ордог зэрлэг ургамалд агуулагдах хүнд элементүүд-(Pb, Cd, Cr, Ni, Co) –ийн агууламжид үнэлэмж өгөх, ургамал амьтны биед чухал ач холбогдол бүхий бичил элементүүд- (Mn, Cu, Zn)-ийн агуулга хэвийн хэмжээнд байгаа эсэхэд үнэлэлт өгөх зорилготой хийгдсэн судалгааны ажил болно.

Судалгааны материал, аргазүй

“Их тайга” ХХК-ийн цайны түүхий эд болгон авсан Хөвсгөлийн уулсаар ургадаг 17 зүйлийн цайны зэрлэг ургамалд Mn, Cu, Zn зэрэг биофиль-бичил элементүүд, Pb, Cd, Cr, Ni, Co зэрэг хүнд элементүүдийн агуулгыг атомын шингээлтийн спектрийн дөлөн атомчлалын аргаар “PERKIN-ELMER 5000” багажаар тодорхойлов. Ургамлын дээжийг хуурай үнсжүүлэлтийн аргаар 475-500 °C-т үнсжүүлж, үнсийг давсны хүчилд уусгаж дээжийг шинжилгээнд бэлдэв.

Судалганы үр дүн

Элементүүдийг ургамалд агуулагдах хэмжээгээр нь макро, микро, ультрамикроэлементүүд гэж ангилдаг (Кабата-Пендиас, 1989; Ильин, 1991). Ургамалд агуулагдаж буй мангани (Mn), цайр (Zn), зэс (Cu) зэрэг

микроэлементүүд амьд организмын физиологийн процесст тодорхой чухал үүрэг гүйцэтгэж байдаг учир зохих хэмжээгээр зайлшгүй шаардлагагайг тооцогддог.

Цайны ургамал дахь биологийн идэвхт элементүүд

Мангани (Mn) амьд организмд зайлшгүй шаардлагатай микроэлементүүдийн нэг. Тэрээр амьд организмын доторх металл агуулсан ферментүүдийн бүрэлдэхүүнд ордог. Ургамлын ургаж буй байгаль цаг уурын нөхцөл байдал болоод тухайн ургамлын төрөл зүйлээс хамааран мангани (Mn)-ийн ургамалд агуулагдах хэмжээ харилцан адилгүй дунджаар 20-70мг/кг агууламжтай байдаг (Ильин, 1991).

“Их тайга” ХХК-ийн бэлтгэн нийлүүлдэг цайны түүхий эд болох зарим ургамлуудад 4.39-49.59 мг/кг, дунджаар 23.49 мг/кг агуулгатай байна. Жишээ нь Шар мод, Ягаан цээнэ, Дэгдэнд 4-8 мг/кг, Бадаана, Нарийн навчит хөвөн оройтод 40 гаруй мг/кг агуулгатай байна (1-р Тахирмаг).



01-р Тахирмаг. Ургамал дахь Cu, Zn, Mn -ийн агуулга

Үүнд: 1-Хусны навч, 2- Бадаана, 3-Үхэр дэгд, 4-Халгай, 5- Боролзгоно, 6- Цэнхэр дэгд, 7- Игүүшин, 8- Тэхийн шээг, 9-Газрын хаг, 10- Тайжийн жинс толгой, 11- Тайжийн жинс үндэс, 12- Ягаан цээнэ, 13- Нарийн навчит хөвөн оройт хүрэн, 14- Нарийн навчит хөвөн оройт ногоон, 15- Нохойн хошуу, 16-Тэрэлж, 17-Шар мод

Ургамал дахь Цайр (Zn)-ийн үндсэн функц нь нүүрс ус, протейн, фосфатуудын метаболизмтой холбоотой. Мөн ургамалд ДНК, рибосом, ауксин үүсэхэд оролцдог. Ердийн нөхцөлд цайр (Zn) ургамалд 15-150 мг/кг агуулгатай байдаг тул ургамал дахь цайрын хоруут чанар тухайн ургамлын ургаж буй хөрсний цайрын агууламжаас ихээхэн хамаардаг. Зарим нэг тохиолдолд, цайрын хүдрийн үйлдвэрийн бүс нутагт хөрсөн дэх цайрын агууламжаас хамааран 300 мг/кг хүртэл агуулгатай тохиолддог. Ургамал дахь цайрын хортой агууламж түүний ургамалд 300-500мг/кг агуулгатай үед илэрдэг (Кабата-Пендиас, 1989; Ильин, 1991) онцлогтой ажээ.

Судалгаанд хамрагдсан цайны ургамлуудад цайрын агууламж 8.64-44.52 мг/кг, дунджаар 23.55 мг/кг агуулгатай байгаа нь (1-р Тахирмаг) ерийн нөхцөлд ургамалд агуулагдах хэмжээ (Ильин, 1991) -нээс 3.5 дахин бага агуулгатай байна. Энэ нь тухайн бүс нутгийн хөрс цайрын агуулгаар дутмаг шинжтэй холбоотой байж болох юм.

Зэс (Cu)-Зэсийн биохимийн функц маш олон янз. Гэхдээ ургамалд

зэсийн агуулга өндөр байх үед хорт үйлчлэл үзүүлэх нь их байдаг. Зэсийн ургамалд агуулагдах хэмжээ ургамалд өөрт нь төдийгүй амьтан болоод хүний хүнсний эрүүл ахуйн хувьд чухал үзүүлэлт болдог. Эх сурвалж (Кабата-Пендиас, 1989)-д ургамал дахь зэсийн хэвийн хэмжээг 3-40мг/кг, сөрөг нөлөө үзүүлэхүйц агуулгыг 150мг/кг гэсэн байна.

“Их тайга” ХХК-ийн ургамлын дээжүүд дэхи зэс 2.99-14.94 мг/кг, дунджаар 7.31мг/кг агуулгатай байна (1-р Тахирмаг). Хамгийн их агуулгатай дээж нь Тайжийн жинсийн үндэс (14.94ppm), харин Цээнэ зэсийг хамгийн багаар (2.99ppm) агуулж байна гэсэн үзүүлэлт гарлаа.

Цайны ургамал дахь хүнд элементүүдийн агуулга,ppm

Pb-хар тугалга бүх төрлийн ургамалд агуулагддаг боловч түүний ургамлын физиологийн процесс, метаболизмд гүйцэтгэх үүрэг төдийлөн их биш юм. Хар тугалга хамгийн хортой бохирдуулагч химийн элементүүдийн нэгт тооцогддог. Ургамал хар тугалгыг үндсээрээ болон навчаараа хөрс ба гадаад орчноосоо хуримтлуулж авдаг онцлогтой. Хар тугалганы ургамалд агуулагдах хэвийн хэмжээг 0.1-5ppm, дунджаар 4.1ppm (Ильин, 1991) эсвэл 0.1-10ppm, дунджаар 2 ppm (Кабата-Пендиас, 1989) гэж үзсэн байна.

Судалгаанд хамрагдсан цайны ургамлын дээжүүдэд 0.5-4.8ppm агуулгатай, ургамалд агуулагдах хэвийн хэмжээнд (Рождественская, 2008) харин газрын хаганд 9.09 ppm-ийн агуулгатай байгаа нь газрын хагийн элементүүдийн хэлбэржилтэд хүрээлэн буй орчны нөлөө давамгайлж байгааг харуулж байна (2-р Тахирмаг)



2-р Тахирмаг. Ургамал дахь Pb -ийн агуулга

1-Хусны навч, 2-Бадаана, 3-Үхэр дэгд, 4-Халгай, 5- Боролзгоно, 6- Цэнхэр дэгд,7- Игүүшин, 8- Тэхийн шээг, 9-Газрын хаг, 10- Тайжийн жинс толгой, 11- Тайжийн жинс үндэс, 12- Ягаан цээнэ, 13- Нарийн навчит хөвөн оройт хүрэн, 14- Нарийн навчит хөвөн оройт ногоон, 15- Нохойн хошуу, 16-Тэрэлж, 17-Шар мод

Cd-кадми нь маш хортой элемент. Ургамал дахь кадмийн хэмжээ газрын хөрсөн дэх кадмийн агуулгаас шууд хамааралтай. Хөрсөнд кадми гол төлөв хөдөлгөөнт хэлбэрт орших ба хөрснөөс ургамалд маш хялбар шингээгддэг. Ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүнээр хүнд дамжих нь

их байдаг (Кабата-Пендиас, 1989). Гэхдээ ургамлын хувьд физиологийн чухал элемент биш.

Ургамалд агуулагдах кадмийн хэвийн хэмжээг В.Б. Ильин; Л.А. Юданова нар (Ильин, 1991) 0.05-0.2 ppm гэж тогтоосон бол Кабата-Пендиас (Кабата-Пендиас, 1989) 0.007-0.27 ppm гэж үзжээ.


Судалгаанд хамрагдсан цайны ургамлын бүх дээжүүдэд кадмийн агуулга 0.05-0.16 ppm байна. Агуулгыг 3-р Тахирмагт үзүүлэв.



3-р Тахирмаг. Ургамал дахь Cd-ийн агуулга

1- Хусны навч, 2- Бадаана, 3-Үхэр дэгд, 4-Халгай, 5- Боролзгоно, 6- Цэнхэр дэгд, 7- Игүүшин, 8- Тэхийн шээг, 9-Газрын хаг, 10- Тайжийн жинс толгой, 11- Тайжийн жинс үндэс, 12- Ягаан цээнэ, 13- Нарийн навчит хөвөн оройт хүрэн, 14- Нарийн навчит хөвөн оройт ногоон, 15- Нохойн хошуу, 16-Тэрэлж, 17-Шар мод

Цайны ургамлын дээжүүдэд бусад хүнд элементүүд (Ni, Co, Cr)-ийн агуулгыг тодорхойлж үзүүлэлтүүдийг 4-р тахирмагт үзүүлэв. Уг үзүүлэлтээс харахад судалгаанд хамрагдсан дээжүүдэд Ni-ийн агуулга 2.36-14.13 ppm, дунжаар 7.937.93 ppm, Co-ийн агуулга 0.4-2.01 ppm дунжаар 0.79 ppm, Cr-ийн агуулга 1.75-28.12 ppm дунджаар 8.08 ppm байна.



4-р Тахирмаг. Ургамал дахь Co, Ni, Cr-ийн агуулга

1- Хусны навч, 2- Бадаана, 3-Үхэр дэгд, 4-Халгай, 5- Боролзгоно, 6- Цэнхэр дэгд, 7- Игүүшин, 8- Тэхийн шээг, 9-Газрын хаг, 10- Тайжийн жинс толгой, 11- Тайжийн жинс үндэс, 12- Ягаан цээнэ, 13- Нарийн навчит хөвөн оройт хүрэн, 14- Нарийн навчит хөвөн оройт ногоон, 15- Нохойн хошуу, 16-Тэрэлж, 17-Шар мод

Цайны ургамал дахь макроэлементүүдийн агуулга

Мөн цайны ургамлын дээжүүдэд “үнслэг” ба зарим нэг макроэлементүүдийн агуулгыг тодорхойлж үр дүнг 1-р хүснэгтэд үзүүлэв.

1-р Хүснэгт. Цайны ургамал дахь макроэлементүүдийн агуулга, %

үнслэг	Na	K	Ca	Mg	Fe
n=17					
1.8 – 8.9	0.018 – 0.8	0.9 – 1.8	0.9 – 0.9	0.9 – 1.8	8.3 – 1028
8.9 ± 0.3	0.0 ± 0.0	0.7 ± 0.0	0.3 ± 0.015	0.9 ± 0.019	354.5 ± 8.8

уСудалгааны дүнгээс харахад цайны ургамлуудад үнслэгийн хэмжээ 1.81-18.94%, Na –ийн агуулга 0.02-0.8%, K-ийн агуулга 0.09-1.18%, Ca-ийн агуулга 0.03-0.92%, Mg-ийн агуулга 0.08-1.18%, Fe-ийн агуулга дунджаар 354.75 ppm байна.

Дүгнэлт

Судалгааны үр дүнд статистик боловсруулалт хийж, цайны ургамал дахь хүнд элементүүдийн агууламжид үнэлгээ өгөхийн тулд дотоодын хүнсний болоод, эмийн ургамлын хүнд элементүүдийн стандарт хараахан батлагдаагүй учир гадны орны судлаачдын бүтээлийг харьцуулах материал болгон авсан.

Судалгааны дүнгээс харахад хар тугалга, кадми зэрэг хортой хүнд элементүүдын агууламж мөн амьтан, ургамалд зайлшгүй шаардалагатай биологийн идэвхт микроэлементүүдийн агуулга судлагдсан бүх дээжүүдэд хэвийн хэмжээнд агуулагдаж байна.

Цайны ургамлын дээжүүдэд ургамлын микроэлементүүдийг шингээх эрэмбийг буурах дарааллаар авч үзэхэд харилцан адилгүй байна. Жишээ нь: Халгай, Хусны навч, Бадаана, Игүүшин, Тэхийн шээг, Тайжийн жинсийн үндэс, Нарийн навчит хөвөн оройт зэрэг ургамлуудад Mn>Zn> Cu> Ni > Co >Cr >Pb >Cd, харин Ягаан цээнэ, Үхэр дэгд, Нохойн хошуу, Тэрэлж, Шар мод, Тайжийн жинсийн толгой зэрэгт Zn> Mn> Cu> Ni >Co> Cr> Pb >Cd дараалалтай байна

НОМ ЗОХИОЛ

Рождественская Т.А., Ельчинонова О.А., Пузанов А.В. “Элементный химический состав растений Горного Алтая и факторы, его определяющие” /Мат. междунар. конф.: Биоразнообразии, проблемы экологии Горного Алтая и сопредельных территорий: настоящее, прошлое и будущее. – Горно-Алтайск, 2008. – С. 110-114.

О.А. Ельчинонова, Т.А. Рождественская, Е.Ю. Черных “Микроэлементы-биофилы и тяжелые металлы в лекарственных растениях Северного Алтая” Мат. междунар. конф.:

Биоразнообразие, проблемы экологии Горного Алтая и сопредельных территорий: настоящее, прошлое и будущее. – Горно-Алтайск, 2008. – С.51-56.

Analytical Methods for Atomic Adsorption Spectrophotometry, 1982

Ильин В.Б. “Тяжелые металлы в системе почва – растение”. Новосибирск: Наука, 1991. 151 с

Кабата-Пендиас А., Пендиас Х. “Микроэлементы в почвах и растениях”. М.: Мир, 1989. 439 с.

SUMMARY

THE CONTENT OF BIOPHIL MICROELEMENTS AND SOME HEAVY METALS IN SOME WILD TEA PLANTS

Ts.Byambasuren¹, B.Khuukhenkhuu¹, Ts.Suvdaa²

Keywords: biophil microelement, heavy metal, plant, background value, allowable level, natural, biochemical cycle, reflection, ecologically

Abstract

The content of biophil microelements (Mn, Zn, Cu) and some heavy metals (Pb, Cd, Cr, Ni, Co) in 17 wild tea plants of Khubsugul mountains of Ikh Taiga LLT was studied. It was found that the concentration was within the limits of background values and did not exceed the allowable level. The elemental chemical composition of plants on the area under investigation can be considered as the reflection of biochemical situation in the ecologically clean region the undisturbed natural biochemical cycles of elements

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ ОРОСЫН ХАМТАРСАН БИОЛОГИЙН ИЖ БҮРЭН ЭКСПЕДИЦИ (МОХБИБЭ) -ИЙН 40 ЖИЛИЙН ОЙД

Монгол Оросын хамтарсан биологийн иж бүрэн экспедици (МОХБИБЭ) -ийн 40 жилийн ойд зориулсан “Төв Ази, Өмнөд Сибирийн шилжилтийн бүс дэх шим мандалын экологийн үр дагавар” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал Улаанбаатар хотноо 9-р сарын 6-наас 8-ны өдрүүдэд болж өнгөрсөн бөгөөд Монгол, ОХУ, Израиль, Япон, Герман, Итали, АНУ, Узбекистан, Казахстан зэрэг 8 орны 220 гаруй эрдэмтэн судлаачид оролцсноос гадаадын 130 гаруй судлаачид хүрэлцэн ирэв.

Энэхүү олон улсын хурлыг Монголын Шинжлэх ухаан Академийн ерөнхийлөгч академич Б.Энхтүвшин нээсэн бөгөөд тус хуралд ОХУ-ын ШУА-ийн тэргүүлэгчдийн газрын гишүүн, Н.С.Северцовын нэрэмжит Экологи ба түүхэн хөгжлийн хүрээлэнгийн захирал академич Д.С.Павлов, ОХУ-ын ШУА-ийн Гадаад хэлтэсийн газрын дарга С.С.Маркианов болон Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүн Х.Наранхүү, Г.Баярсайхан, БОАЖЯ-ны дэд сайд Ч.Жаргалсайхан, БСШУЯ-ны шинжлэх ухаан технологийн газрын дарга Ө.Сүхбаатар, ШУА-ийн дэд ерөнхийлөгч Д.Рэгдэл нар баяр хүргэж тус экспедицийн судалгааны үр дүнг өндрөөр үнэлэхийн зэрэгцээ хурлын үйл ажиллагаанд амжилт хүслээ.

Уг олон улсын бага хуралд дэлхий Биологийн Шинжлэх Ухааны Олон Улсын Холбооны (IUBS) ерөнхийлөгч Джон Бернарди, ЮНЕСКО-гийн Зүүн Азийн Биосферийн нөөцийн сүлжээний (Eastern-Asian Network of Biosphere Reserves) суурин төлөөлөгч Р. Якумар нарын хүндэт зочид оролцож МОХБИБЭ-ийн түүхэн үйл ажиллагааг дүгнэхдээ Төв Азид тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж буй хуурай газрын хамгийн том ганц экспедици мөн гэж онцлон тэмдэглэсэн болно.

Экспедицийн судалгааны дүнд манай орны ургамал ба амьтны зүйлийн бүрэлдэхүүн тоо толгой, бүртгэлийн ажил үндсэндээ дуусав. Одоо тус оронд 3000 орчим зүйл дээд ургамал, 1000 гаруй зүйл хаг, 461 зүйл хөвд, 1574 зүйл замаг бүртгэгдэсний дотор ургамлын хэд хэдэн зүйл, төрөл дэлхийд ба монгол оронд шинээр бүртгэгдэв.

Тус экспедици өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн дээрх он жилүүдэд олон түмний оюуны мэлмийг нээсэн шинжлэх ухааны 4.5 мянга гаруй суурь бүтээлүүд нийтлэгдсэнээс 55 цуврал бүтээл, 30 гаруй шинжлэх ухааны нэгэн сэдэвт бүтээл, амьтны янз бүрийн ангилалзүйн бүлгийн газарзүйн тархац, экологи, биологи, ангилалын талаарх мэдээг нэгтгэсэн 5 боть номыг “Монгол орны сээр нуруутан амьтад” цувралаар гаргав. Манай орны амьтан, ургамал, хөрс, газарзүй зэрэг шинжлэх ухааны салбаруудаар тус экспедицийн оролцогч нараас Оросын талаас 20 дэд доктор, 25 шинжлэх ухааны доктор Монголын талаас 55 дэд доктор, 20 шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалжээ.

Олон жилийн нөр их хүч, хөдөлмөрийн үр дүнд бий болсон оюуны

бүтээлүүд нь Монгол орны байгалийн баялаг, түүний бүтэц, бүрэлдэхүүний олон янз байдал, үйл ажиллагааны өвөрмөц онцлог, үүргийн онцлогийг илрүүлэн тусгаснаараа түүхэн ач холбогдолтой билээ. Байгалийн экосистем, түүний экологийн нөхцлийг судласан ажлын үр дүн болон Монгол орон бүс нутгийн загвар улс болохынхоо хувьд Өмнөд Сибирь ба Төв Азийн завсрын бүсийн шим мандлын экологийн тэнцвэртэй байдлыг хангах, шувуу судлаачдын нүүдлийн шувуудыг хамгаалах талаар Засгийн газар хоорондын Конвенцид оруулсан санал, Рамсарын конвенцид заасан ус намгийн эдэлбэр газрыг хамгаалах сүлжээ байгуулах саналыг боловсруулж хэрэгжүүлэхэд МОХБИБЭ судалгаа шинжилгээгээ чиглүүлж буй нь их ач холбогдолтой.

Дэлхий нийтээрээ хүн төрөлхтөний орших эс оршиход онцгой үүрэгтэй байгалийн амьтан ургамлын олон янз байдал байнга цөөрч устаж байгаад онцгой анхаарах шаардлагыг тусгасан Гран Канарийн тунхаг бичгийн хүрээнд биологийн олон янз байдлыг хамгаалах (БОЯБХК) жилийг 2010 онд тэмдэглэн өнгөрүүлэхтэй давхцан тус конвенцид нэгдсэн манай орны хувьд ядуурлыг бууруулах, улс орны тогтвортой хөгжилд түлхэц болсон эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаагаа тасралтгүй 40 жил үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй Монгол-Оросын хамтарсан биологийн иж бүрэн экспедицийн түүхэн ой давхцан тохиож буйг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Энэхүү экспедици өөрийн судалгаа шинжилгээндээ экосистемийн өнөөгийн төлөв байдалд үнэлгээ өгч, байгаль орчныг хамгаалах аргад сүүлийн үеийн дэвшилттэй технологи нэвтрүүлэх, дэлгэрүүлэх чиглэлээр дорвитой хувь нэмрээ оруулсаар ирсэн билээ.

“Төв Ази, Өмнөд Сибирийн шилжилтийн бүс дэх шим мандлын экологийн үр дагавар” хурлын үндсэн үйл ажиллагаа нь:

1. Хүрээлэн буй орчны өөрчлөлтөнд үзүүлэх экологи-нийгмийн асуудлууд
2. Байгал нуурын ай сав дахь ус намгийн экосистемийн экологийн асуудлууд
3. Тусгай хамгаалттай газар нутгийн сүлжээний өнөөгийн төлөв, хөгжлийн чиг хандлага
4. Байгаль -нийгмийн экосистем дэх экологийн эрсдэл
5. Төв Ази болон Өмнөд Сибирийн шилжилтийн бүсийн биогеоценоз, ургамал-амьтны олон янз байдал

6.Эрин зууны уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр дагавар гэсэн нэртэй салбар хуралдаануудаар нийт 92 үндсэн илтгэл хэлэлцэгдэж, 85 ханын илтгэл тавигдаж, МОХБИБЭ-ийн түүхийг харуулсан гэрэл зургийн үзэсгэлэн болон тус экспедицийн хүрээнд явуулсан судалгааны бүтээлийн номын үзэсгэлэн нээгдсэн.

Уг хурлаас “Улаанбаатарын тунхаг бичиг” гарган хэд хэдэн томоохон асуудлын шийдэлд нэгэн зэрэг хүрсэн болно.

Тус бага хуралд оролцогчид хүрээлэн байгаа орчныг хамгаалах болон байгалийн нөөц баялагаа зөв зохистой ашиглах асуудалд хамааралтай төрийн бус байгууллагууд, шинжилгээ судалгааны төвүүд, Төв Азийн улс орнуудын төр засгийн байгууллагууд тулгамдаж буй экологийн асуудлыг зохих ёсоор

шийдэж дээр дурдсан бүх чиглэлд хамтын ажиллагаагаа бэхжүүлэхэд өөрсдийн хувь нэмрээ оруулна гэдэгт гүнээ итгэж байна.

Хурлын илтгэлүүдийн эмхтгэл хоёр ботиор хэвлэгдэв.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол, Оросын хамтарсан биологийн иж бүрэн экспедицийн 40 жилийн ойг тохиолдуулан манай орны шинжлэх ухааны биологи, ботаникийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, ОХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн, Ботаникийн хүрээлэн, МОХБИБЭ-ийн эрдэм шинжилгээний удирдагч Рудольф Владимирович Камелин, ШУА-ийн Экологи түүхэн хөгжлийн хүрээлэнгийн лабораторийн эрхлэгч, МОХБИБЭ-ийн оросын талын дарга Петр Дмитриевич Гунин, ШУА-ийн Сибирийн салбарын Ойн хүрээлэнгийн зөвлөх Евгений Николаевич Савин нарыг “Алтан гадас” одонгоор, ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Николай Николаевич Слемнев, ШУА-ийн сурвалжлагч гишүүн, Экологи ба эволюцийн хүрээлэнгийн орлогч дарга Юрий Юлианович Дгебуадзе нарыг “Найрамдал” медалиар, ШУА-ийн Сибирийн салбарын Ойн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Юрий Николаевич Краснощекков, ШУА-ийн ботаникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Тамара Ивановна Казанцева нарыг хөдөлмөрийн хүндэт медалиар тус шагнав.

ДОКТОР В. ХИЛЬБИГИЙН 75 НАСНЫ ОЙД

Профессор Ц. Жамсран¹

¹МУИС

Вернер Хильбиг 1935 оны 2-р сард Герман улсын Силезин нутаг, Горлиц хотын ойролцоо Лаубан хотод барилгачны гэр бүлд төржээ. Улмаар Мерзебургийн дунд сургууль төгсөж 1953 онд Мартин-Лютерийн нэрэмжит Халле-Виттенбергийн Их Сургуульд элсэн суралцаж 1958 онд төгссөн.

Ургамлын бүлгэмдэл судлалын мэргэжилтэй тэрээр 1958-1989 онд тус их сургуулийн Геоботаникийн хүрээлэнд ажиллаж геоботаник, ургамлын экологи, байгаль хамгааллалын судалгаа хийж 1965 онд “Тюринг мужийн хогийн ургамалжилт” сэдвээр өөрийн багш профессор Х. Меизелийн удирдлага дор байгаль шинжлэлийн докторын (Dr. rer. nat) зэрэг хамгаалсан.

1974 оны 6-р сараас эхлэн МУИС, Халле-Виттенбергийн Их Сургуулийн хамтарсан “Минж нутагшуулах” экспедицийн ургамал судлаачаар ажиллаж, 1976, 1977, 1979, 1981, 1983, 1985, 1986 онуудад Булган, Ховд гол, Хар ус нуур, Хар хираа, Их Богд уул, Хөвсгөл, Хангай, Хэнтийн нуруу, Өмнөговь, Дорнод Монголын ургамал бүлгэмдлийг судлаж өөрөө болон бусад судлаачтай хамтран олон өгүүлэл бичиж нийтлүүлсэн юм.

1987 онд “Монгол орны ургамалжилт” сэдвээр биологийн шинжлэх ухааны докторын (Sc.D) зэрэг хамгаалсан.

В. Хильбиг МУИС-ийн ургамал судлалын мэргэжилтэн багш нартай хамт Монголын уудам нутгаар аялан судалгаа хийж явахдаа геоботаникийн судалгааны аргыг чадамгай эзэмшсэн, асар их гярхай, цөхрөлтгүй ажиллаж чаддаг, нөхөрсөг, тусархуу зан чанар нь танигдаж бид түүнээс ургамал бүлгэмдлийг ялгаж таних, эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, өнгөт зургийн слайд хэрэглэн илтгэх, усны ургамал таних, ургамлын хатаадас бэлтгэх, ургамал таниж, шинжлэх ухааны нэр оноох зэрэг чухал ажилд суралцсан юм.

В. Хильбиг 1995 онд “Монгол орны ургамалжилт” /The vegetation of Mongolia/ номоо Амстердам хотод хэвлүүлснээс хойш түүний нэр судлаачдын анхаарал татаж олон улсад тарсан юм. Энэ бүтээл нь англи хэлээр ярьж, бичдэг олон оронд Монголын ургамал бүрхэвчийн тухай мэдээлэл хүргэсэн. А.А.Юнатовын дараа Монгол орны ургамалжилтыг Браун Бланкийн аргаар задлан шинжилж үзсэн шинэлэг том бүтээл юм. Энэ бүтээлдээ В. Хильбиг Монгол орны газарзүй, уур амьсгал, ургамлын бүс, бүслүүрийн тухай товч тодорхойлолт өгч шилмүүст модон ой, өргөн навчит модон ой, сөөгөн шугуй, үетэнт хээр, уулын хээр, нугын хээр, элсэрхэг хээр, заримдаг цөл, цөл, таг, цармын ургамал, ус, намгийн ургамал, нуга, бэлчээр, хагалсан газар, хаягдсан газрын ургамал бүлгэмдлийг нарийвчлан ялгаж, оролцох мод, сөөг, өвслөг ургамлыг өндөр нам, арви, бүрхэц байдлаар тодорхойлсон байдаг.

В. Хильбиг 1989, 2002, 2004-2010 онд Монгол оронд ирж судалгаагаа үргэлжлүүлсээр байгаа бөгөөд Дархан цаазат Богд хан уулын ургамалжилт зэрэг олон дорвитой бүтээл хийж, бас Монгол орны ургамлын аймагт хэд хэдэн шинэ зүйл тэмдэглэж илрүүлсэн юм.

Тэрээр 1990-1998 онд Мюнхен хот дахь Баварын хөдөө аж ахуйн байгууллагад эрдэм шинжилгээний ажилтан-ургамал судлаачаар ажиллаж

байгаад 1998 онд чөлөөнд гарсан байна.

Доктор Хильбигтээ Герман улсын болон Монголын болоод Төв Азийн ургамал судлалын ажилдаа улам их амжилт гарган, эрүүл энх, урт насалж, аз жаргалтай явахын сайн ерөөлийг дэвшүүлье

**ШУА-ИЙН БОТАНИКИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТЭРГҮҮЛЭХ АЖИЛТАН ДОКТОР
(Sc.D), ПРОФЕССОР
ЧИНБАТ ОВОГТОЙ САНЧИРЫН 70 НАСНЫ ОЙД**

Доктор (Sc.D), профессор Ч.Санчир 1940 онд төрсөн. 1949-1953 онд Чойбалсан (Дорнод) аймгийн Хэрлэнбаян (Сэргэлэн) сумын бага сургуульд, 1953-1959 онд Чойбалсан хотын төвийн 10-н жилийн дунд сургуульд, 1959-1963 онд Монгол Улсын Их сургуульд тус тус суралцаж, Ургамал судлаач-багш мэргэжлээр төгсөөд 1963 оноос ШУА-ийн Ургамал, амьтан судлалын хэлтэст дээд ургамлын ангилалзүйн мэргэжилтнээр орж өнөөг хүртэл ажиллаж буй.

Тэрбээр 1976 оноос Ургамлын ангилалзүйн сектор, лабораторын эрхлэгч, захиргааны болоод эрдмийн зөвлөлийн гишүүн, 1978 оноос эрдэм шинжилгээний ахлах, тэргүүлэх ажилтан бөгөөд 2000 оноос Монгол улсын боловсролын их сургуулийн дэд профессор, профессор болсон юм.

Ч.Санчир 1974 оноос ЗХУ (хуучнаар)-ын Ташкентийн их сургуульд Биологийн ухааны дэд эрдэмтний, 1997 онд ОХУ-ын ШУА-ийн Ботаникийн хүрээлэнд Биологийн ухааны докторын зэргийг тус тус хамгаалсан.

Доктор (Sc.D), профессор Ч.Санчир Шинжлэх ухааны салбарт 47 жил тасралтгүй ажилласан хугацаандаа, нэг сэдэвт зохиол 2-ыг туурвиж дангаараа болон бусадтай хамтран ном, товхимол, сурах бичиг, эмхтгэл, хамтын бүтээл, гарын авлага 20 гаруйг бичилцэж, эрдэм шинжилгээний өгүүлэл 90 гаруйг нийтлүүлж шинжлэх ухааны нийтлэл өгүүлэл 240-ийг нийтийн хүртээл болгожээ. Түүний зарим өгүүлэл, ном товхимол орос, латин, англи, герман, хятад, япон хэлээр хэд хэдэн оронд хэвлэгджээ.

Доктор (Sc.D) Ч.Санчир дээрх бүх ажлын явцад 20-иод зүйл (species) цэцэгт ургамлаас гадна садан (sectio), зэргэлж (series), дэд зүйл (subspecies), янз зүйл (varieties) зэрэг 120 жаг (таксон)-ийг ургамал судлалд шинээр оруулж нээгч буюу зохиогчийн эрхийг хангасан байна.

Мөн гүйцэтгэсэн ажлын чиглэлээр зураг, заавар, зөвлөмж, технологийн үндэслэл, стандарт, сургалтын материал, гарын авлага 10 гаруйг боловсруулж үйлдвэр практикт нэвтрүүлсэн юм. “Харганатай холимог тэжээл бэлтгэх арга” зөвлөмж нь 1983 онд шинэ бүтээлээр батлагдсан (гэрчилгээний дугаар 541) болно.

Доктор (Sc.D) Ч.Санчир суурь судалгааны ажлын явц, үр дүнг амьдрал хэрэглээтэй холбох талаар сүүлийн жилүүдэд нэлээд санаачлагатай ажиллаж байна. Тухайлбал зэрлэг үр амууны ургамлаар гурил хийдэг уламжлалт арга технологийг сэргээж түүхий эд бэлтгэх, хураах, хатаах, цайруулах, боловсруулах, хэрэглэх талаар гарын авлага гаргасан нь эм болоод экологийн хувьд цэвэр хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, хүн амын эрэлт хэрэгцээг хангахад бодитой нөлөө үзүүлж байгааг зориуд тэмдэглэх нь зүйтэй болов уу. Тэрбээр эл чиглэлээр ШУА-ийн “Хүнстех” корпорацийтай хамтран хүнсний нэмэгдэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөлд гүйцэтгэгчээр ажиллаж, талын Бирааг, харалдайн Хамхаг тэргүүтний байгалийн нөөц,

тархацыг судлахын зэрэгцээ ургамлын түүхий эдээр эм хийж, стандарт 2-ыг боловсруулахад оролцож, патент авсан зэргийг дурьдаж болно. Ч.Санчир гадаад, дотоодод эрдэм шинжилгээний хуралд 30 гаруй удаа илтгэл, сонсгол хэлэлцүүлсний дээр Монголын үндэсний атлас; Түүх соёлын атлас; удаа дараагийн “Улаан ном”; Самар, жимс, жимсгэнэ, хүнсний мөөгийн альбом; Монголын ашигт ургамлын атлас; Монголын хураангуй нэвтэрхий толь; Хүүхэд залуучуудын нэвтэрхий толь (1-3-р боть) тэргүүтнийг гаргахад зохиогч болоод редакторын үүрэгтэй оролцсон юм. Үүнээс гадна ном товхимол, гарын авлага, цуврал бүтээл, эмхтгэл 30 гаруйг хянан тохиолдуулжээ.

Профессор Ч.Санчир 1974 оноос УБДС (хуучнаар), МУИС, АУДС (хуучнаар), багш нарын мэргэжил дээшлүүлэх институтэд багшлах, хээрийн дадлага, курс дипломын ажил удирдах, сургалтын хөтөлбөр боловсруулах, магистр, аспирант, докторантын зэрэг хамгаалуулах, тэдний ажилд шүүмж санал бичих, онолын семинарит оролцох, тойм лекц унших зэрэг ажлыг тасралтгүй хийж ирлээ. Ялангуяа түүний бусадтай хамтран бичсэн “Улаанбаатар орчмын ургамал таних бичиг” (1972), “Определитель высших сосудистых растений Монголии” (1982), “Монгол орны хадлан бэлчээр дэх гэжээлийн ургамал таних бичиг” (1985), “Монгол орны замаг, мөөг, хаг, хөвд, үрт ургамал таних бичиг” (1985), Ерөнхий боловсролын дунд сургуулийн 6-р ангид үзэх “Ургамал зүйн үндэс” (2002) зэрэг бүтээлүүд нь одоо ч сургалтын практикт хэрэглэгдэж оюутан, багш нарт гарын авлага болсоор буй.

Тэрбээр Японы ардын эмнэлгийн нийгэмлэгийн гишүүн, Монголын байгалийн шинжлэх ухааны академийн гишүүн, Монголын ургамал судлаачдын нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүн, Монголын экологичдын нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүн, Ургамал судлалаар магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр тус тус ажиллаж байна.

Түүний хөдөлмөр зүтгэлийг үнэлж “Алтан гадас” одон, Улсын хувьсгалын 70, 80 жилийн ойн медаль, Шинжлэх ухааны тэргүүний ажилтан, Байгаль хамгаалахын тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнажээ.

Доктор (Sc.D), профессор Ч.Санчирын Шинжлэх ухааны салбарт 47 жил тасралтгүй идэвхи зүтгэлтэй ажиллахдаа, нэг сэдэвт зохиол 2-ыг туурвиж дангаараа болон бусадтай хамтран ном, товхимол, сурах бичиг, эмхтгэл, хамтын бүтээл, гарын авлага 20 гаруйг бичилцэж, эрдэм шинжилгээний өгүүлэл 90 гаруйг нийтлүүлж шинжлэх ухааны нийтлэл өгүүлэл 240-ийг нийтийн хүртээл болгожээ. Дээрх бүх ажлын явцад 20-иод зүйл (species) цэцэгт ургамлаас гадна садан (sectio), зэргэлж (series), дэд зүйл (subspecies), янз зүйл (varieties) зэрэг 120 жаг (таксон)-ийг ургамал судлалд шинээр оруулж нээгч буюу зохиогчийн эрхийг хангасан гавьяатай эрдэмтэн, багш.

Доктор (Sc.D), профессор Ч.Санчирын 70 насных нь ойг тохиолдуулан ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн эрдмийн хамт олон Танд баяр хүргэж, урт насалж улам ихийг туурвин бүтээхийн өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье

БОТАНИКИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН НӨХЦӨЛД ЦЭЦЭРЛЭГИЙН САРНАЙН “Knock Out” СОРТЫГ НУТАГШУУЛЖ БУЙ ДҮНГЭЭС

Э.Ариунбаяр

ШУА, Ботаникийн хүрээлэн

Хураангуй

2009 оноос Ботаникийн цэцэрлэгийн нөхцөлд нутагшуулж буй Цэцэрлэгийн сарнайн “Knock Out” сортын анхдагч таримлын биологийн онцлог, хөгжлийн хэмийн зүй тогтлыг судалсан судалгааны явц, модожсон болон ногоон мөчрөөр үржүүлсэн судалгааны дүнгээс энэхүү өгүүлэлд оруулав.

Зангилаа үг: Ногоон мөчир, модлог мөчрөөр үржүүлэх.

Оршил

Ботаникийн цэцэрлэгийн нөхцөлд сарнайн төрлийн ургамлыг тарималжуулах, нутагшуулах судалгааны ажлыг 1976 оноос эхэлсэн /2,3 ба 4/ бөгөөд одоогоор тус цэцэрлэгийн цуглуулгын талбайд интродуцент болсон нутгийн 5 зүйл, гадаадын 9 зүйлийн сарнайгаас гадна шинээр судлагдаж буй 8 зүйлийн сарнай ургаж байна.

Судалгааны материал

Ботаникийн цэцэрлэгийн нөхцөлд тарималжуулж нутагшуулж буй Сарнайн төрлийн ургамлын цуглуулгыг баяжуулах зорилгоор 2009 оны хавар ОХУ-ын Эрхүү хотоос тарих материал цуглуулсаны нэг нь цэцэрлэгийн сарнайн “Knock Out” сорт юм. Энэхүү сортын сарнайн бут нь 90-100 см өндөр, титмийн өргөн нь 150 см-т хүрч ургадаг чимэглэлийн гоёмсог сөөг. Иш мөчир нь улаавтар хүрэн өнгөтэй, шигүү өргөстэй. Анхилуун сайхан үнэрт, улаан өнгийн цэцэгтэй. Цэцгийн голч нь 7-8 см. Энэ сортын цэцэг нь зуны туршид тасралтгүй үргэлжлэн цэцэглэдэг. Хуурайшилт, хүйтэн болон өвчин хортонд тэсвэртэй.

Судалгааны аргазүй

Ботаникийн цэцэрлэгт ургамал тарималжуулж, нутагшуулах ерөнхий аргазүй (Эрдэнэжав, 1986) Чимэглэлийн сөөг ургамлын интродукцийн аргазүйг (Цэрэннадмид, 2000) баримтлан судалгааг явууллаа.

Судалгааны үр дүн

2009 оны хавар ОХУ-ын Эрхүү хотоос Цэцэрлэгийн сарнайн “Knock Out” сортын 25 см өндөртэй, хоёр салаа иштэй тарьцыг авчирч хүлэмжинд тарихад үндэсний хүзүүнээс сэргэн ургаж 6-р сарын эхнээс 8-р сарын сүүлч хүртэл цувран цэцэглэсэн. Намар мөчир салаа ихтэй дунджаар 120-150 см өндөртэй ургамлыг ил талбайд шилжүүлж, шороогоор хучиж өвөлжүүлсэн.

Ногоон мөчрөөр үржүүлсэн судалгааны дүнгээс Тус сарнайгаас 2009 оны 7-р сарын эхээр 3-4 нахиатай ногоон мөчир бэлтгэн, доод талын

зүсэлтийг нахианаас доогуур 5 мм-т ташуу, дээд талын зүсэлтийг нахианаас дээш 3 мм дээгүүр тэгшлэн, 5-7 см урттай 20 ширхэг тайрдас бэлтгэж, өсөлт идэвхижүүлэгч гетероауксины 0,002% -ийн уусмалд 16 цаг ёзоор хэсгийг нь дүрсэн. Тарихын өмнө цэвэр усаар сайтар зайлж урьдчилан бэлтгэсэн хөрсөнд мөчрийг эгнээ хооронд 5 см, ургамал хооронд 5 см зайтайгаар 3 см гүнд суулган, орчны хөрсийг сайтар нягтруулсаны дараа усалгаа хийсэн. Усалгааг бороожуулагчаар өдөрт 4-6 удаа усалж тогтмол чийгтэй байлгасан. Ногоон мөчрөөр сарнайг үржүүлж, тасралтгүй үргэлжлэн дэлгэрэх цэцэгсийг баглааны зориулалтаар ашиглах боломжтой.

Модлог мөчрөөр үржүүлэхдээ 2009 оны намар хучиж өвөлжүүлсэн эх



1-р зураг. Хүлэмжинд тарихын өмнө 2-р зураг. Тарьсаны дараах байдал ургамлаас 2010 оны 4-р сарын сүүлчээр хучилтыг авч ил гарган, 4-6 нахиатай, 10-15 см урт тайрдсыг үзүүр талын нахиан дээгүүр тэгш, доод талын огтлолыг нахианы доогуур ташуу хийж бэлтгэн, суулгахын өмнө гетероауксины 0,002% -ийн уусмалд 14 цаг дүрсэн. Ийнхүү бэлтгэсэн тайрдсаа тусгайлан бэлтгэсэн хөрсөнд нэг нахиаг нь ил үлдээж, мөр хооронд 15 см, ургамал хооронд 20 см зайтай суулган хөрсөөр сайтар чигжсэн. Суулгасны дараа усалж тогтмол чийгтэй байлгахад 5-р сарын дундаас цувран цэцэглэж эхэлсэн. Намар 3-6 салаа мөчиртэй, 90-120 см өндөртэй, 95%-ийн амьдралттай ургалаа.

Хучиж өвөлжүүлсэн суулгацыг 2010 оны 5-р сарын эхээр гоёл чимэглэлийн сөөгийн цуглуулгын ил талбайд шилжүүлэн суулгахад 6-р сарын эхээр нахиа хөөж, 6-р сарын дундуур нахиа задарч, 7-р сарын эхээр навч нь байвал зохих хэмжээндээ хүрч, 7-р сарын дундаас 9-р сарын сүүлч хүртэл цувран цэцэглэсэн. Нэг наст найлзуурын жилийн дундаж өсөлт 12 см – т хүрч байв.



᠖-р зураг. үгүй онд цэцэглэсэн байдал	᠗-р зураг. үгүй онд ил талбайд ургаж байгаа нь
---------------------------------------	--

Судалгааны явцаас ажиглахад Цэцэрлэгийн сарнайн “Knock Out” сортыг цаашид олшруулан үржүүлж ногоон байгууламжинд ганцаар, хэсэг бүлгээр бусад ургамалтай хослуулан тарих боломжтой нь тогтоогдлоо.

Энэ сортын сарнай нь анхилуун сайхан үнэртэй учраас бундуужаад цэцэглэж эхлэх үед нь хортон шавьж цугларч цэцэглүүлэхгүй байх магадлалтай тул хортон шавьжаас хамгаалах арга хэмжээ авах нь зүйтэй.

Дүгнэлт

Цэцэрлэгийн сарнайн “Knock Out” сорт нь Улаанбаатар хотын хөрс уур амьсгалын нөхцөлд анхдагч таримлын ургалтын үе нь 6-р сарын 12-ноос 10-р сарын эх хүртэл 120 орчим хоног үргэлжилж байна.

Цэцэглэх үе нь 7-р сарын эхнээс 9-р сарын сүүлч хүртэл тасралтгүй үргэлжлэн, орчноо чимэглэх тул өрөө тасалгаа болон ногоон байгууламжинд өргөн ашиглах боломжтой.

Цэцэрлэгийн сарнайн “Knock Out” сортыг модлог болон ногоон мөчрөөр үржүүлэх боломжтойг судлан тогтоолоо.

Ном зохиол

Цэрэннадмид П. Эколого-биологическое обоснование интродукции декоративных кустарниковых растений и их использование в зеленом строительстве. Автореф. дисс. на соиск. канд. биол. наук. УБ., 1995.

28с.

Цэрэннадмид П. Чимэглэлийн сөөглөг ургамлыг тарималжуулж, нутагшуулах судалгааны арга //ШУА-

ийн мэдээ. 2000. № 1. 46-60-р тал.

Чанцалням Д. Биологические особенности некоторых полезных кустарников при интродукции.

Автореф. дисс. На. Соиск. Канд. Биол. наук. УБ., 1995. 27с.

РЕЗЮМЕ

НЕКОТОРЫЕ ИТОГИ ИНТРОДУКЦИИ РОЗА ПАРКОВАЯ “Knock Out” В УСЛОВИЯХ БОТАНИЧЕСКОГО САДА

Э.Ариунбаяр

Институт Ботаника, АНМ

В статье приводятся данные о росте и развитии сорта Роза парковая “Knock Out” к условиям Ботанического сада, использовании данных сортов для озеленения городских территорий

ШУА-ИЙН БОТАНИКИЙН ЦЭЦЭРЛЭГТ НУТАГШУУЛСАН ГАДААДЫН ЗАРИМ ЗҮЙЛИЙН УЛИАСУУДЫН АМЬДРАЛЫН ХЭЛБЭР, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

М.Мөнгөн-Онсь

ШУА, Ботаникийн хэрээлэн

Хураангуй

Эрдэмтдийн судалгаагаар дэлхийд 110 зүйлийн улиас ургадаг. Үүнээс манай оронд 6 зүйлийн улиас ургана. Улиас нь олон талын ач холбогдолтой. Ялангуяа сүүлийн жилүүдэд хот суурин тохижуулах, амралт эмнэлэг, сувилалын газрыг цэцэрлэгжүүлэхэд өргөн ашиглаж, ой багатай, ойгүй говь зарим нутагт мөн тарьж ургуулж байна. Улиас мод тэгим хүйтэн, элдэв хорт хийг тэсвэрлэх чадвар болон ямарч хөрсөнд зохилдон ургах шинжээрээ бусад модноос давуутай.

Эрдэм шинжилгээний болоод үйлдвэрлэлийн зорилгод нутгийн улиасаар зогсохгүй хилийн чандад ургадаг хэд хэдэн зүйлийн өсөлт хурдантай, гоёл чимэглэлийн ач холбогдол бүхий улиасыг нутагшуулан ургуулах нь манай өнөөгийн шаардлагаас урган гарч байна.

Зангилаа үг: Улиасны суулгац, тарьц, мөчир, тайрдас, нутагшуулалт, тарималжуулалт

Судалгааны материал

Бид дээрх асуудлын заримыг шийдвэрлэх зорилгоор 1976 оноос Амгалан дахь ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт Ташкент, Улаан-Үдээс зарим зүйлийн улиас авчирч, мөчрийн тайрдсаар ургуулах, нутагшуулах ажил хийж эхэлсэн.

Судалгааны үр дүн

Populus euroamericana У-214 – ЕВРОАМЕРИКИЙН УЛИАС энэ нь 10 насандаа 23 м өндөр 46 см диаметр бүхий бүдүүн ургадаг. Иш нь шулуун, титмийн диаметр 10 м хүрэх ба хүрэн ба хар хүрэн өнгийн ан цав гарч хагарсан холтостой. Мөчир дээрх навч нь 6 см урт, 4-4.5 см өргөн том шүдэлсэн захтай. Газрын гадаргуугаар ихээр тархсан үндэсний системтэй, мөчрийн тайрдсаар сайн үрждэг, тайрдсны амьдралт 94-99% хурдан ургадаг. Зуны халуун, агаарын хурайшилт, өвчин хорлогчдыг сайн тэсвэрлэдэг дунд зэргийн давсжсан хөрсөнд ургана. Хот сууринг цэцэрлэгжүүлэхэд хэсэг бүлгээр юмуу зурваслан тариалж болно. Ботаникийн цэцэрлэгийн нөхцөлд 3-4 салаа иш мөчир үүсгэн 4 ширхэг ЕВРОАМЕРИКИЙН УЛИАС ургаж байна.

P.serotina Hort – НАМАРСАГ УЛИАСЫГ эрлийзжүүлэх аргаар гарган авсан мод 40 м өндөр, 1 м хүртэл бүдүүрч ургах ба 10 насандаа 21.5 м өндөр, 37 см диаметр бүхий ажээ. Ишний холтос нь бор хүрэн өнгөтэй, гүнзгий ан цав гарч хагарсан байдаг. Мөчрийн навч нь 4-5 см урт, 3.5-4 см өргөн шүдэлсэн захтай, навчны бариул 2-3.5 см урт, хавтгайдуу ногоон өнгөтэй. Мөн дээрх хэлбэрээр Ботаникийн цэцэрлэгт 3 ширхэг НАМАРСАГ УЛИАС ургаж байна. Үндэсний систем нь газрын гадаргууд тэлж салаалсан, мөчрийн тайрдсаар сайн үрждэг, тайрдсны амьдралт 96-100% өвчөн хорлогчдод тэсвэртэй, дунд зэргийн давсжсан хөрсөнд маш хурдан ургадаг. Селекц эрлийзжүүлэлтийн ажилд чухал ач холбогдолтойн дээр хамгаалалтын зурваст эгнээ ба бүлгээр

тариална.

P.deltoides Marsch – ГУРВАЛЖИН НАВЧИТ УЛИАС нь хойд америкаас гаралтай, гоёл чимэглэлийн ач холбогдолтой юм. Байгаль дээр 30-50 м хүртэл өндөр, 2-2.5 м бүдүүн ургана. 10 насандаа 15.8 м өндөр, 34 см бүдүүн ургадаг. Ишний холтос нь буурал бүдэг саарал өнгөтэй, гүнзгийн ан цав гарч хагарсан, мөчир дээрх навчны урт нь 7 см, 6.8 см өргөн, гурвалжин хэлбэртэй навчтэй. Сүүлийн жилүүдэд Европод ба Дундад Азид их тариалж байна. Энэ улиас нь эхний үедээ хурдан өсдөг, мөчрийн тайрдсаар сайн үрждэг, амьдралт нь 92-99% өвчин хорлогчид, агаарын хуурайшилт зуны халууныг сайн тэсвэрлэдэг. Хот сууринг цэцэрлэгжүүлэх, хамгаалалтын зурвас байгуулахад эгнээ ба бүлгээр нь тарьдаг байна. Ботаникийн цэцэрлэгийн нөхцөлд олон ишт хэлбэрээр 5 ширхэг ГУРВАЛЖИН НАВЧИТ УЛИАС ургаж байна.

P.generosa - ҮРЖИЛТ УЛИАС 10 насандаа 15.5 м өндөр, 30.5 см бүдүүн ургана. Титэм нь бөөрөнхий хэлбэртэй, диаметр нь 8 м, ишний холтос нь нягт бор саарал өнгөтэй гүнзгий биш ан цав гарч хагарсан. Мөчрийн навчны урт 9 см, өргөн 8.5 см, бариул нь 7-8 см урт, хавтгайдуу хэлбэртэй. Үндэсний систем нь газрын гадаргууд ихээр салаалж тэлсэн. Мөчрийн тайрдсаар сайн үрждэг. Амьдралт нь 87-93%, өвчин хорлогчдод тэсвэртэй, дунд зэргийн давсархаг хөрсөнд ургана. Энэ улиас эрлийзжүүлэлт, селекцийн ажилд чухал ач холбогдолтойгоос гадна хот сууринг тохижуулахад гудамж замын дагуу зурваслан суулгахад үзэмжтэй аж.

P.candicans – ТОМ НАВЧИТ УЛИАС нь Хойд Америкаас гаралтай. Энэ нь 30 м өндөр, 60 см бүдүүн ургах ба 10 насандаа 13.7 м өндөр 20 м диаметр хүртэл бүдүүрч ургадаг. Ишний холтос нь бүдэг саарал шар өнгөтэй, ан цав гарч хагарна. Навчны урт 9 см, өргөн 7 см, навчны бариул нь 3.5 см урт хавтгайдуу хэлбэртэй. Хүчтэй хөгжсөн үндэсний системтэй мөчрийн тайрдсаар сайн үрждэг, амьдралт 92-100%, ган халуунд тэсвэртэй, дунд зэргийн давсжсан хөрсөнд ургана. Өвчин хорлогчдод амархан нэрвэгдэх талтай. Мөчрийн найлзуур нь өвөрмөц улаавтар өнгөтэй. Том навчтай тул парк цэцэрлэгт эгнээгээр ба бүлгээр таривал гоё үзэмжтэй харагдана.

P.simionii Carr – НАНГИАД УЛИАС нь ЗХУ-ын Алс Дорнод, Солонгос, Хойд Хятад, Азийн зарим нутагт мөн Дорнод Монголын нутгаар тохиолддог гэж тэмдэглэжээ. Байгаль дээр 25 м өндөр, 40 см бүдүүн ургах ба Узбекистаны Ботаникийн цэцэрлэгт 10 насандаа 11.5 м өндөр, 22 см бүдүүн ургасан улиас бий. Навч нь 8.3 см урт, өргөн нь 4.5 см, навчны бариул 3 см урт хавтгайдуу хэлбэртэй. Уг улиас өвлийн хүчтэй, өвчин хорлогчдыг сайн тэсвэрлэдэг. Үржил шимтэй хөрсөнд ургах ба мөчрийн тайрдсаар үрждэг, амьдралт 83-90%, хот сууринг цэцэрлэгжүүлэхэд чухал модны нэг юм.

1976 онд эдгээр улиасыг өвөлжүүлэхийн тулд хөрсөн дээр нь 20-25см орчим зузаан үртэс, навчаар битүү хучиж азрын дээрх иш (найлзуурыг)-ийг хөвөн материалаар жил бүр ороож өвөлжүүлэх зорилт тавьж байсан боловч манай орны хүйтэн нөхцлийг давж чадахгүй эл улиасууд мод хэлбэрээ алдаж сөөг хэлбэрт орон ургаж байсан болно. Хавар нь газрын дээрх найлзуурууд хөлдөж, үндэсний сэргэн ургах нахианаас ишний найлзуур шинээр гарч, өмнөх жилийнхээ ургасан хэмжээнд хүрэв. Ер нь эдгээр 4 зүйлийн улиас манай

орны нөхцөлд зохицон ургах боломжтой нь харагдлаа. Дээр өгүүлснээс үзэхэд манай улсын хот, суурин газрыг цэцэрлэгжүүлэх, тариалангийн хамгаалалтын зурвас байгуулахад өөрийн орны болон гадаадын улиасыг нутагшуулан ашиглах ихээхэн бололцоо байгаа нь харагдаж байна. Цаашид хот, суурин тохижуулахад ашиглахаар улиас модыг тайрдсаар ургуулах судалгааг янз бүрийн газар нутагт өргөн далайцтай явуулах шаардлагатай байна.

P.hubrida altaica – Алтайн эрлийз улиас нь 1976 онд Ботаникийн цэцэрлэгт Улаан-Үдээс нэг наст суулгацаар ирсэн улиас билээ. Нутагшуулалтын үр дүнгээр манай оронд бүрэн нутагшиж натурализаци болсон ганц зүйл юм. Ботаникийн цэцэрлэгийн нөхцөлд 21 насандаа 18 м өндөр, 50 см бүдүүрч ургаад байна. Энэ улиасны 20 ширхэг эх модноос бид туршилтын мөчрөө бэлтгэж судалгаа шинжилгээний ажлаа явуулдаг юм. Бидний 30 гаруй жилийн судалгааны үр дүнд өдгөө Ботаникийн цэцэрлэгт 0.26 га-д улиас, хусны 100 гаруй суулгацаас бүрдсэн амьд бичил цэцэрлэгийг бүрдүүлээд байна. Олон жилийн судалгааныхаа ажлын үр дүнг олны хүртээл болгох зорилгоор 2010 онд дээрх бичил цэцэрлэгийнхээ дүржүүлсэн бичлэгийг хийлгэж, видео хуурцганд буулгасан болно /хуурцгийг хавсаргав/.

Анхны тарилтаар дээрх зүйлүүд бүгд нахиалсан боловч эхний жилийн өвөлжилтөөр гол иш нь хөлдөн дараа жилээс бутлаг хэлбэртэй дахин нахиалж байв. Олон жилийн туршид дээрх үзэгдэл давтагдсаар ирсэн ба яг одоогийн байдлаар Евро-Америкийн улиас 4 ширхэг, Гурвалжин навчит улиас 6 ширхэг, Намарсаг улиас 5 ширхэг зэрэг зүйлс нь дасан зохицож олон ишт мод хэлбэрээр ургаж байсан гэж дээр өгүүлсэн.

Дүгнэлт

1976 онд Улаан-Үдэ хотоос 100 ширхэг Алтайн эрлийз улиасны нэг наст суулгацыг Мая Степанова надад илгээснээр миний эрдэм шинжилгээний ажлын үндэс объект Ботаникийн цэцэрлэгт анх тавигдах болсон түүхтэй. Тухайн жилийн тарилтаар нэг наст суулгацууд нь 60-80 см өндөртэй 100% соёлож байсан нь энэхүү зүйл нь Монголын байгаль цаг уурын нөхцөлд гахалтай дасан зохицох ирээдүйг нь харуулсан гэж бодож байна. Үүнээс хойш 33 жилийн турш уг зүйл нь Ботаникийн цэцэрлэг болон Улаанбаатар хотод амжилттай ургасаар байна. Одоогийн байдлаар Алтайн эрлийз улиас 19-21 насандаа 18 м өндөртэй, 45-50 см диаметр бүхий 20 эх мод Ботаникийн цэцэрлэгт ургасаар байна. Үүнээс гадна мөчир бэлтгэх 20 эх мод ургаж байна.

НОМ ЗОХИОЛ

Даваасүрэн Ц. Улиас түүнийг үржүүлэхүй. УБ., 1966.

Усманов А.У. Дендрология Узбекистана. Том 3. Тополь. Из-во Фа. Узб. ССР.Ташкент 1971.

SUMMARY
**CHARACTERS, LIFE FORM FOREIGN SPECIES POPLAR
 INDRADUCT IN THE BOTANICAL GARDEN, MAS**

M.Mungun-onis
 Institute of botany, MAS

Key words: poplar's plant, seedling branch clipping, indroduction planting

30 years research results of the Botanic Institute of the Academy of Science of Mongolia show that introduction of Tashkent asps in Ulaanbaatar did not succeed, as they lost its main (tree) form and grew in bushy form. But Altai asps (*Populus hybrida altaica*) have been growing successfully and naturalized.

**ШУА-ИЙН БОТАНИКИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
 ХОВОР УРГАМЛЫН ЦУГЛУУЛГА**

Н.Очгэрэл¹, Л.Энхтуяа¹
¹Ботаникийн хэрээлэн

Хураангуй

Дэлхийн ургамлын баялагийг хадгалан хамгаалах, генофондыг судлах, цуглуулах явдал өнөөгийн улс орон бүрийн анхааралд байгаа хамгийн чухал асуудлын нэг болж байна. 2004 оноос ховор, ховордсон ургамлын цуглуулгын зүйлийн бүрдлийг баяжуулах, тэдгээрээс цаашид тарималжуулах ирээдүйтэй төрөл, зүйлийг сонгон авах, тэдгээрт интродукцийн үнэлгээ өгөх, ургамлын генийн санг in situ хэлбэрээр хадгалан хамгаалахад чиглэгдсэн судалгааны явцаас өгүүлсэн болно.

Зангилаа үг: ховор, нэн ховор ургамал

Оршил

Аливаа улс орны Ботаникийн цэцэрлэг нь байгалийн зэрлэг ургамлыг тарималжуулах, гадаадын гаралтай таримал сортуудыг нутагшуулах замаар ургамлын нөмрөгийн цуглуулгын сан бүрдүүлэн, тухайн орон нутгийн зүйлийн бүрдлийг нэмэгдүүлэн олшруулах, ургамлын генийн санг in situ-ээр хадгалан хамгаалахад чиглэгдсэн байдаг.

Манай орны ургамлын аймагт (Өлзийхутаг, 1989) 149 зүйл унаган, 140 гаруй зүйл завсрын унаган, 100-гаас цөөнгүй зүйл эртний цөл, гуравдагчийн ба мөстлөгийн үеийн үлдвэр ургамал байдаг хэмээн тэмдэглэсэн.

Байгалийн ургамлын тухай Монгол улсын (1995) хуулийн хавсралтанд нэн ховор ургамал 133 зүйл, ховор ургамал 354 зүйл бүртгэгдсэн байдаг.

Байгалийн ургамлын тухай хуулинд (Байгаль орчин, аялал жуулчлалын хуулийн эмхтгэл, 2009) нэн ховор ургамалд байгалийн жамсстөрөл 50 зүйл мод, сөөг, өвслөг ургамлын цуглуулгатай болсон (1-р хүснэгт)

**1-р хүснэгт. Ботаникийн цэцэрлэгийн ховор, нэн ховор ургамлын
 зүйлийн бүрдэл**

№	Овог, зүйлийн нэр	Статус	Цуглуулсан газар	Хэн, хэдэн онд цуглуусан	
I. Alliaceae. J. Adardh.					
1	<i>Allium altaicum</i> Pall.	□	Ховор	Цуглуулгын талбай	С.Жавзан
				Баян- Өлгий аймаг, Сагсай сум	С.Лхагвасүрэн, 1996
				Улаанбаатар, Тэрэлж, Горхи	Б.Буянчимэг, 2008
				Баянхонгор аймаг, Богд сум, Их Богд уул, Битүүгийн ам	Л.Энхтуяа, 2009.07.22
				Өмнөговь аймаг, Говь Гурван сайхан, Елын ам	Л.Энхтуяа, 2009.07.19
				Өвөрхангай аймаг, Богд сум	Л.Энхтуяа, 2009.07.21
				Баянхонгор аймаг, Эрдэнэцогт сум,	Л.Энхтуяа, 2009.07.24

2	<i>A. condensatum Turcz.</i>	<input type="checkbox"/>	Ховор	Сүхбаатар аймаг, Эрдэнэцагаан сум	Г.Цэрэнбалжид, 2005
᠖	<i>A. macrostemon Bge.</i>	<input type="checkbox"/>	Нэн ховор	Дорнод аймаг, Матад сум	Г.Цэрэнбалжид, 2005
᠗	<i>A. obliquum L.</i>	<input type="checkbox"/>	Нэн ховор	Баян-Өлгий аймаг, Сагсай сум	С.Лхагвасүрэн, 1996
᠘	<i>A. victoralis L.</i>	<input type="checkbox"/>	Ховор	Сэлэнгэ, Зүүнхараа, Хонин нуга	Л.Энхтуяа, 2009
II. Crassulaceae DC.					
᠑	<i>Rhodiola rosea L.</i>	<input type="checkbox"/>	Нэн ховор	Улаанбаатар, Заан Тэрэлж Булган аймаг, Хялганат Улаанбаатар, Гацууртын эх	Л.Энхтуяа, Н.Очгэрэл, 2003.09.07 Ч.Доржсүрэн, 2009 Л.Энхтуяа, Н.Очгэрэл, 2009.06.22
III. Caryophyllaceae Juss.					
᠒	<i>Stellaria dichotoma L.</i>	<input type="checkbox"/>	Ховор	Завхан аймаг	С.Лхагвасүрэн, 1996
IV. Ranunculaceae Juss.					
᠓	<i>Adonis mongolica Simon.</i>	<input type="checkbox"/>	Нэн ховор	Налайх	С.Жавзан (цуглуулгын талбай)
V. Paeoniaceae Rudolphi					
᠔	<i>Paeonia anomala L.</i>	<input type="checkbox"/>	Ховор	Төв аймаг	С.Жавзан (цуглуулгын талбай)
				Төв аймаг, Баянчандмань	Н.Очгэрэл, 2006.09.12
				Сэлэнгэ аймаг, Сант сум Хөвсгөл аймаг, Жаргалан сум	Н.Очгэрэл, 2007.08.27 Н.Очгэрэл, 2007.08.19
᠕	<i>P. lactiflora Pall.</i>	<input type="checkbox"/>	Нэн ховор	Дорнод аймаг, Халх гол сум	С.Жавзан (цуглуулгын талбай)
				Дорнод аймаг, Халх гол сум, Хянганы тойрог	Л.Энхтуяа, 2002
				Хэнтий аймаг, Дадал сум	Н.Очгэрэл, Л.Энхтуяа, 2006.08.30
VI. Liliaceae Juss					
᠖	<i>Convallaria Keisei Miq.</i>	<input type="checkbox"/>	Нэн ховор	Сэлэнгэ аймаг, Хүдэр сум	Д.Чанцалням, 2005
᠗	<i>Hemerocallis lilioasphodelus L.</i>	<input type="checkbox"/>	Ховор	Дорнод аймаг, Халх гол сум, Хянганы тойрог	Л.Энхтуяа, 2002
᠘	<i>Lilium buschianum Lodd.</i>	<input type="checkbox"/>	Ховор	Дорнод аймаг, Халх гол сум, Хянганы тойрог	Л.Энхтуяа, 2002
᠙	<i>L. dahuricum Ker-Gawl.</i>	<input type="checkbox"/>	Нэн ховор	Дорнод аймаг, Халх гол сум, Хянганы тойрог	Л.Энхтуяа, 2002
				Дорнод аймаг, Эрэндаваа	Л.Энхтуяа, 2002
				Сэлэнгэ аймаг, Шарын гол Шарын гол, Моностойн ам Шарын гол, Моностойн ам	Г.Очирбат, 2004 С.Бямбасүрэн, Г.Цэдэндаш, 2005 Н.Очгэрэл, 2005.07.24
᠑᠐	<i>L. martagon L.</i>	<input type="checkbox"/>	Нэн ховор	Сэлэнгэ аймаг, Шарын гол Шарын гол, Моностойн ам	Г.Очирбат, 2004 Н.Очгэрэл, 2005.07.24
1᠑	<i>Tulipa uniflora (L.) Bess.</i>	<input type="checkbox"/>	Нэн ховор	Завхан аймаг, Тосон цэнгэл сум	Г.Цэрэнбалжид, 2004.09.08
VII. Iridaceae Lindl					
12	<i>Iris flavissima Pall.</i>	<input type="checkbox"/>	Ховор	Улаанбаатар, Чингэлтэй	Л.Энхтуяа
13	<i>I. potaninii Maxim.</i>	<input type="checkbox"/>	Ховор	Төв аймаг, Зоргол Хайрхан	Л.Энхтуяа

19	<i>I. halophila Pall.</i>		Ховор	Ховд аймаг, Булган сум	Л.Энхтуяа
20	<i>I. dichotoma Pall.</i>		Ховор	Дорнод аймаг, Халх гол сум, Хянганы тойрог	Л.Энхтуяа, 2002
				Сүхбаатар аймаг, Түмэнцогт Хэнтий аймаг, Дадал сум	С.Лхагвасүрэн Б.Мөнхжаргал
21	<i>I. oxepetala Bunge.</i>		Ховор	Өмнөговь аймаг, Ханбогд	С.Амгалан, 2002
22	<i>L. Bungei Maxim.</i>		Ховор	Дундговь аймаг, Адаацаг	Л.Энхтуяа, 2002
VIII. Scrophulariaceae Juss					
23	<i>Lancea tibetica Hook.f et Thoms.</i>		Нэн ховор	Архангай аймаг, Цэнхэрийн гол	Г.Цэрэнбалжид, 2004.09.08
IX. Papaveraceae Juss.					
24	<i>Chelidonium majus L.</i>		Ховор	Улаанбаатар, Гүнтийн ам	Л.Энхтуяа, 2008
X. Umbelliferae Juss.					
25	<i>Saposhnikovia divaricata (Turcz.) Schischk.</i>		Ховор	Дорнод аймаг	Ц.Батцэрэн
				Дорнод аймаг	Л.Энхтуяа, 2002
XI. Valerianaceae Batsch.					
26	<i>Valeriana officinalis L.</i>		Ховор	Улаанбаатар, Тэрэлж	Л.Энхтуяа, 2008
XII. Bignoniaceae Juss.					
27	<i>Incarvillea potaninii Batal.</i>		Нэн ховор	Өмнөговь аймаг, Хүрмэн сум	Л.Энхтуяа, 2008
XIII. Euphorbiaceae Juss					
28	<i>Euphorbia pallasii Turcz.</i>		ховор	Дорнод аймаг, Халх сум	Л.Энхтуяа, 2002
XIV. Pinaceae Lindl.					
29	<i>Abies sibirica Ledeb.</i>		Нэн ховор	Сэлэнгэ аймаг, Бугант	П.Цэрэннадмид, 1999
30	<i>Larix dahurica Turcz. ex Trautv.</i>		Ховор	Хэнтий аймаг, Баянуул сум	Д.Чанцалням, 2007
31	<i>Pinus sibirica (Rupr.) Mayr.</i>		Ховор	Улаанбаатар, Хандгайын ам	Д.Чанцалням, 2005
XV. Cupressaceae F.W.Neger.					
32	<i>Juniperus Sabina L.</i>		Нэн ховор	Казакстан улсын, Ботаник цэцэрлэг Монгол Дагуур	Барс, 1980 Д.Чанцалням, 2001
XVI. Tamaricaceae Link.					
33	<i>Myricaria longifolia (Willd.)</i>		Ховор	Улаанбаатар, Туул голын эргээс	П.Цэрэннадмид, 1984
XVII. Rosaceae Juss.					
34	<i>Amygdalus mongolica Maxim.</i>		Ховор	Говь-Алтай аймаг	П.Цэрэннадмид, 1988
35	<i>Sorbaria sorbifolia (L.) A.Br.</i>		Нэн ховор	Дарханы УГТЭШХ	Д.Чанцалням, 2004
36	<i>Rosa laxa Retz.</i>		Нэн ховор	ОХУ-ын Лукцийн Ботаник цэцэрлэг	П.Цэрэннадмид, 1988
37	<i>R. Beggeriana Schrenk.</i>		Ховор	Москва, ЕБЦ	П.Цэрэннадмид, 1988
38	<i>R. Platyacantha Schrenk.</i>		Ховор	Зүүнгарын говь	П.Цэрэннадмид, 1980
39	<i>Crataegus sanguinea Pall.</i>		Ховор	Сэлэнгэ аймаг, Хүдэр	Д.Чанцалням, 2000
40	<i>Malus baccata (L.)</i>		Ховор	Улаанбаатар, Туул голын эргээс	П.Цэрэннадмид, 1976
XVIII. Fabaceae DC.					

41	<i>Caragana spinosa</i> (L.)		Ховор	Ховд аймаг	П.Цэрэннадмид, 1977
42	<i>Halimodendron halodendron</i> (Smith)		Нэн ховор	Дорноговь аймаг, Сайншанд	П.Цэрэннадмид, 1976
XIX. <i>Elaeagnaceae</i> Juss.					
43	<i>Elaeagnus moorcroftii</i> Wall. Ex Schlecht.		Нэн ховор	Өмнөговь аймаг, Булган сум	Д.Чанцалням, 1987
XX. <i>Ericaceae</i> Juss.					
44	<i>Rhododendron dauricum</i> L.	<input type="checkbox"/>	Нэн ховор	Улаанбаатар, Тэрэлжийн уулнаас	П.Цэрэннадмид, 1981
45	<i>Rh. ledebourii</i> Pojark.	<input type="checkbox"/>	Нэн ховор	Хөвсгөл аймаг	П.Цэрэннадмид, 1981
XXI. <i>Verbenaceae</i> Jaume.					
46	<i>Caruopteris mongolica</i> Bunge.	<input type="checkbox"/>	Ховор	Сэлэнгэ аймаг, Баруунхараа	П.Цэрэннадмид, Д.Чанцалням, 1983
XXII. <i>Caprifoliaceae</i> Pall.					
47	<i>Sambucus manshurica</i> Kitag.	<input type="checkbox"/>	Нэн ховор	Төв аймаг, Богд-уул	П.Цэрэннадмид, 1978
48	<i>Lonicera altaica</i> Pall.	<input type="checkbox"/>	Ховор	Хангайн уулын тойрог	П.Цэрэннадмид, 1981
49	<i>Viburnum mongolicum</i> Pall.	<input type="checkbox"/>	Нэн ховор		П.Цэрэннадмид, 1981
XXIII. <i>Cornaceae</i> Dumort.					
50	<i>Cornus alba</i> (L.) Opiz.	<input type="checkbox"/>	Ховор	ОХУ-ын Улаан-Үд хот	П.Цэрэннадмид


- 1987 оны БНМАУ-ын Улаан номонд бүртгэгдсэн ургамал
- 1997 оны Монгол Улсын Улаан номонд бүртгэгдсэн ургамал
- Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ: үнэлгээ, өргөжүүлэх асуудал. 2002.
- “Байгалийн ургамлын тухай” Монгол улсын хуулийн хавсралт. 2004.

Ботаникийн цэцэрлэгийн өвслөг ургамлын цуглуулгын талбайд 2007 онд Монгол улсын 1997 оны Улаан номонд бүртгэгдсэн ховор, нэн ховор ургамлаас 8 овгийн 10 төрлийн 19 зүйл байсан бол 2009 оны байдлаар 28 зүйл болж, 9 зүйлээр нэмэгдэж (1-р зураг), байгалийн өвслөг ургамлын цуглуулгыг 1500 м² талбайд 3000 гаруй дээж бодгаль ургамлыг бүрдүүлсэн.

Үүний үр дүнд үр болон үржлийн материал, булцуу, үндэслэг ишээр үржүүлэх нөхцөл бүрдсэн юм.

Ботаникийн цэцэрлэгийн өвслөг ургамлын цуглуулгын талбайд тарималжуулж буй ховор ургамал 80-85%-ийн амьдралттай ургаж байна. Тухайлбал: *Allium altaicum* Pall., *A. obliquum* L., *A. condensatum* Turcz., *Rhodiola rosea* L., *Adonis mongolica* Simon., *Paeonia anomala* L., *P. lactiflora* Pall., *Lilium buschianum* Lodd., *L. dauricum* Ker-Gawl., *Tulipa uniflora* (L.) Bess. зэрэг ховор зүйлүүд нь цэцэглэн үрлэж, үрийн гарцыг судлах боломж бүрдсэн.

1-р зураг. Ботаникийн цэцэрлэг дэх ховор, ховордсон өвслөг ургамлын зүйлийн бүрдэл



Бид цуглуулгын талбайд ганц хоёр ширхэг бодгалиар ургаж байсан эх ургамлуудыг олшруулан үржүүлэхээр нэн ховор, ховор ургамал болох байгалийн 2 зүйлийн Цээнийг үндэслэг ишний сэргэн ургах нахианы хэсгээр болон үрээр, Ганццэцэгт Алтанзул, Алтайн Сонгиныг сонгинолог булцуугаар, Бушийн ба Дагуур Сарааныг сонгинолог булцуу болон булцууны хайрсаар Төвд Баягзавааг үндэслэг ишээр нь салгаж үржүүлэхэд эдгээр зүйлүүд 90% ийн амьдралтай ургаж байна.

Дүгнэлт

Ботаникийн цэцэрлэгийн цуглуулга үржүүлгийн талбайд ховор, нэн ховор ургамал 2009 оны байдлаар 23 овог 35 төрөл 50 зүйл цуглуулгатай болсон. Үүнээс мод, сөөг 10 овог 19 төрөл 22 зүйл, өвслөг ургамал 13 овог 16 төрөл 28 зүйл байна. Ховор, нэн ховор ургамлын амьд цуглуулгыг in situ хэлбэрээр хадгалснаар эх ургамлаас үр, булцуу, үндэслэг ишээр үржүүлэн олшруулах боломжтой болов.

Талархал

Ботаникийн цэцэрлэгт ховор ургамлын цуглуулга бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан доктор (Sc.D) Г.Цэрэнбалжид, С.Лхагвасүрэн, Г.Очирбат, Б.Буянчимэг, Ч.Доржсүрэн, дэд доктор Г.Цэдэндаш, С.Бямбасүрэн нарт талархалаа илэрхийлж байна.

Ном зохиол

- Байгаль орчин, аялал жуулчлалын хуулийн эмхтгэл. УБ.: 2009.146-р тал.
- Монгол Улсын Улаан ном .УБ.: 1997. 234-236-р тал.
- Өлзийхутаг Н. Монгол орны ургамлын аймгийн тойм. УБ.:1989.161-170-р тал
- Эрдэнэжав Г. Ботаник ургамлын аж ахуйн судалгааны үр дүн ба хэтийн төлөв. УБ.: 2005.174-180-р тал.

SUMMARY

THE RARE PLANTS OF COLLECTION IN THE BOTANICAL GARDEN OF MAS

N.Ochgerel¹, L.Enkhtuya¹

¹Institute of Botany MAS, Ulaanbaatar, Mongolia

Key words: rare, very rare plants

The collection of rare and endangered trees, bushes and herbal plants 50 species that belong to 35 genus of 23 families in Botanical Garden of the Institute of Botany, Mongolian Academy of Sciences.

БОТАНИКИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТАЙЛБАР

Л.Жаргалсайхан, Г.Цэдэндаш

ШУА, Ботаникийн хүрээлэн

Бэлгэ тэмдэг буюу лого гэдэг нь байгууллагын таних тэмдэг болдог учир тухайн газрын онцлог, үйл ажиллагааны чиглэл, зорилгыг тусгасан байх шаардлагатай. Бид Ботаникийн хүрээлэнгийн бэлгэ тэмдгийг анх 1980-аад оны дундуур бүтээсэн бөгөөд, 1990-ээд оноос ажилтнуудын нэрийн хуудас, Монгол-Оросын хамтарсан биологийн иж бүрэн экспедици болон хүрээлэнгийн эрдмийн хурлын урилга, эмхтгэлийн хавтсан дээр тавигдах болсон ба 2009 онд Ботаникийн хүрээлэнгийн 35 жилийн ойн дурсгалын энгэрийн тэмдгийг энэ бэлгэ тэмдгээр хийсэн билээ. Гэвч хоёр талдаа сул зай ихтэй, ургамлын дүрс хамгаалалтгүй мэт болсон тухай саналыг хүлээн авч 2010 онд нэмэлт, засвар орууллаа (9).

Бэлгэ тэмдгийн утга учир, агуулгыг тайлбарлан хэвлүүлэхээр бэлтгэв.

Бэлгэ тэмдгийн хүрээ нь мөнх тэнгэр болон амьдралыг тэтгэгч усыг төлөөлүүлсэн цэнхэр өнгөтэй, номын хүрээлэн гэсэн утга илэрхийлэх дэлгэсэн номын хэлбэртэй, дэвсгэр нь номын цагаан буяныг бэлгэдсэн цагаан өнгөтэй (1), дээд төвд Монгол улсын шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний төв удирдах байгууллага болох “Шинжлэх ухааны академи” гэсэн үгийг товчилж (ШУА) гэж цэнхэр өнгөөр кирилл үсгээр бичсэн (2). Ботаникийн хүрээлэн гэдэг нэрийг бор шаргал өнгөөр (3) кирилл, ногоон өнгөөр эвхмэл монгол бичгээр (4) үзүүлсэн. Төвд нь англиар Mongolia, Institute of Botany гэдэг үгийг товчилж <<M, I, B>> гэсэн 3 үсгийг залган ургамлын дүрс үүсгэн, ургамлын үржлийн шадар эрхтнүүд (цэцэг, дохиур, үр болосрох орон) болон навчийг төлөөлүүлэн дүрслэсэн (5, 6, 7, 8) нь арга билигийн чанартай, үргэлж үржиж, ургаж, дэвжиж байхыг бэлгэдсэн болно.

Бүх дүрслэлийг тусгайлан авч үзвэл:

1. Хүрээ, дэвсгэр



2. ШУА

ШУА

3. Ботаникийн хүрээлэн

БОТАНИКИЙН ХҮРЭЭЛЭН

4. Ботаникийн хүрээлэн



5. Ургамлын дүрс, цэцэг



6. М үсэг буюу навч



7. I үсэг буюу үр боловсрох орон



8. B үсэг буюу дохиур



9. Бүтэн бэлгэ тэмдэг



Ботаникийн хүрээлэнгийн эрдмийн хамт олны хэн нь ч хүрээлэнгийнхээ бэлгэ тэмдгийн утга учрыг мэддэг, тайлбарлаж чаддаг, хүрээлэн маань үеийн үед өргөжин дэвжиж байхын ерөөл өргье.